

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ  
/2024 оны жилийн эцсийн байдлаар/

2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр

Эрдэнэт хот

№	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн, хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
									Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төг)		
1	2	3	4	5		6	7	8	9	10	11	12	13
<b>НЭГ.ЭРҮҮЛ МЭНД, БИЕЙН ТАМИР, ЧИЙРЭГЖҮҮЛЭЛТИЙН БОДЛОГО</b>													
<b>ЭРҮҮЛ МЭНД</b>													
1	1.1Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулж, нотолгоонд суурилсан эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.	Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж, үр нөлөөг дээшлүүлэн ажиллах	2021-2024	ЭМГ	ЭМБ	Улс болон олон улсын төсөл хөтөлбөр	133.0	Хөтөлбөр үүдийн хэрэгжилтийн дундаж 83%	Хэрэгжилтийн хувь 86.5%-д хүрсэн байна.	30.0	2021-2023 онд орон нутгийн төсөв 4400,0 2024 онд 281.0	Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Эрүүл мэндийн сайдын тушаалаар 10 арга хэмжээний төлөвлөгөө батлагдаж хэрэгжилт 2021 онд 84.5 хувь, 2022 онд 83.8 хувь, 2023 онд 88.1, 2024 онд 88.3 хувийн хэрэгжилттэй байгаа нь суурь үзүүлэлтээс 5.3 хувиар нэмэгдсэн байна. 2024 онд тус арга хэмжээнүүдийн хүрээнд: Арга хэмжээний төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт 231926 буюу нийт үзлэгийн 35.0 хувьд урьдчилан сэргийлэх үзлэг хийгдсэн. Урьдчилан сэргийлэх үзлэгт хүн амын 59706 хүн буюу 56.2 % нь хамрагдсан байна. Хүүхдийн үзлэгт 33671 хүүхэд хамрагдаж 88.7%, 18-аас дээш насны 26035 хүн хамрагдсан нь хамруулахаар төлөвлөсөн хүн амын 37.9% нь хамрагдсан байна. - Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр гарсан холбогдох тушаал шийдвэрийн хэрэгжилтэд 17 удаагийн хяналтыг хийж, зөвлөмж өгч ажилласнаар тушаал шийдвэрийн хэрэгжилт дунджаар 85%-тай байна. - Тайлант хугацаанд 26 удаагийн өдөрлөг, аян, форум, 235 удаагийн сургалт сурталчилгаанд давхардсан тоогоор 37499 иргэнийг хамруулж, 55 төрлийн сурталчилгааны материалыг 9471 иргэнд түгээж, 40 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн 5 телевизтэй хамтран бэлтгэж иргэдэд хүргэсэн. - 2021-2023 онуудад арга хэмжээнүүдийн хүрээнд орон нутгаас төсөл хөтөлбөрийн	100%

												хүрээнд 1.3 тэрбум, ковид-19 халдварын эсрэг хариу арга хэмжээнд 3.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн ба 2024 онд нийгмийн эрүүл мэндийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд нийт 281.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгуулан хэрэгжүүлсэн.	
2		Хүн амын дунд эрүүл мэндийн суурь судалгааг хийж, түүнд түшиглэсэн эрүүл мэндийг дэмжих бодлого боловсруулан хэрэгжүүлэх	2022	ЭМГ	Аймгийн ЗДТГ ЭМБ	Олон улсын төсөл хөтөлбөр орон нутгийн төсөв	50.0	Суурь судалгааны тоо, үр дүн-1	Тандалт судалгаанд хүн амын 1%-ийг хамруулсан байна.	-	-	Эрдэм шинжилгээний бага хурлыг жил тутам зохион байгуулж ирсэн бөгөөд 2021-2023 онд 96 илтгэл хэлэлцүүлснээс улсын хэмжээнд 2 илтгэл хэлэлцүүлэгдэж, 3 суурь судалгаа хийгдсэн. 2024 онд эрдэм шинжилгээний бага хурлаар 32 илтгэл хэлэлцүүлэгдэж 106 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж олон улсын хэмжээнд 5 илтгэл, улсын хэмжээнд 11 илтгэл хэлэлцүүлэгдсэн. Нийт 5 суурь судалгаа хийгдсэн. Үүнд: - Орхон аймгийн томуу, томуу төст өвчний лабораторид суурилсан тандалтаар эерэг илэрсэн тохиолдлын дархлаажуулалтын байдлын судалгаа - Ундны усны эрүүл ахуйн мэдлэгийн түвшин тогтоох судалгааг 4 багийн 200 хүнийг хамруулж хийж дүгнэхэд мэдлэгийн түвшин 49.3% буюу бага байгаа нь судалгаанаас харагдаж байна. - 14 байгууллагын 847 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан албан хаагчдын бие бялдрын түвшин тогтоох сорилоор А үнэлгээтэй 33.2% , В үнэлгээтэй 30.8 % , С үнэлгээтэй 26.2%, D үнэлгээтэй 7,4%, F үнэлгээтэй 2,2% байна. Бие бялдрын судалгаанаас D, F үнэлгээтэй 82 эмч эмнэлгийн мэргэжилтэнд эрүүл мэндийн боловсрол олгож, ажлын байрны дасгал хөдөлгөөнийг хэвшүүлэх арга хэмжээ зохион байгууллаа. - -Архи тамхины хэрэглээний хамаарлын судалгааг Эрдэнэт үйлдвэрийн 800 ажилчин албан хаагчдаас авч боловсруулалтын үе шатандаа явагдаж байна. - Амны хөндийн эрүүл мэндийн мэдлэг хандлага шалгах судалгааг 400 эцэг эх асран хамгаалагчаас авч дүгнэхэд асран хамгаалагчдад нас хүйс, харгалзахгүйгээр шүдний сойзны сонголт, угаах аргыг заах онол дадлага хосолсон эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг хийж мэдлэг, хандлага, дадлыг цогцоор нь сайжруулах шаардлагатай байна.	100%

3		“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд зорилтот бүлгүүдэд элэгний вирусийг эрт илрүүлж, өвчлөлийг бууруулах, эмчлэх ажлыг зохион байгуулах	2021-2024	ЭМГ	СӨЭМТ	Эрүүл мэндийг дэмжих сан Улс, Орон нутгийн төсөв олон улсын төсөл хөтөлбөр	120.0	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь 83.4%	Хөтөлбөрийг хэрэгжүүлж, шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан байна.	30.0	Улсын төсөв 50.0	<p>2020 онд “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд нийт 72205 иргэнийг хамруулахаас 52952 иргэнийг хамруулж хамралт 73.3 хувьтай улсад тэргүүлж нийт илрүүлэгт хамрагдсан иргэнээс 4129 хүн буюу 7.8 хувьд нь С вирус, 3825 хүн буюу 7.2 хувьд нь В вирус илэрч, 64.3 хувь нь баталгаажуулах шинжилгээнд хамрагдан вирусийн эсрэг эмчилгээнд 1326 хүн хамрагдаж эдгэрсэн үр дүнтэй хэрэгжиж дууссан.</p> <p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/577 дугаар тушаалаар батлагдсан “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.</p> <p>2024 оны байдлаар элэгний В вирус илрүүлэх шинжилгээнд 3427 иргэн хамрагдсанаас 28 хүн буюу 1.8%, С вирус илрүүлэх шинжилгээнд 3390 иргэн хамрагдсанаас 24 буюу 1.5% нь эерэг илэрсэн байна.</p> <p>Монголын тархвар, халдвар судлаач эмч нарын нийгэмлэгтэй хамтран халдварын хяналт сэргийлэлтийн сургалтад Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон Үсчин, гоо сайхны холбооны гишүүн нийт 115 хүнийг хамруулсан. Мөн Шүдний мэргэжилтний холбоотой хамтран шүдний эмч, сувилагч, туслах сувилагч, үйлчлэгч нарт сургалт зохион байгуулж 60 эмч, мэргэжилтэн хамрагдсан.</p> <p>БОЭТ-ийн Лабораторийн нэгдсэн тасагт В вирусийн эсрэг вакцины дархлаа тогтцын шинжилгээг шинээр нэвтрүүлэн уг шинжилгээнд Эрүүл мэндийн салбарын 200 эмч, ажилтан хамрагдсанаас 71 эмч эмнэлгийн мэргэжилтний дархлал тогтоц 100мл/IU-ээс доош гарсан байна.</p> <p>Нярайн төрсний дараа 24 цагийн дотор гепатитын В вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралт 99.7%, 2 настай хүүхдийн А вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралт 99.9 хувьтай байна. Гепатит В вирусийн халдвартай эхээс төрсөн 1 нярайг 12 цагийн дотор вакцинд хамруулсан. В вирусийн эсрэг сайн дурын дархлаажуулалтад 1335 иргэн хамрагдсан. Халдварын сэргийлэлт хяналтыг сайжруулах, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх сургалтад эмч, эмнэлгийн мэргэжилтний 26.4%-ийг хамруулсан</p>	84.0%
---	--	--	-----------	-----	-------	--	-------	-------------------------------------	---	------	------------------	--	-------

											байна. Аймгийн хэмжээнд Д вирустэй оношлогдсон 290 иргэнийг идэвхтэй хяналтад хянаж, хавдрын илрүүлэг шинжилгээнд улирал тутамд хамруулан ажилласан.  2024 онд вируст гепатитын 3 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 0.28 промилл, элэгний хорт хавдрын нас баралт 48 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 4.6 промилл байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.7 промиллоор, элэгний хатуурлын нас баралтын 17 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 1.6 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.6 промиллоор тус тус өссөн байна. “Элэг бүтэн Монгол” төлөвлөгөөний хэрэгжилт 84.0% -тай байна байна.		
4		Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг (хөх, умай, чихрийн шижин, цусны даралт ихсэх) үзлэгийг эрчимжүүлэх	2021-2024	ЭМГ	ЭМБ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр Орон нутгийн төсөв	45.0	Эрт илрүүлэг 60.4%	Эрт илрүүлэг 2%-иар нэмэгдүүлсэн байна.	15.0	-	Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг /хөх, умай, чихрийн шижин, цусны даралт ихсэх/ үзлэгийн хамралт 2020 онд 64,1%, 2021 онд 62.8%, 2022 онд 40.5 %, 2023 онд 89.5%-тай байна. 2024 онд халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг 82.4 хувь буюу өмнөх оны мөн үеэс 7.3 хувиар буурсан байна. Үүнд: - Артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт нийт 18-аас дээш насны нийт 43285 буюу хамрагдвал зохих хүн амын 85.4 хувийг эзэлж, өмнөх оноос 6.8 хувиар нэмэгдэж үр дүнгийн үзүүлэлтээр 0.7 хувь нь онош батлагдсан. - Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт 18-аас дээш насны нийт 39328 буюу хамрагдвал зохих хүн амын 77.6 хувийг эзэлж, өмнөх оноос 22.7 хувиар буурч, үр дүнгийн үзүүлэлтээр 0.3 хувь онош батлагдсан. - Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 3354 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 84.4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар буурсан. Пап шинжилгээнд нийт 1645 сорьц хүлээн авсан байна. - Хөхний эрт илрүүлэг үзлэгт 17285 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 83.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар нэмэгдсэн байна. - Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 1214 хүн буюу хамрагдвал зохих хүн амын 69.5 хувь нь хамрагдсан.	100%

												Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, өвчлөлөөс сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн сургагч багш бэлтгэх сургалтад 170 идэвхтэн иргэд, сурагч, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, эрүүл мэндийн салбарын 170 эмч эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах сургалтад хамруулсан. Иргэдэд эрүүл мэндийн боловсролыг олгохоор 11 төрлийн зөвлөмжийг 780 иргэнд түгээж, цахимд 116 төрлийн шторк, зөвлөмжийг байршуулан давхардсан тоогоор 156395 иргэнд хүргэж, 6 удаагийн өдөрлөг зохион байгуулж 14468 хүнийг хамруулж ажилласан.	
5		Хорт хавдартай иргэдийн эмийн болон эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх	2021-2024	Аймгийн ЗДТГ ЭМГ	БОЭТ	Орон нутгийн төсөв	280.0	Дэмжлэгт хамрагдсан хувь 16.8%	Дэмжлэгт хамрагдсан хувь 17.4%-д хүрсэн байна.	70.0	2021-2023 онд орон нутгийн төсөв 199.6  2024 орон нутгийн төсөв 84.1	Хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэхээр орон нутгийн төсвөөс 2021 онд 128 иргэнд 60.0 сая төгрөг, 2022 онд 177 иргэнд 69.8 сая төгрөг, 2023 онд 162 иргэнд 69.8 сая төгрөгийг тус тус олгосон байна. 2024 онд хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэхээр орон нутгийн төсөвт 100.0 сая төгрөгийг баталснаас одоогийн байдлаар 154 иргэнд 84.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн ба шинээр батлагдсан тохиолдлын 80.2 хувь нь эмийн болон эмчилгээний дэмжлэгт хамрагдсан байна.	100%
6		"Эрүүл хамт олон" ажлын байранд эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөн өрнүүлж, жил бүр шалгаруулан сайн туршлагыг нийтийн хүртээл болгон урамшуулах	2021-2024	Аймгийн ЗДТГ ЭМГ	ТББ	Орон нутгийн төсөв	24.0	ЭМДБ-ын тоо 66	0.5%-иар нэмэгдсэн байна.	6.0	2021-2023 онд Орон нутгийн төсөв 22.0  2024 онд Орон нутгийн төсөв 6.0	Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөнийг өрнүүлэн ажилласны дүнд 2021 онд 2 байгууллага, 2022 онд 2 байгууллага, 2023 онд 5 байгууллага, 2024 онд 5 байгууллага Эрүүл мэндийг дэмжигч байгууллага болсон. 2024 онд ажлын байранд эрүүл мэндийг дэмжих аяны хүрээнд 3 арга хэмжээ хамтран зохион байгууллаа. Үүнд: - "Энэ жилдээ Эрүүл жиндээ-2", "Хичээллээ-Өрнүүлье-Хөгжүүлье" аяны хүрээнд Биеийн тамир спортын газартай хамтран "Ажлын байрны дасгал хөдөлгөөн" 2 сарын цахим уралдааныг зохион байгуулж, 33 байгууллагын давхардсан тоогоор 7384 ажилтан албан хаагчийг хамруулан, уралдаанд идэвх санаачилга гаргасан 5 байгууллагыг шагнаж урамшууллаа. - Төрийн болон төрийн бус 16 байгууллагыг хамруулсан явган алхалтад 800 хүнийг хамруулсан. - Эрдэнэт үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн албатай хамтран 33 цехийн	100%

											<p>дарга, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хариуцсан 66 хүнд ажлын байранд эрүүл мэндийг дэмжих чиглэлээр сургалт зохион байгуулсан.</p> <p>- Төрийн байгууллага, албан хаагчдад сар бүрийн эхний 7 хоногт ажлын байр дээр эрүүл мэндээ хэрхэн хамгаалах сургалт зохион байгуулж нийт 1180 албан хаагчийг хамруулсан.</p> <p>- Аймгийн хэмжээнд Эрүүл мэндийг дэмжигч 86 байгууллага байгаагаас боловсролын салбарын 45, эрүүл мэндийн салбарын 14, үйлдвэр аж ахуйн нэгж 17, бусад 10 байгууллага байна.</p> <p>Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих зорилгоор 2021-2023 онд орон нутгийн төсвөөс 22.0 сая төгрөг, 2024 онд 6.0 сая төгрөгийг шийдүүлэн ажилласан.</p>		
7	1.2.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар сэргийлж болох өвчлөл, нас баралтыг бууруулна	БОЭТ-ийн харьяа Эрүүл мэндийг дэмжих төвийг байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулах	2021-2024	Аймгийн ЗДТГ ЭМГ БОЭТ	ЭМБ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр	400.0	-	Үйл ажиллагаа тогтмолжсон байна.	-	<p>БОЭТ-ийн харьяа Эрүүл мэндийг дэмжих төв нь нийт 320 м2 талбай бүхий стандартын шаардлага хангасан байранд үйлчлүүлэгчдэд эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэн тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Тус төв нь байгуулагдсанаас хойш нийт 16237 иргэнийг эрт илрүүлэг үзлэгт хамруулснаас 18-30 насанд 2494, 31-45 насанд 4705, 46-60 насанд 5942, 61-аас дээш насанд 3096 иргэн хамрагдсан байна. Тайлант хугацаанд урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт 4689 иргэн хамрагдсанаас 18-30 насанд 420, 31-45 насанд 1631, 46-60 насанд 1819, 61-с дээш насанд 819 иргэн тус тус хамрагдсан байна.</p> <p>Өвчлөлийн 12795 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнээс 3968 буюу 34% нь хоол боловсруулах тогтолцооны өвчин, 3040 буюу 26% нь дотоод шүүрэл тэжээлийн ба бодисын солилцооны өвчин, 1021 буюу 8.7% нь шээс бэлгийн тогтолцооны өвчин, 2935 буюу 25.1% нь зүрх судасны тогтолцооны өвчин, 169 буюу 1.4% нь амьсгалын тогтолцооны өвчлөл бүртгэгдсэн нь тэргүүлэх шалтгаан болж нийт өвчлөлийн сэжигтэй тохиолдлын 95.2% эзэлж байна.</p>	100%	
8	1.2.1.Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн менежментийг	Тархины харвалт, шигдээсийн чиглэлээр шинэ дэвшилтэт	2021-2024	ЭМГ БОЭТ	Аймгийн ЗДТГ	Улс болон орон нутгийн төсөв	380.0	-	Тархины харвалт, шигдээсийн чиглэлээр	50.0	2021-2023 онд орон нутгийн төсөв	Аймгийн хүн амын нас баралтын зонхилох шалтгаан болох харвалт, шигдээсийн үеийн тусламж үйлчилгээг чадавхжуулах хүрээнд 2022 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвд	100%

	сайжруулж, оношилгоо, эмчилгээний тусламж үйлчилгээ үзүүлэх чадавхыг нэмэгдүүлж, иргэд орон нутагтаа эмчлүүлэх боломжийг бүрдүүлэн шинэ дэвшилтэт технологийг нутагшуулна.	технологийг нутагшуулах						шинэ дэвшилтэт технологи нэвтэрч үйл ажиллагаа тогтмолжсон байна.		126.5 Улсын төсөв 3000.0 2024 онд БОЭТ гүйцэтгэлийн санхүүжилт 67.8	мэдрэлийн тасагт 2 ор, эрчимт эмчилгээний тасагт 2 ор, дотрын тасагт тархины харвалтын нэгж байгуулж, 1 эмч, 1 сувилагч сургагдаж бэлтгэгдсэн. Судсан дотуурх оношилгоо эмчилгээг 2021-2023 онд 490 хүнд, 2024 онд 141 хүнд, нийт 631 хүнд хийгдсэнээс 275 хүн буюу 43.6% нь стент тавиулсан байна. Эрүүл мэндийн даатгалаас тус өндөр өртөгт хагалгааны зардалд нэг иргэнд 4.9 сая төгрөгийг төлж байна. Тархины харвалт, шигдээсийн чиглэлээр шинэ дэвшилтэт технологийг нутагшуулах хүрээнд 2021-2023 онд орон нутгийн төсвөөс бүлэн хайлуулах РЭПИ/актилизе/-р хангах 113.0 сая төгрөг, ЭМЯ-ны 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 32 зүслэг бүхий Siemens үйлдвэрийн КТГ-ийн аппарат, ерөөний засварын төсөв, 1.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Siemens брэндийн Artis Zee Floor загварын моноплан ангиографийн аппарат суурилуулж аппарат суурилуулсан орон нутгийн төсвийн 13.5 сая төгрөгөөр аппаратын хэвийн үйл ажиллагааг хангах хүчилтгэл, кабелийн шугамын асуудлыг шийдвэрлэсэн. 2024 онд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн гүйцэтгэлийн санхүүжилтээр 6 флакон РЭПИ/актилизе/-д 20,6 сая төгрөгийг зарцуулсан байна. Тайлант хугацаанд тархины цус харвалтын шалтгаант нас баралт 1,1 промилл болж өмнөх оны мөн үеэс 0.7 промиллоор, зүрхний шигдээсийн шалтгаант нас баралт 1.6 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.5 промиллоор тус тус буурсан байна Тайлант хугацаанд Тархины цус харвалтын шалтгаант нас баралт 1,1 промилл болж өмнөх оны мөн үеэс 0.5 промиллоор, зүрхний шигдээсийн шалтгаант нас баралт 1.4 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.5 промиллоор тус тус буурсан байна.	
9	1.2.2.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, эмнэл зүй, эм зүйн тусламж үйлчилгээг	Эм зүйн салбарын ил тод хариуцлагатай байдлыг бэхжүүлж, стандартын хэрэгжилтийг хангуулан,	2021-2024	ЭМГ	Эм ханган нийлүүлэх байгууллага	-	-	Эм ханган нийлүүлэх байгууллага эмийн сангуудын стандартын хэрэгжилт	-	-	Аймгийн хэмжээнд нийтийн үйлчилгээтэй 77 эмийн сан, 8 эм ханган нийлүүлэх байгууллага иргэдэд үйлчлэн ажилласан. 2024 онд эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоогүй бөгөөд 1 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг цуцлан, 4 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг 1 сарын хугацаатай түдгэлзүүлсэн байна. Эмийн зохистой хэрэглээний 10	98.2%

	хөгжүүлэх, нянгийн тэсвэржилтийг судалж, антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн хяналтыг сайжруулна.	тогтвортой үйл ажиллагааг дэмжих			Эмийн сан Эм холбоо			хэрэгжилт 88%	ийг 98%-д хүрсэн байна.			хоногийн хүрээнд 40 эмч, эм зүйчийг сургалтад хамруулж, иргэдэд хандсан сургалт сурталчилгааг эрчимжүүлэн ажилласан. Сэтгэцэд нөлөөт эмийн 3938 ширхэг жорыг 11 байгууллагад, мансууруулах эмийн жорыг 8 байгууллагад 1257 ширхгийг тус тус дугаарлан олгосон. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх эмийн сангуудыг ЭМГ-ын даргын 2024 оны А/25 тоот тушаалаар шинэчлэн баталсан. Эм ханган нийлүүлэх байгууллага болон эмийн сангуудын стандартын хэрэгжилт дунджаар 96.2 хувь байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 1.1 хувиар нэмэгдсэн байна. Үүнд: - “Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015 стандарт”-аар хяналт хийхэд 94.9%-тай үнэлгээтэй гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад стандартын хэрэгжилт 1.1%-аар сайжирсан байна. Эм ханган нийлүүлэх байгууллагын стандартын шаардлага 97.5%-тай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад стандартын хэрэгжилт 0.5%-аар сайжирсан байна.	
10		Эмнэл зүйн эм зүйн тусламжийг эмнэлгийн тусламж үйлчилгээний шатлалд тохируулан нэвтрүүлэх	2021-2024	ЭМГ	Эм ханган нийлүүлэх байгууллага Эмийн сан Эм холбоо	Улс болон орон нутгийн төсөв	-	Эмнэл зүйн эм зүйн тусламж үйлчилгээ 2 эмнэл зүйн эм зүйч ажиллуулах	Эмнэл зүйн тусламж, үйлчилгээ сайжирсан аар эмийн эмчилгээн ий үр дүн нэмэгдсэн байна.	-	-	Эмнэл зүйн тусламж үйлчилгээний хэрэгжилт 2021 онд 81.2%, 2022 онд 81.8%, 2023 онд 82.1 хувьтай байсан. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 132 эм зүйч, 116 эм найруулагч ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад эм зүйч 4 хувь, эм найруулагч 0,87 хувиар тус тус нэмэгдсэн байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 6 клиник эм зүйч, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад 11 клиник эм зүйч ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.7%-аар нэмэгдсэн байна. Эмнэл зүйн эм зүйн тусламж үйлчилгээнд хяналт хийхэд нийт өвчтөний 49.6-58.2 хувьд тарилгыг хийж, 41.8-50.4 хувьд уухаар эмийг өгсөн байгаа нь өмнөх онтой харьцуулахад эмийг тарилгын хэлбэрээр хэрэглэх явдал 2.2 хувиар буурч, ууж хэрэглэх эмийн хувь 6.8-9.0 хувиар нэмэгдсэн, зонхилон тохиолдох эмгэгийн оношилгоо, эмчилгээний удирдамжийн хэрэгжилт 87.2 хувь болж 3.1 хувиар нэмэгдсэн, эмийн зохистой хэрэглээ алдагдал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.5 хувиар буурсан байна.	85.2%



												Эмнэл зүйн тусламж үйлчилгээний хэрэгжилт 2024 онд 85.2 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 2.1%-аар нэмэгдсэн байна.	
11	1.2.3.Төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, үйлчлүүлэгчийг нэг дороос бүх төрлийн тусламжийг авах нөхцөлийг бүрдүүлсэн төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлнэ.	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг бүх талаар дэмжиж, зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх	2021-2024	Аймгийн ЗДТГ ЭМГ	ХХЭМБ	Орон нутгийн төсөв	92.0	Төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллагын тоо 1	Гэрээт үйлчилгээг 1-ээр нэмэгдүүлсэн байна.	25.0	Орон нутгийн төсөв 30.0	2020-2023 онд суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх, гэр сувиллыг гэрээгээр гүйцэтгүүлэн орон нутгийн төсвөөс 70.0 сая төгрөгийг шийдвэрлэж суурь эмгэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй 400 хүүхдийг хамруулсан. 2024 онд хувийн хэвшлийн 1 нэгдсэн эмнэлэг, 11 ор бүхий клиниктэй аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газар хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллалаа. Тайлант хугацаанд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд 45074 үзлэг хийсэн нь аймгийн хэмжээнд хийгдсэн нийт үзлэгийн 7.7%-ийг, 14567 иргэнийг хэвтүүлэн эмчилсэн нь нийт эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчийн 53.2%-ийг эзэлж, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн ачааллыг хуваалцсан байна. Хувийн хэвшлийн эмнэлгүүдэд өдрийн эмчилгээний 171 оронд нийт 880 иргэнийг хамруулсан байна. Хувийн хэвшлийн төрөлжсөн эмнэлэг 1, хүүхдийн 4 клиник томуу томуу төст өвчний үеийн тусламж үйлчилгээний ачаалал, хүлээгдлийг бууруулах чиглэлээр гэрээний дагуу уртасгасан цагийн зохицуулалт хийж хамтран ажиллалаа. Суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх, гэр сувиллыг гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг жил бүр зохион байгуулж ирсэн ба 2024 онд орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөгийг шийдвэрлэснээр Бүжинлхам хувийн хэвшлийн хүүхдийн клиниктэй гэрээ байгуулан ажиллаж сульдаа, уураг илчлэгийн дутагдал, цус багадалт зэрэг суурь эмгэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй 100 хүүхдийг нар ус агаараар чийрэгжүүлэх зуны сувилалд хамруулсан. Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулахад 6 хувийн хэвшлийн нөхөн үржихүйн клиниктэй гэрээ байгуулан 16-49 насны 942 эмэгтэйг үзлэгт хамруулан 38.5 хувийг бүрэн эмчлэн эрүүлжүүлэн, лавлагаа шатлалд 374 эмэгтэйг илгээсэн байна.	100%
12		Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний	2021-2024	Хувийн хэвшл	Аймгийн ЗДТГ	Олон улсын төсөл	-	Төрөлжсөн мэргэшли	Нарийн мэргэшил эзэмшсэн	-	-	Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт Медикал, Баян-Өндөр мед эмнэлэг, хувийн хэвшлийн эрүүл мэндийн ор бүхий клиникүүд	100%

		хэрэгцээг тодорхойлж, төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг дэмжих		ийн байгууллагууд	ЭМГ	хөтөлбөр Орон нутгийн төсөв Төр, Хувийн хэвшлийн түншлэл		йн тусламж үйлчилгээг үзүүлж буй байгууллага-2	эмчийн хангалтыг 1% -иар нэмэгдүүлэх .			төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажилласан ба хүний нөөцийн хангалт 90 хувь болж 2020 оноос 0.3 хувиар, өмнөх оноос 0.1 хувиар нэмэгдсэн. Хувийн хэвшлийн ор бүхий 8 клиник амбулатори, 171 оронд өдрийн эмчилгээ хийж үйлчилсэн. Сум, 8 өрхийн эрүүл мэндийн төв нь өдрийн эмчилгээний гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын санхүүжилт авч дотор, мэдрэлийн чиглэлээр лавлагаа шатлалын эмнэлгүүдийн хэвтэн эмчлүүлэх ачааллыг бууруулж ажилласан. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын оношилгооны чадавх 91.0 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.0 хувиар нэмэгдсэн. Үйлчлэх хүрээний хүн амын тоо, шилжилт хөдөлгөөн, өвчлөл, нас баралтын шалтгаан, эрүүл мэндийн байгууллагуудын хүчин чадал, эмнэлгийн ор ашиглалт зэргийг харгалзан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээг тодорхойлоход дотор, мэдрэл, уламжлалтын тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх эрэлт хэрэгцээ байна. Нэн шаардлагатай нарийн мэргэшлээр бөөрний мэс засал судлал 1 эмч, түлэнхийн нөхөн сэргээх мэс засал судлал 1, дотоод шүүрэл судлал 1, уушги судлал 1, мэдрэлийн мэс засал судлал 2, чих, хамар хоолойн мэс засал судлал 1, нийт 7 эмч суралцаж, төлөвлөлтийн дагуу нэн шаардлагатай нарийн мэргэжлийн эмчийн эзлэх хувь 91% болж өмнөх оноос 10 хувиар нэмэгдсэн.	
13	1.2.4.Хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, эх, хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийг бууруулна.	Өсвөр үе болон нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	ЭМГ	БОЭТ ХХЭМ Б		Улс болон орон нутгийн төсөв Олон улсын төсөл хөтөлбөр	47.0	Өсвөр үе болон нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн үзлэгт хамруулсан хувь 10%	Өсвөр үе болон нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн үзлэгт 20 хувийг хамруулсан байна.	15.0	Орон нутгийн төсөв 20.0	Өсвөр үе болон нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн үзлэгт 2021 онд нийт өсвөр үе, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 17.2%, 2022 онд 18.5%, 2023 онд 15.1%, 2024 онд 19%-ийг тус тус хамруулсан байна. Тайлант хугацаанд: - Эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр 9 албан тоот хүргүүлж, 2 удаагийн хяналт хийн зөвлөмж хүргүүлсэн. - Томуу, томуу төст өвчний тархалт идэвхжилийн түвшинд хүрч, хүүхдийн тасгийн ачаалал 2 дахин нэмэгдсэн тул 100 хүртэлх орыг нэмэлтээр дэлгэж, анхан шатлалд гэрийн эргэлтийг идэвхжүүлэн томуугийн салбар дундын ажлын хэсгийн 3 удаагийн хурлын	95%

												<p>шийдвэрийн хэрэгжилтийг 90.5% ханган ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тайлант хугацаанд бүртгэгдсэн амьгүй төрөлтийн 5, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 9, гэрийн төрөлтийн 2 тохиолдолд үзүүлсэн анхан болон 2 дахь шатлалын тусламж үйлчилгээг дүгнэн хэлэлцэж, нөлөөлсөн хожимдол, сургамж, зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.</li> <li>- Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан сургалтаар давхардсан тоогоор нийт 504 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулсан.</li> <li>- НҮБ-ын Хүүхдийн Сан, аймгийн ЗДТГ-тай хамтран хэрэгжүүлж байгаа стрептококкын скрининг үзлэгт 5400 гаруй хүүхдийг хамруулсан.</li> <li>- Хүчирхийлэлд өртсөн 5, жирэмсэлсэн 2 өсвөр насны охидын мэдээллийг Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн газар БОЭТ-тэй солилцож, эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлсэн.</li> <li>- Эрт илрүүлэг үзлэгт нийт 0-5 насны хүүхдийн 86.5 хувь, 6-17 насны хүүхдийн 92.0 хувь нь хамрагдсан.</li> <li>- Жирэмсний эрт үеийн хяналт 99.4 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1.0 хувиар нэмэгдсэн.</li> <li>- Нийт 1684 эх амаржсанаас 15-19 насны 51 тохиолдол буюу 3.0%-ийг охидын төрөлт эзэлж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,4%-аар нэмэгдсэн.</li> </ul> <p>Нялхсын эндэгдэл 1000 амьд төрөлтөд 10.2 промилл, өнгөрсөн оны мөн үеэс 1.1 промиллоор, нэмэгдэж, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөд 10.2 промилл, өмнөх оны мөн үеэс 0.4 промиллоор буурсан.</p>	
14		Жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг нэмэлт аминдэмд хамруулах	2021-2024	ЭМГ	БОЭТ СӨЭМ Т	Улсын төсөв Орон нутгийн төсөв олон улсын төсөл	23.0	Нийгмийн халамж шаардлагатай жирэмсэн хөхүүл эхийг аминдэмэ	Нийгмийн халамж шаардлагатай жирэмсэн хөхүүл эхчүүдийн 20%-ийг	6.5	2021-2023 онд Орон нутгийн төсөв 18.0  2024 онд Орон	<p>Нийгмийн халамж нэн шаардлагатай жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг аминдэмд хамруулахаар 2012 оноос орон нутгийн төсвөөс жил бүр санхүүжилтийг шийдвэрлэн хэрэгжилтийг зохион байгуулж ирсэн. 2021-2023 онд орон нутгийн төсвөөс нийт 18.0 сая төгрөг зарцуулан нийт 1767 эх аминдэмд хамрагдсанаас 50.5% нь цус багадалттай эх</p>	100%

					хөтөлбөр		эр хангасан хувь 10%	аминдэмэр хангасан байна.		нутгийн төсөв 10.0	хамрагдсан ба аминдэмжүүлэлтийн үр дүн 90%-тай бана. 2024 онд аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан 10.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн эмчилгээний зорилгоор 243, урьдчилан сэргийлэх тунгаар 644, нийт 887 жирэмсэн болон хөхүүл эхийг аминдэмжүүлсэн. Аминдэмжүүлэлтэд хамрагдсан нийт 887 эхээс 243 буюу 27.4 хувь нь цус багадалттай эх байгаа ба эх барихын хүндрэлгүй төрүүлсэн. Тайлант хугацаанд аминдэмд хамрагдах эхийн тоо өмнөх онтой харьцуулахад 1.2 дахин нэмэгдсэн буюу жирэмсэн, хөхүүл эхчүүдийн 33.3%-ийг хамруулсан.	
15	Нярайн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх	2021-2024	ЭМГ БОЭТ	Аймгийн ЗДТГ	Орон нутгийн төсөв	176.0	Нярайн эндэгдэлд эзлэх амьсгал хямралын хам шинжийн хувь 33.5%	Нярайн эндэгдэлд эзлэх амьсгал хямралын хам шинжийг 27.5% болгож бууруулна	44.0	2021-2023 онд орон нутгийн төсөв 99.5 ЭМД-аас гүйцэтгэлийн санхүүжилтээр 12.0 2024 онд ЭМД-аас гүйцэтгэлийн санхүүжилтээр 47.2	Орон нутагт нярайн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологи сурфактант эмчилгээг 2015 оноос эхлэн нэвтрүүлсэн. Тус эмчилгээнд 2021-2023 онд нийт 43 нярайд сурфактант эмчилгээг хийснээр 86.6 хүртэл хувийн үр дүнтэй байсан. 2024 онд Сурфактант эмчилгээг амьсгал хямралын хам шинжтэй, дутуу төрсөн 16 нярайд хийж 70 хувийн үр дүн өгсөн байна. Нярайн эндэгдэлд эзлэх амьсгал хямралын хам шинж 2021 онд 9.1%, 2023 онд 16.6 хувь байсан бол 2022 онд амьсгал хямралын хам шинжийн шалтгаант эндэгдэл бүртгэгдээгүй байна. 2024 оны байдлаар: - Сурфактант эмчилгээг амьсгал хямралын хам шинжтэй, дутуу төрсөн 18 нярайд хийж, 72.2 хувийн үр дүн өгсөн байна. - Нярайн тандалт скрининг шинжилгээнд төрсөн нярай бүрийг 100% хамруулж байгаа бөгөөд дутуу нярайн нүдний эвэрлэгийн эмгэг судасжилт илрүүлэх шинжилгээг 24 дутуу нярайд хийснээс 2 нярайд лавлагаа шатлалд илгээж, 6 нярайд хяналтад авсан байна. - Нярайн скрининг оношилгоо бодисын солилцооны 5 төрлийн эмгэг илрүүлэх шинжилгээг нийт 985 нярайд хийж, сорьцыг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд илгээсэн бөгөөд төрөлхийн бодисын солилцооны эмгэгийн тохиолдол илрээгүй байна. - Нийт 1355 нярайд түнхний үений скрининг оношилгоог хийснээс type A-12218 type B 13388 type C 2 оношлогдож дөрөөвч зүүж, 746	100%

											<p>нярайд давтан үзлэг хийж зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>- Нүдний угийн улаан рефлексийг төрсөн 305 нярайд хийсэн бөгөөд эмгэг илрээгүй байна. Нялхсын эндэгдэлд эзлэх нярайн эндэгдэл 66.6 хувь байгаагаас амьсгал хямралын хам шинжийн шалтгаант эндэгдэл 2 бүртгэгдсэн нь нийт нярайн эндэгдлийн 16.6 хувийг эзэлж байна.</p>		
16	1.2.5.Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудыг барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ.	БОЭТ-ийг орчин үеийн тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангах	2021-2024	Аймгийн ЗДТГ БОЭТ	ЭМГ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр	2.100.0	БОЭТ-ийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь 75%	Тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх	-	<p>2021-2023 онд Улсын төсөв 6.5 тэрбум</p> <p>Орон нутгийн төсөв 2.8 тэрбум</p> <p>Төсөл хөтөлбөр 423.7</p> <p>2024 он Орон нутгийн төсөв 629.6</p>	<p>2021 онд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн хангалт 90%, 2022 онд 92%, 2023 онд 92.5% 2024 оны байдлаар 96%-тай байна. Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь стандартын дагуу нэн шаардлагатай болон шаардлагатай 898 ширхэг багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан бөгөөд эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлсэн дэвшилтэт технологийн багаж тоног төхөөрөмжийн эзлэх хувь 20.1%-тай байна.</p> <p>БОЭТ-ийн амбулатори болон төрөх тасагт 500,0 сая төгрөгийн эмэгтэйчүүдийн суурин болон зөөврийн эхо аппарат, чих хамар хоолойн үзлэг болон төвөнхийн харалтын иж бүрэн дуран 129.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжүүд бүрэн нийлүүлэгдэн ашиглагдаж байна.</p>	100%
17		БОЭТ-ийн барилга их засвар, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлэх	2021-2024	Аймгийн ЗДТГ БОЭТ	ЭМГ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр	1.000.0	БОЭТ-ийн барилга их засвар	Дотрын тасгийн засвар	150.0	<p>2021-2023 онд Орон нутгийн төсөв 445.6</p> <p>Гүйцэтгэлийн санхүүжилт 927.6</p> <p>2024 онд Улсын төсөв 1.4 тэрбум Орон нутгийн төсөв 882.5</p>	<p>2021 онд орон нутгийн 245,6 сая төгрөг, 2022 онд 200.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар амбулаторийн 1 болон 2 давхрын их засвар, 280.0 сая төгрөгийн гүйцэтгэлийн санхүүжилтээр Дотрын тасгийн их засвар нь хийгдсэн. 2023 онд Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь лабораторийн тасгийн засварыг 274.8 сая төгрөг, амбулаторийн 3, 4-р давхрын засварыг 372.8 сая төгрөгийн байгууллагын гүйцэтгэлийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн.</p> <p>2024 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Мэс заслын нэгдсэн тасагт 533.3 сая төгрөг, Гэмтлийн тасгийн их засварт 305.2 сая төгрөг, эмчилгээний хоолны тасгийн дээврийн засварт 44,0 сая төгрөгийн нийт 882.5 сая төгрөгийн их засварын ажлууд хийгдсэн.</p>	100%

18		Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг шаардлагатай лабораторийн болон бусад тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангах	2021-2024	Аймгийн ЗДТГ ЭМГ	Жаргалант сумын ӨЭМТ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр Орон нутгийн төсөв	1.500.0	Сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь 85%	2 өрхийн эрүүл мэндийн лабораторийн чадавхыг сайжруулах	240.0	2021-2023 онд ЭМД-аас гүйцэтгэлийн санхүүжилт 29.0  Орон нутгийн төсөв 79.5  Төсөл хөтөлбөр 15.5  2024 онд Орон нутгийн төсөв 134.7  Олон улсын төсөл 13.7	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 2021-2022 онд дунджаар 93.5%, 2023 онд 95,6%-тай байна. 2024 онд анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмжийг сайжруулах чиглэлээр 148.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс орон нутгийн төсөв 134.7 сая (90,8%), төсөл хөтөлбөр 13.7 сая (9,2%) төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Үүнд: - Орон нутгийн 60.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3 өрхийн эрүүл мэндийн төвийг мобайл технологиор, 17.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Анхны-Оч, Мөнхсүндрэл өрхийн эрүүл мэндийн төвийг нярайн шарлагын аппаратаар, 48.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Анхны-Оч өрхийн эрүүл мэндийн төвийг цусны дэлгэрэнгүй шинжилгээний аппарат, нярайн шарлагын аппаратаар, 9.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Мэндцэцэн өрхийн эрүүл мэндийн төвийг шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр тус тус хангасан. - Азийн Хөгжлийн банкны МОН-9218 төслийн хүрээнд 13.7 сая төгрөгийн өртөг бүхий 6 нэр төрлийн 54 ширхэг тоног төхөөрөмжийг сум, өрхийн дархлаажуулалтын 9 нэгжид, олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд нүдний улаан рефлекс шалгах Arclite багажийг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 15 ширхгийг тус ус хуваарилсан. - Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд цусны дэлгэрэнгүй болон биохимийн шинжилгээний аппарат 6, шээсний шинжилгээний аппарат 8, суурин эхо 8, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат 17, дефибриллятор 9, билиметр 9 байна. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 96%-тай болж өмнөх оноос 0,4%-аар нэмэгдсэн байна.	100%
19		Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг зориулалтын байртай болгож ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.	2021, 2023	Аймгийн ЗДТГ Жаргалант сумын ЗДТГ	Жаргалант сумын ӨЭМТ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр Орон	2.150.0	Стандартын шаардлага хангасан орчин бүрдүүлсэн Сум,	-	-	2021-2023 онд Улсын төсөв 1,7 тэрбум	2021 онд Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга 500.0 сая, Энхжигмандариваа өрхийн эрүүл мэндийн төвийн барилга 1.2 тэрбум, Мөнхийн Гэгээ өрхийн эрүүл мэндийн төвийн гадна фасадны их засварын ажлууд хийгдсэн.	100%

						нутгийн төсөв		өрхийн эрүүл мэндийн төв-7			Орон нутгийн төсөв 170.0  2024 онд Улсын төсөв 1.8  Орон нутгийн төсөв 636,8	2022 онд Цагаанчулуут багийн Үйлсбадрах өрхийн эрүүл мэндийн төвийн газрын асуудлыг шийдвэрлүүлсэн. 2023 онд Жаргалант сумын Эрүүл мэндийн төвд Жаргалант сумын төсвөөс 20.0 сая төгрөг шийдвэрлэн стандартын дагуу болгож засварлах урсгал засвар хийгдсэн. 2024 онд улсын төсвөөс Цагаанчулуут багт Өрхийн эрүүл мэндийн төвийн барилгад 1.8 тэрбум төгрөг батлагдан эрх шилжин нээлттэй тендер зарлагдаад байна. Орон нутгийн төсвийн 253.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Анхны Оч өрхийн эрүүл мэндийн төвийн дээврийн болон дотор засвар, Баян-Өндөр сумын ИТХ-ын тогтоолоор Мөнхийн Гэгээ өрхийн эрүүл мэндийн төвд 24.8 сая төгрөгийн дээврийн завсар, Жаргалант сумын ИТХ-ын тогтоолоор Жаргалант сумын эрүүл мэндийн төвд 375.5 сая төгрөгийн их засвар хийгдэхээр төсөвлөгдсөн байна. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн барилга байгууламж 100% стандартын шаардлага хангасан.	
20	1.3.Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.	Тохиолдол удирдлагын тогтолцоог бэхжүүлж хариу арга хэмжээний чадавхыг нэмэгдүүлэх	2021-2024	ЭМГ	Аймгийн ЗДТГ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр	19.0	Хариу арга хэмжээний чадавх 75%	Хариу арга хэмжээний чадавхыг 85%-д хүргэх	5.5	2023 онд Орон нутгийн төсөв 25.0	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний чадавх 2021 онд 85%, 2022 онд 90%, 2023 онд 95% болж өмнөх оноос 5%-аар нэмэгдсэн байна. 2024 онд тохиолдол удирдлагын тогтолцоог бэхжүүлж, хариу арга хэмжээний чадавх нэмэгдүүлэх хүрээнд орон нутгийн төсвөөс 25.0 сая төгрөгийг шийдвэрлэснээр эрүүл мэндийн байгууллагуудад дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг хариуцсан 40 мэргэжилтэн бэлтгэгдэж, эрүүл мэндийн 3 байгууллагад олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO 9001 стандарт эрсдэлийн менежментийн тогтолцоо ISO31000:2018 стандарт нэвтрэн, томуу, томуу төст өвчний дэгдэлтийг хүндрэл бэрхшээлгүй даван туулсан. ХӨСҮТ-д нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрсдэлийн үнэлгээ хийх төвийн сургалтад ЭМГ-аас 2 мэргэжилтнийг хамруулж чадавхжуулсан. ОБЕГ-аас зохион байгуулсан Стратеги команд штабын сургуулилтад эрүүл мэндийн албаны 15 гишүүн, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн мэргэжлийн ангийн 55 бие бүрэлдэхүүн оролцож, 2 удаагийн жагсаалын	100%

											бэлтгэл хийн, Онцгой байдлын газраас өгөгдсөн 7 удаагийн цагийн байдалд хариу арга хэмжээ авч ажилласан. Эрүүл мэндийн байгууллагуудын гамшгийн үеийн нөөцийн хангалт дунджаар 95% байна.		
21		Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийг нэмэгдүүлэх	2021-2024	ЭМГ	Аймгийн ЗДТГ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр	60.0	Нөөц бүрдүүлэлт 50%	20.0	Эрүүл мэндийн байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлсэн байна.	2021-2023 онд Улсын төсөв 36.4 Орон нутгийн төсөв 30.0 Улсын төсөв 19.0 Орон нутгийн төсөв 30.0	Эрүүл мэндийн байгууллагуудын гамшгийн үеийн нөөцийн хангалт 2021 онд 75-80%, 2022 онд 90%, 2023 онд 95 хувьтай болж нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд Монгол Улсын Их Хурлын 2008 оны 30 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 17 нэр төрлийн 411 нэрийн эм, багаж хэрэгсэл бусад шаардлагатай бараа, материалын нөөцийг 7 хоног тутмын 2 дахь өдөр Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт медиал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, сумын болон өрхийн эрүүл мэндийн төвүүдээс авч нэгтгэн 8 удаагийн мэдээ тайланг хүргүүлээд байна. Мөн ЭМГ-ын гамшгийн нөөцөд нэмэлтээр 1 нэр төрлийн 4.8 сая төгрөгийн эм, 5 төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж хэрэгслийн 4.6 сая төгрөгийн яаралтай тусламжийн багц, 3 нэр төрлийн 27.0 сая төгрөгийн хувийн хамгаалах хувцас хэрэгсэл ирсэн нь өмнөх онтой харьцуулахад нөөцийн хангалт 14.27%-аар нэмэгдсэн байна. Эрүүл мэндийн байгууллагууд дунджаар 14-21 хоногийн нөөцтэй байна. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний чадавх 95%-тай байна.	100%
22	1.4. Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн, эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэн, орон нутагт хийгдэх оношилгоо эмчилгээнд алсын зайн технологи ашиглаж, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах үйлчилгээг нэвтрүүлнэ.	Орон нутагт хийгдэх алсын зайн оношилгоо, телемедицинский техник тоног төхөөрөмжийг сайжруулан, цахим эрт илрүүлэг, алсын зайн оношилгоо хийх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	2021-2024	Аймгийн ЗДТГ ЭМГ БОЭТ	Эрүүл мэндийн байгууллагууд Олон улсын байгууллагууд	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр	-	Зайн оношилгоо-2 чиглэлээр хэрэгжиж байна. Алсын зайн оношилгоо, телемедицинский техник тоног төхөөрөмжийн	-	Цахим эрт илрүүлэг, алсын зайн оношилгоо хийх үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдсэн байх.	-	Алсын зайн оношилгоо, телемедицинский техник тоног төхөөрөмжийн хангалт 2021-2023 онд 33 хувь, 2024 онд 33.2% болж суурь үзүүлэлтээс 16.2%-аар нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд телемедицинский хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд: - Зүрх судасны үндэсний mn.Cardio программын цахим өвчний түүхэнд 215 хүний мэдээллийг оруулсан. - БНСУ-ын Бусан хотын Үндэсний их сургуулийн эмнэлгийн алсын зайн оношилгоо, эмчилгээний төв Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 2023 онд байгуулагдсанаар нийт 21 өвчтөнд зөвлөгөө авсан байна. - Жаргалант сумын эрүүл мэндийн төвд эмнэлзүйн хүнд өвчтөнд авах арга хэмжээний зөвлөмжийг БОЭТ-ийн нарийн мэргэжлийн,	100%



							хангалт 17%				<p>мэргэшсэн эмч нараас телемедицинээр авах нөхцөл бололцоо бүрдсэн.</p> <p>- Байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай, хэвтэрт байдаг иргэдийг Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын хуралд телемедицинээр гэрээсээ өрхийн эмчийн хамт орон хөнгөвчлөх ажлыг зохион байгуулахаар туршилтын хурлыг зохион байгуулсан.</p> <p>- "Цахим Эрдэнэт-1" хөтөлбөрийн хүрээнд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 20 ширхэг планетаар хангаж, түргэн тусламж, гэрийн эргэлт дуудлагаар очиж үзсэн эмч өвчтөний өвчний түүхийн мэдээллийг цахим системээс харах, үзлэгийн бүртгэлийг хийх, хөнгөлөлттэй эмийн жор бичих зэрэг цахим бүртгэлтэй холбоотой ажиллагааг газар дээр нь хийх боломж бүрдсэн.</p> <p>- Жаргалант сумын эрүүл мэндийн төв болон 5 өрхийн эрүүл мэндийн төвд Мобайл технологи хэрэгжиж тайлант хугацаанд мобайл технологиор гэрийн эргэлтийн IV, V-р бүлгийн эргэлт, алслагдсан багийн малчдын эргэлт, явуулын үзлэг, байгууллагын урьдчилан сэргийлэх үзлэг зэрэгт ашиглаж давхардсан тоогоор 10,000 гаруй хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.</p> <p>- Алсын зайн оношилгоо, телемедициний техник тоног төхөөрөмж бүхий 11 байгууллага байна. Тайлант хугацаанд 50 өвчтөний мэдээллийг телемедицинээр дамжуулан оношилгоо, эмчилгээний зөвлөгөө авсан байна</p>	
23	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн компьютерыг үе шаттайгаар шинэчлэх	2021-2024	ЭМГ	Аймгийн ЗДТГ БОЭТ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр	-	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 10%-д компьютерыг шинэчлэл хийгдсэн.	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 100%-д компьютерыг шинэчилсэн байна.	-	2023 онд Орон нутгийн төсөв 174.6	<p>Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн компьютерын хангалт 2021-2022 онд 90%, 2023 онд 95%-тай байна.</p> <p>Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа өрхийн эрүүл мэндийн 8 төв, Жаргалант сумын эрүүл мэндийн төвүүд нь 2 mb/ps хурдтай интернетэд холбогдсон.</p> <p>- "Цахим Эрдэнэт-1" хөтөлбөрийн хүрээнд өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 20 ширхэг таблет олгосноор түргэн тусламж, гэрийн эргэлт дуудлагаар очихдоо эмч өвчний түүхийн мэдээллийг цахим системээс харах, үзлэгийн бүртгэлийг хийх, хөнгөлөлттэй эмийн жор бичих зэрэг цахим бүртгэлтэй холбоотой ажиллагааг газар дээр нь гүйцэтгэж байна.</p> <p>- ХӨСҮТ, Жайка олон улсын байгууллагын</p>	100%

											санхүүжилтээр дархлаажуулалтын бүртгэл хийхэд ашиглах тус бүр 1 ширхэг суурин компьютероор сум, өрхийн мэндийн төвүүдийг хангасан. - Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар алслагдсан багийн 3 өрхийн эрүүл мэндийн төвд алсын зайнаас оношилгоо хийх зөөврийн таблет, ipad бүхий мобайл технологийн тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн. Сум, өрх эрүүл мэндийн төвүүдэд 126 компьютер ашиглагдаж байгаа ба тайлант хугацаанд 60 компьютерыг шинэчлэх болон, ssd hard тавьж хурдыг сайжруулсан. 2024 онд сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн компьютерын хангалт 95.2% болж өмнөх оноос 0.2%-аар нэмэгдсэн.	
24	1.5.Эрүүл мэндийн ажилтны ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж, нийгмийн баталгааг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэн тэдний эрүүл аюулгүй тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудлыг дэмжих, "Эмч" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2021-2024	ЭМГ	Аймгийн ЗДТГ	Орон нутгийн төсөв	520.0	Эмч хөтөлбөрийн хэрэгжилт 95.3%	Хөтөлбөрийг хэрэгжүүлж, шалгуур үзүүлэлтийг бүрэн хангах	200.0	Орон нутгийн төсөв 150.0	98.7%

												<ul style="list-style-type: none"> <li>- Эрдэнэт хотын “Илгээлтийн эзэд” эрүүл мэндийн салбарын 100 ахмадын уулзалтыг зохион байгуулсан.</li> <li>- Эрүүл мэндийн салбарын 36 ажилтанд 36.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</li> <li>- Эрүүл мэндийн байгууллагуудын 70 ажилтныг умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг, 24 ажилтныг бүдүүн гэдэсний дуранд хамруулсан.</li> <li>- Тайлант хугацаанд төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь 14 байгаа нь өмнөх оноос 0.9%-аар нэмэгдсэн ба нийгмийн дэмжлэгт хамрагдсан хувь 16% байгаа ба хөтөлбөрийн хэрэгжилт 98.7 хувьтай байна.</li> </ul>	
25		Эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн чадавхыг сайжруулж нэн шаардлагатай эмнэлгийн мэргэжилтнийг үе шаттай сургах	2021-2024	ЭМГ	Аймгийн ЗДТГ	Улсын болон орон нутгийн төсөв олон улсын төсөл хөтөлбөр	-	Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан хувь 12.5%	Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан хувь 14.5%-д хүргэсэн байна.	-	-	<p>2021-2022 онд төрийн санхүүжилт болон хувийн зардлаар үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн сургалтад 288 эмч, мэргэжил олгох сургалтад 10 сувилагч тус тус суралцсан.</p> <p>2023-2024 онд улсын төсвийн санхүүжилт болон хувийн зардлаар үндсэн болон төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтад 82 эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн суралцсанаас улсын төсвийн санхүүжилтээр 46 эмч, эмнэлгийн мэргэжилтэн буюу 3.2% нь суралцсан. Төлөвлөлтийн дагуу нэн шаардлагатай нарийн мэргэжлийн эмчийн эзлэх хувь 92% байна. ЖАИКА олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа “Эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах” төслийн хүрээнд 2023-2024 онд буюу 6 дахь жилийн сургалтад “Яаралтай тусламжийн сувилахуй”-аар 2 сувилагч элсэн суралцаж байна. ус төслийн хүрээнд “Шинэ сувилагчийн сургалтын хөтөлбөр”, “Эмнэл зүйн шатлал”-ийн хөтөлбөрийг Орхон аймагт улсын хэмжээнд анх удаа эхлүүлэн, хөтөлбөрийн хүрээнд хэлэлцүүлэг 3 удаа зохион байгуулж, 12 шинэ сувилагчийг хөтөлбөрийн дагуу ажлын байранд нь дадлагажуулсан.</p> <p>Тус хугацаанд 1412 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажлын байрны, алсын зайн сургалтад хамрагдсан нь нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний 91%-ийг эзэлж байна. Мөн 126 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг лавлагаа шатлалд болон анхан шатлалд сэлгэн ажиллуулсан байна.</p>	100%

												Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь 14.9% байна	
<b>БИЕЙН ТАМИР, ЧИЙРЭГЖҮҮЛЭЛТ</b>													
26	1.6.Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжих, мэргэжлийн спорт, баг тамирчдын амжилтыг нэмэгдүүлнэ.	Спортын магадлан итгэмжлэлд хамрагдах спортын клуб, фитнес клубын тоог нэмэгдүүлэх	2021-2024	БТСГ	НБХ	ЭМД-ын сан	-	Магадлан итгэмжлэг дсэн клубын тоо 3	Магадлан итгэмжлэг дсэн клубын тоо 5	-	-	Аймгийн хэмжээнд 2021 онд 13 фитнес клубт 1650 иргэн, 2022 онд 14 фитнес клубт 1800 иргэн, 2023 онд 1900 иргэн тогтмол хичээллэж ирсэн. Тайлант онд фитнес клуб 1-ээр, хичээллэгчдийн тоог 100-аар тус тус нэмэгдэж, 15 фитнес клубт 2000 иргэн тогтмол хичээллэж байна. Фитнес клубүүдээс 3 клуб нь магадлан итгэмжлэгдэн ажиллаж байсан ч магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан тул дахин итгэмжлэлийг сунгуулахаар Биеийн тамир, спортын улсын хороонд хүсэлтээ хүргүүлээд байна.	75%
27		Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тамирчдын тоог нэмэгдүүлж, хэрэглэл материалаар хангах	2021-2024	БТСГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Тамирчдын тоо 140	Тамирчдын тоо 196	Батлагдсан төсвийн хүрээнд	2021-2023 онд Орон нутгийн төсөв 89.9 Улсын төсөв 32.9 2024 онд орон нутгийн төсөв 79.6	2022 онд 15 төрөлд 168 тамирчин хичээллэсэн байсан бол 2023 онд өсвөрийн шигшээ 16 багт 182 тамирчин бэлтгэл сургуулилтаа тогтмол хийсэн. Өсвөрийн шигшээ багийн тамирчдын ур чадварыг сайжруулах зорилгоор өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 17 төрлөөр зохион байгуулж нийт 2764 сурагчид хамрагдсан. 2023 онд өсвөрийн шигшээ багийн тамирчид "Монголын хүүхдийн спортын VII их наадам", улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээнд нийт 142 медаль хүртсэнээс 43 алт, 43 мөнгө, 56 хүрэл медаль авсан амжилтыг үзүүлсэн. Мөн онд өвлийн спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллаж буй гадаад улсын буцалтгүй тусламжаар гүйлтийн цана 20 ширхгийг хүлээн авч, цанын өсвөрийн шигшээ багийг хэрэглэл материалаар хангасан. 2024 онд өсвөрийн шигшээ 16 багт тамирчдын тоог 14-өөр нэмэгдүүлж 196 өсвөрийн тамирчин бэлтгэл сургуулилалтаа тогтмол хийж байна. Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 13 төрлөөр зохион байгуулж, нийт 2152 тамирчдыг хамруулсан. Өсвөр үеийн тамирчид олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнд 167 өсвөрийн тамирчид медаль авсан амжилтыг үзүүлснээс 68 алт, 42 мөнгө, 57 хүрэл медалийг хүртсэн. Тэмцээн уралдааны зардалд орон нутгийн төсвөөс 40.0 сая, хэрэглэл материал авахад орон нутгийн төсвөөс 39.6 сая төгрөг тус тус зарцуулсан.	100%

28		Улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулах	2021-2024	БТСГ	НБХ	Орон нутгийн төсөв, Спортын холбоод болон ААНБ-ын хандив	Батлагдсан төсвийн хүрээнд	Зохион байгуулсан тэмцээний тоо 2	Зохион байгуулсан тэмцээний тоо 5	Батлагдсан төсвийн хүрээнд	2021-2023 онд Улсын төсөв 275.0  Орон нутгийн төсөв 312.0  2024 онд Орон нутгийн төсөв 124.7	Орон нутагтаа улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнийг зохион байгуулах ажлын хүрээнд 2021 онд улсын аварга шалгаруулах тэмцээн 2 удаа, 2022 онд улсын аварга шалгаруулах тэмцээн 5 удаа, бүсийн аварга шалгаруулах тэмцээн 4 удаа, 2023 онд улсын аварга шалгаруулах тэмцээн 7, бүсийн аварга шалгаруулах тэмцээн 2 удаа тус тус зохион байгуулж нийт 6782 тамирчин хамруулж, орон нутгийн төсвөөс нийт 312.0 сая, улсын төсвөөс 275.0 сая төгрөг зарцуулж, Орхон аймагт 1300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, худалдан авалт хийгдэж худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлсэн. Тайлант онд улсын аварга шалгаруулах тэмцээн 9, бүсийн аварга шалгаруулах тэмцээн 4 удаа тус тус зохион байгуулж, нийт 4162 тамирчин оролцсон. Тэмцээн уралдаан зохион байгуулахад орон нутгийн төсвөөс 124.7 сая төгрөг зарцуулж, худалдаа, үйлчилгээний аж ахуйн нэгж, байгууллагад 450.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, худалдан авалт хийгдсэн.	100%
29		Үндэсний болон багийн спортын төрлүүдээр иргэдийн спортын их наадмыг шат дараатай зохион байгуулж, төрлүүдийн тоог нэмэгдүүлэх	2021-2024	БТСГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Спортын 5 төрөл	Спортын 8 төрөл	Батлагдсан төсвийн хүрээнд	2021-2023 онд орон нутгийн төсөв 38.8  2024 онд Орон нутгийн төсөв 25.0	Үндэсний болон багийн спортын төрлүүдээр "Иргэдийн спортын наадам"-ыг 2021 онд спортын 3 төрлөөр (сагсан бөмбөг, волейбол, орс таталт) зохион байгуулж, 900 иргэн хамруулсан бол 2022 онд спортын 6 төрлөөр зохион байгуулж 897 иргэнийг хамруулж, 12.8 сая төгрөг зарцуулсан. 2023 онд Баян-Өндөр, Жаргалант сумдын ЗДТГ-тай хамтран "Иргэдийн спортын наадам"-ыг үндэсний болон багийн спортын 8 төрлөөр зохион байгуулж сагсан бөмбөгийн төрөлд 308, волейболын төрөлд 384, орс таталтын төрөлд 184, ширээний теннисний төрөлд 46, үндэсний бөхийн төрөлд 69, буудлагын төрөлд 92, дартсын төрөлд 46, Мас-рестлинг /Модон барилдаан/-ны төрөлд 32 иргэн тус тус оролцож нийт 1143 иргэн хамрагдсан. Тэмцээний үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 20.0 сая төгрөг зарцуулсан. Тайланд онд "Иргэдийн спортын наадам"-ыг багийн болон үндэсний спортын 8 төрлөөр зохион байгуулж, 1015 иргэн оролцуулан орон нутгийн төсвийн 25.0 сая төгрөгийг зарцуулсан.	100%

30		Спортын хэрэгслийн (ердийн болон цахилгаан дугуй, цана, тэшүүр, дугуйт цана, дугуйт тэшүүр) түрээсийн үйлчилгээг нэвтрүүлэх санал санаачилгыг дэмжих	2021-2024	НБХ	БТСГ ХЗА	Орон нутгийн төсөв	-	-	Түрээсийн үйлчилгээ үзүүлж буй ААНБ, иргэдийн тоо жил бүр нэмэгдсэн байна.	-	<p>2021 онд 2 байршилд 2 иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан боловч Ковид-19 цар тахлын улмаас үйл ажиллагаа явагдаагүй.</p> <p>2022 онд 4 байршилд 3 иргэн аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, уулын цана, чарга, тэшүүр, ердийн болон гэр бүлийн дугуйн төлбөрт үйлчилгээг 6700 гаруй хүүхэд залууст хүргэж ажилласан бол 2023 онд 6 байршилд 6 иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, уулын цана, чарга, тэшүүр, цахилгаан дугуй /скүүтер/, ердийн болон гэр бүлийн дугуйн төлбөрт үйлчилгээг 7200 гаруй хүүхэд залууст хүргэж ажиллалаа.</p> <p>2024 онд 5 байршилд 5 иргэн, аж ахуйн нэгж уулын цана, чарга, тэшүүр, гэр бүлийн дугуй, дугуйн түрээсийн үйлчилгээг 4650 гаруй хүүхэд залууст үзүүлсэн. Үүнд:</p> <p>- "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Сархиа цанын баазад чарга, уулын цана, тэшүүрийн түрээсийн үйлчилгээнд 2200 иргэн;</p> <p>- 19-р сургууль /орос сургууль/ дахь мөсөн талбайн тэшүүрийн түрээсийн үйлчилгээнд 1200 иргэн;</p> <p>- "Эрдэнэт спорт амралтын хүрээлэн"-д тэшүүрийн түрээсийн үйлчилгээнд 650 иргэн, гэрбүлийн дугуйн түрээсийн үйлчилгээнд 1250 иргэн;</p> <p>"Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнд" дугуйн түрээсийн үйлчилгээнд 1500 иргэн тус тус хамрагдсан.</p>	100%
31	1.7.Хүн амын зорилтот бүлгүүд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллана.	Ахмадуудад спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх, хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэх	2021-2024	БТСГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Хичээллэгсдийн тоо 750	Хичээллэгсдийн тоо 1000	Батлагдсан төсвийн хүрээнд	2024 онд улсын төсөв 5.2	100%

											спортын зааланд 1000 гаруй ахмадыг үнэ төлбөргүйгээр хичээллүүлж байна.		
32		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулах уралдаан тэмцээний төрлийг нэмэгдүүлэх	2021-2024	БТСГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Хичээллэгсдийн тоо 250	Хичээллэгсдийн тоо 450	Батлагдсан төсвийн хүрээнд	2022-2023 онд Улсын төсөв 5.6 2024 онд улсын төсөв 3.8 Орон нутгийн төсөв 1.2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд биеийн тамир, спортын газрын А, Б зааланд долоо хоногт 3 удаа үнэ төлбөргүйгээр хичээллэдэг бөгөөд 2021 онд спортын 3 төрлөөр 3 удаа тэмцээн зохион байгуулж 112 иргэн, 2022 онд спортын 9 төрлөөр 12 удаагийн арга хэмжээ зохион байгуулж 509 иргэдийг хамруулж байсан бол 2023 онд пара хөнгөн атлетик, 3x3 сагсан бөмбөг, буухиа, дартс, ширээний дуут бөмбөг, волейбол, хонхот бөмбөг, суугаа волейбол, бочи зэрэг 9 төрлөөр 360 иргэн тогтмол хичээллэж, 11 удаагийн тэмцээн уралдаанд оролцсон. 2024 онд спортын 10 төрлөөр 455 иргэн тогтмол хичээллэж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын 9 төрлөөр 10 удаа тэмцээн уралдаан зохион байгуулан тэмцээн, уралдааны зохион байгуулалтад улсын төсвөөс 3.8 сая, орон нутгийн төсвөөс 1.2 сая төгрөг тус тус зарцуулсан.	100%
33	1.8.Хийн болон эрүүл мэндийн дасгал хөдөлгөөн өрнүүлэх иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын санал санаачилгыг дэмжиж, спортын заал талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Хийн болон эрүүл мэндийн дасгал хөдөлгөөнийг сурталчилж "Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшье" аяныг аймгийн иргэд болон ААНБ-уудын дунд өрнүүлэх	2021-2024	БТСГ БШУГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Хамрагдах иргэдийн тоо 9000	Батлагдсан төсвийн хүрээнд	2022-2023 онд орон нутгийн төсөв 28.0 2024 онд улсын төсөв 15.0	"Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшье" аянд 2021 онд 15954, 2022 онд 44856 иргэн тус тус хамрагдсан. 2023 онд аяны хүрээнд "Нэг анги-Нэг өглөө" өглөөний дасгалын үйл ажиллагааг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд ерөнхий боловсролын 11 сургуулийн 12632 сурагч, 2597 эцэг эх давхардсан тоогоор нийт 15229 иргэнийг дасгал хөдөлгөөнд хамруулсан байна. 2024 онд "Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшье" аяны хүрээнд 6 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 38000 иргэнийг хамруулж, орон нутгийн төсвөөс 15.0 сая төгрөг зарцуулсан. Ингэснээр иргэдийг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлж, дасгал хөдөлгөөнөөр дамжуулан эрүүл идэвхтэй амьдралын дадлыг олгон, эрүүл идэвхтэй хэв маягтай иргэдийн тоог нэмэгдүүлсэн.	100%
34		Биеийн тамир, спортоор хичээллэх заал талбайг нэмэгдүүлэх	2021-2024	Аймгийн ЗДТГ-ын НБХ	БТСГ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	33	Жил бүр 1 талбай нэмэгдсэн байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	2021-2023 онд Орон нутгийн төсөв 1200.0	2021 онд Жаргалант сумын ЗДТГ-ын спорт заал, 2022 онд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгөөр "Энэрэл төв"-ийн спорт заал, 2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Үйлдвэрчний эвлэлийн хорооны спорт заал, 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн барилгын өргөтгөлд шинээр спорт заал тус тус	100%

											<p>ашиглалтад оруулснаар аймгийн хэмжээнд төрийн өмчит байгууллагууд болон хувийн хэвшил, ерөнхий боловсролын сургуулиудад нийт 36 спорт заал ашиглагдаж байна. Ингэснээр аймгийн хэмжээнд 1 хүнд ногдох спорт заалны хүртээмжийн индекс 0.158м<sup>2</sup> болсон байна.</p> <p>Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын 3, 8, 16-р сургуулийн спорт заал, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Сансар худалдааны төвийн хажуу талд спорт заал бүхий цогцолбор тус тус 55-70 хувийн гүйцэтгэлтэйгээр баригдаж байна.</p> <p>Орон сууцны болон гэр хорооллын байршилд орон нутгийн төсвийн 798.7 сая төгрөгөөр амралт, чөлөөт цагийн 6 талбайг шинээр барьж байгуулах ажил хийгдсэн.</p> <p>Хүн амын шинэ суурьшлын бүс орон сууцны 2а, 7а хорооллуудад 960 хүүхдийн ерөнхий боловсролын дунд сургууль /спорт заалтай/ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдахаар барилгын зураг төслийг боловсруулах ажил хийгдэж байна.</p>	
35	1.9.Аймгийн хэмжээнд өвлийн спортыг хөгжүүлж, боловсон хүчин болон материаллаг баазаар ханган хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ.	Өвлийн спортын дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2021-2023	БТСГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Хэрэгжилтийн хувь 10%	Хэрэгжилтийн хувь 100%	Батлагдсан төсвийн хүрээнд	<p>2021-2023 онд Улсын төсөв 275.0,</p> <p>Орон нутгийн төсөв 276.4,</p> <p>Хандив тусламж 20.0</p> <p>2024 онд 10.0</p> <p>Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Өвлийн спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөр"-ийн биелэлт 2021 онд 76 хувь, 2022 онд 86.5 хувь, 2023 онд 92.5 хувийн биелэлттэй хэрэгжсэн байна. Хөтөлбөрийн хүрээнд спортын 7 төрлөөр 10 удаагийн нээлттэй тэмцээнийг зохион байгуулж 560 гаруй иргэнийг хамруулсан. Тамирчид тив, улс, бүсийн аварга шалгаруулах 32 тэмцээнд оролцож 280 медаль авсан амжилтыг үзүүлсэн. Мөн биатлоны Монгол улсын шигшээ багт 5, хоккейн улсын шигшээ багт 14 тамирчин шалгаран тус тус бэлтгэл сургуулилтаа хийж байна. Өвлийн спортын төрлүүдийг хөгжүүлэхэд орон нутгийн төсвийн 220.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар цана 17 ширхэг, тэшүүр 14 ширхэг, цас буудагч буу, цасны мотоцикль, усны шланг зэргийг авсан. Швейцарын холбооны улс, Бүгд найрамдах Франц улсын өвлийн спортын үндэсний төвүүдтэй хамтран ажиллаж 200ш хоккейн тэшүүр, 13 цана хандиваар авч цана, тэшүүрийн тамирчдыг бэлтгэл сургуулилтаа хийхэд хэрэглэл материалаар ханган ажилласан.</p>	100%



												<p>Хөтөлбөрийн хүрээнд шинээр 2 мөсөн талбай байгуулж өвлийн спортын мөсний сур харваа, мөсөн шагай, тэшүүр, шорт трекийн спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлснээр хичээллэгсдийн тоо 600-аар, тамирчдын тоо 342-оор тус тус нэмэгдэж нийт 2532 иргэн хичээллэдэг болсон. 2023 онд орон нутагтаа анх удаа Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадам, Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадмыг нэгэн зэрэг өндөр түвшинд зохион байгуулж 12 аймаг, 7 дүүргээс 700 гаруй дасгалжуулагч, тамирчид, зочид төлөөлөгчид хүрэлцэн ирж зочид буудал, хоол үйлдвэрлэл, бэлэг дурсгал, хэвлэл мэдээлэл, бусад үйлчилгээний байгууллагуудаас Орхон аймагт нийт 1.0 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалт, худалдан авалт хийгдсэн байна.</p> <p>2024 онд өвлийн спортын хөтөлбөрийг төсөл арга хэмжээ болгон үргэлжлүүлж “Эрдэнэт мөнгөн өвөл-2024” аяныг 4 дэх жилдээ зохион байгуулсан. Тус аяны хүрээнд улсын аварга шалгаруулах тэмцээн 3, олон хотын болон аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 5 удаа, нийт 8 удаагийн тэмцээн уралдаан, өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулж, 1358 тамирчид, иргэдийг хамруулж өвлийн спортоор дамжуулан орон нутгаа сурталчилж ажилласан. Тэмцээн уралдаан зохион байгуулахад орон нутгийн төсвийн 10.0 сая төгрөг зарцуулсан.</p> <p>Аймгийн хэмжээнд цасан зам 2, мөсөн талбай 4 тус тус байгуулж, өвлийн спортын 7 төрөлд 560 гаруй тамирчид бэлтгэл сургуулилтаа хийхэд таатай орчныг бүрдүүлсэн. Мөн цана, чарга, тэшүүрийн түрээсийн үйлчилгээнд 4050 иргэн хамрагдсан нь хүүхэд залуусыг чөлөөт цагаараа өвлийн спортоор хичээллэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлж ажиллалаа.</p>	
36	“Эрдэнэт-Спорт амралтын хүрээлэн” болон ЕБС-иудын гаднах талбайд өвлийн спортоор хичээллэх орчин бүрдүүлэх	2021-2024	БТСГ БШУГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Мөсөн талбайн тоо 3	Жил бүр 1 талбай нэмэгдсэн байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	2021-2023 онд Орон нутгийн төсөв 71.0  2024 онд Орон нутгийн төсөв 10.0	<p>2021 онд мөсөн талбай 2, цанын зам 1, 2022 онд мөсөн талбай 3, цанын зам 1 -ийг тус тус байгуулсан.</p> <p>2023 онд 7 зам талбай байгуулж спортын 8 төрлөөр /биатлон, гүйлтийн цана, уулын цана, снөүбоард, гүйлтийн тэшүүр, шорт трек, хоккей, мөсний сур харваа, мөсөн шагай/ 532 тамирчин хичээллэж, бэлтгэл сургуулилт хийх, тэмцээн уралдаан зохион байгуулах орчин нөхцөлийг бүрдүүлж ажилласан.</p>	100%	

												<p>2024 онд цанын зам 2, мөсөн талбай 4 тус тус байгуулж, өвлийн спортын 7 төрөлд 560 гаруй тамирчид бэлтгэл сургуулилтаа хийж, улсын аварга шалгаруулах тэмцээнийг биатлон, гүйлтийн цана, хоккейн төрлүүдээр зохион байгуулсан бол мөсний шагай, мөсний сур харваа, гүйлтийн цана, уулын цана, хоккейн төрлүүдээр олон хотын болон аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүдийг өөрсдийн зам талбайдаа тус тус зохион байгуулсан. Мөн цана, чарга, тэшүүрийн түрээсийн үйлчилгээнд 4050 иргэн хамрагдсан нь хүүхэд залуусыг чөлөөт цагаараа өвлийн спортоор хичээллэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлж ажиллалаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- "Эрдэнэт спорт, амралтын хүрээлэн"-д гүйлтийн тэшүүр 400м мөсөн талбай;</li> <li>- Сархиа цанын баазад гүйлтийн цана, уулын цанын 2 зам,</li> <li>- Сархиа цанын баазын мөсөн талбай,</li> <li>- 19-р сургуулийн хоккейн талбай;</li> <li>- Ерөнхий боловсролын 15 дугаар сургуулийн гадна мөсөн талбайг байгуулсан.</li> </ul> <p>Эрдэнэт спорт амралтын хүрээлэнд мөс тавихад орон нутгийн төсвийн 10.0 сая төгрөг зарцуулсан.</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

**ХОЁР.ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАЛАМЖ, ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН БОДЛОГО**

**ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУД, АХМАД НАСТАН**

37	2.1.1.Гэр бүлд суурилсан салбар дундын уялдаа холбоог сайжруулан идэвхэжсэн хандлага оролцоог дэмжинэ.	Зорилтот гэр бүлд чиглэсэн ажил, үйлчилгээг сайжруулах	2021-2024	ГБХЗ ХГ	Аймгийн ЗДТГ	Улсын төсөв	60.0	Зорилтот гэр бүлийн 10%	Зорилтот гэр бүлийн 30%	15.0	<p>2021-2023 онд Улсын Төсөв 60.0 Орон нутгийн төсөв 35.0</p> <p>2024 онд Орон нутгийн төсөв 30.0 улсын төсөв 17.0</p>	<p>2021-2024 онд зорилтот бүлгийн гэр бүлд чиглэсэн "Гэр төсөл", "Алхам алхмаар", "Бид хамтдаа зуслан", эрсдэлт бүлгийн гэр бүлүүдэд сэтгэл заслын үйлчилгээ хөтөлбөрүүд, "Сайн уу үр минь", "Хосын болзоо" өдөрлөг, эрүүл мэнд, хууль хяналтын байгууллагад холбон зуучлах үйлчилгээ, амьдрах ухааны сургалт болон нөлөөллийн олон талт арга хэмжээнд давхардсан тоогоор 1754 өрхийн 7017 иргэн хамрагдсанаар зорилтот гэр бүлийн 38 хувийг хамруулсан байна. Үүнээс 2024 онд зорилтот бүлгийн гэр бүлд үзүүлэх зөвлөгөө үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх, хохирогчид нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр нийт 21 арга хэмжээнд 831 өрхийг хамруулсан нь нийт зорилтот өрхийн 18.1 хувьд хүрч ажилласан үр дүнтэй байна. Мөн тэдэнд сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх цар хүрээг нэмэгдүүлэх, чиглэлээр Баян-өндөр сумын 15 багт сэтгэл зүйн зөвлөгөө, холбон зуучлах үйлчилгээ</p>	100%
----	--	--	-----------	---------	--------------	-------------	------	-------------------------	-------------------------	------	--	---	------

											үзүүлэх нийгмийн ажилтны өрөөг бий болгож, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлсэн. Алслагдсан хорооллын 10 багийн 50 өрхийн гишүүдэд сэтгэл заслын үйлчилгээ үзүүлснээр сэтгэл гутралд орохоос урьдчилан сэргийлэх, сэтгэл зүйгээ удирдах арга ухаанд суралцсан үр дүнтэй байна.		
38		Гэр бүлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	2021-2024	ГБХЗ ХГ	НБХ	Улсын төсөв	20.0	Нийт өрхийн 15%	Нийт өрхийн 35%	5.0	2021-2023 онд улсын төсөв 35.0 орон нутгийн төсөв 45.0 2024 онд Улсын төсөв 11.8 Орон нутгийн төсөв 28.0	2021-2024 онд гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр гэр бүлийн өдөрлөг, гэр бүлийн чуулган, онол практикийн бага хурал, "нийгмийн эрүүл мэндэд- бидний оролцоо" аян, гэр бүлийн гишүүдийг оролцуулсан уралдаан тэмцээн, кино соёл урлагаар дамжуулан гэр бүлийн боловсрол олгох, харилцаа хандлага төлөвшүүлэх арга хэмжээ, залуу хосуудад эцэг эх байх үүрэг хариуцлага зэрэг сургалт нөлөөллийн 108 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 37915 өрхийг хамруулсан. Үүнээс 2024 онд гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр нийт 19 төрлийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 14515 өрхийг хамруулсан нь аймгийн нийт өрхийн 48.4%-ийг эзэлж байна. Мөн гэр бүлийн 34 сургагч багш бэлтгэн гэрчилгээ олгож, тэдгээрээр дамжуулан аж ахуй нэгж байгууллага, хувийн хэвшлийн албан хаагчид, өсвөр үе, залуучуудад сургалт нөлөөллийн ажлыг үе шаттай зохион байгуулсан нь бүх давхаргын иргэн, өрх, өсвөр үе залуучуудын гэр бүлийн боловсролын талаарх мэдлэг ойлголт сайжран, харилцаа хандлага дээшилсэн байна. Дэлхийн гэр бүлийн өдөрлөгөөр "Харилцааны гайхамшиг" ТББ-тай хамтран 20 өдөр өглөөний уулзалтыг зохион байгуулж, уулзалтад төрийн болон төрийн өмчийн байгууллага, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ажилчдад гэр бүлийн хамт оролцох боломжийг олгосон нь тэдний гэр бүл дэх харилцаа хандлага өөрчлөгдсөн үр дүнтэй байна. Гэрлэхийн өмнө аав ээж байх, боловсрол олгох, сургалтыг ЭЭМТ-үүдтэй хамтран "Нийгмийн эрүүл мэндэд бидний оролцоо" аяны хүрээнд шинээр төрөх ээжүүдийг гэр бүлийн хүний хамт сургалт нөлөөллийн ажилд хамруулан ажиллаж эцэг, эх байх үүрэг хариуцлага, хүүхдээ асрахуйн сургалтыг зохион байгуулахаар 4.6 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлэн	100%

												ажиллаж байна. Гэр бүлийн боловсрол олгох сургалтыг Технологийн их сургууль, Полетехнекийн коллеж, Маргад дээд сургуулийн нийт 1093 оюутан сурагчдад хүргэж, тэдний гэр бүлийн боловсролын талаарх мэдлэг нэмэгдсэн.	
39		Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхэдтэй харилцах эв дүй, хүмүүжлийн эерэг арга, хандлагыг төлөвшүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан зохион байгуулах	2021-2024	ГБХЗ ХГ	НБХ	Улсын төсөв	20.0	Эцэг эхчүүдийн 10%	Эцэг эхчүүдийн 30%	5.0	2021-2023 онд Улсын төсөв 10.0 2024 онд Улсын төсөв 6.2 Орон нутгийн төсөв 30.0	2021-2024 онд эцэг эх, асран хамгаалагчдад хүүхэдтэй харилцах эв дүй, хүмүүжлийн эерэг арга, хандлагыг төлөвшүүлэх сургалт, нөлөөллийн ажил, бүлгийн ярилцлага, хэсэгчилсэн зөвлөгөөн зэрэг 41 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 50732 иргэн хамруулаад байна. Аймгийн хэмжээнд 115 байгууллагад эцэг, эхийн зөвлөл ажиллаж байна. Үүнээс хүүхдийн өрөөг бий болгосон байгууллага 18, хүүхэд хамгааллын бодлого боловсруулан хэрэгжүүлж байгаа байгууллага 95 байна. 2024 онд байгууллагуудын Эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан хүүхэдтэй харилцах эв дүй, хүмүүжлийн эерэг арга, хандлагыг төлөвшүүлэх сургалт, Японы боловсролын онцлог хүүхэд хүмүүжлийн эерэг арга хөтөлбөр, цахим нөлөөллийн ажил, хүүхэд хамгааллын тухай хууль сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зэрэг арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 19000 эцэг эх хамрагдсан нь нийт эцэг эхчүүдийн 31.6 хувь хамрагдсан. Үүнд Хүүхэд хүмүүжлийн эерэг арга, хүүхэдтэйгээ ярилцах арга зүйн сургалтыг 9 сургуулийн 600 гаруй багш, эцэг эх, асран хамгаалагчдад хүргэн ажилласан. Эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан 7 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулж 3900 эцэг эх, асран хамгаалагчийг харуулсан. Хүүхэд хамгааллын тухай хууль, хүүхэд хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн боловсрол олгох сэдвээр 4 шторк, 21 постер мэдээлэл, 3 удаагийн лайв мэдээлэл хийж ажиллаж нийт 14500 гаруй хандалт авсан байна.	86%
40		Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдэд чиглэсэн төсөл хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	2021-2024	ГБХЗ ХГ	НБХ	Орон нутгийн төсөв	-	-	Хөтөлбөрийн хэрэгжилтийн 95%-д хүрсэн байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	2021-2023 онд Орон нутгийн төсөв 190.0 2024 онд Орон	2021-2024 нийгэмд эерэг харилцаа, дадлыг төлөвшүүлж, эмэгтэйчүүдийн хөгжил, манлайллыг нэмэгдүүлэх чиглэлээр 15 төрлийн сургалт, үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, давхардсан тоогоор 21700 гаруй охид, эмэгтэйчүүдийг хамруулсан. Үүнээс 2024 онд тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 50.0 сая төгрөгийн	100%

										<p>нутгийн төсөв 50.0</p> <p>санхүүжилт олгосон. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, хөгжил манлайлал, оролцоог нэмэгдүүлэх зөвлөгөөн сургалт 11 төрлийн арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж, 4600 гаруй охид эмэгтэйчүүдийг хамруулж, хөтөлбөрийн хэрэгжилт 98 хувьтай байна.</p> <p>Эмэгтэйчүүдийг чадавхжуулахад чиглэсэн сургалт нөлөөллийн олон талт ажлыг зохион байгуулахаар 6 төрийн бус байгууллагатай хамтран ажилласан. Үүнд Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан "Хайр нэмье" сэтгэлзүйн өдөрлөг, хууль хүчний 6 байгууллагын дунд "Мөрдөстэй бүсгүйчүүд" арга хэмжээг зохион байгуулж 800 гаруй эмэгтэйчүүдийг хамруулсан.</p> <p>Гадаад дотоодын төсөл хөтөлбөрт эмэгтэй бизнес эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх, холбон зуучлах, хөдөлмөрт зуучлах, гоо зүйн чиглэлээр "Монгол дахь гоёлын шивээс нүүр будалтын холбоо" НҮТББ-ын хамтран артист гоёлын шивээсний сургалтыг 3 сарын хугацаанд үе шаттай зохион байгуулж, давхардсан тоогоор 45 эмэгтэйг хамруулан, амжилттай суралцсан 10 эмэгтэйг ажлын байраар хангаад байна.</p> <p>Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдэд өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор "Эрдэнэтийн ээжүүдийг чадавхжуулах" төрийн бус байгууллагатай хамтран гар урлалын төрөл, хийцийг өргөжүүлэх судалгаа хийж, туршлага судлан гар урлалын 3 шинэ төрлийг нэвтрүүлэн урлангийн ээжүүдэд 5 удаагийн сургалтыг зохион байгуулж 120 гаруй эмэгтэйчүүдийг хамруулснаар анхны бүтээлээ гаргаж салбар дэлгүүрээр дамжуулан худалдаанд гаргаж байна.</p> <p>Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, хөгжил манлайлал, оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах чиглэлээр Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн холбоотой хамтран "Хойд бүсийн зөвлөгөөн" зохион байгуулан Хөвсгөл, Булган, Орхон аймгийн 200 гаруй бизнес эрхлэгч эмэгтэйчүүд хамрагдаж, туршлага судалж, бизнес санаагаа дэлгэрүүлсэн.</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

41	2.1.2.Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний чанар хүртээмж, салбар дундын үйл ажиллагааг сайжруулна.	Хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах	2021-2024	ГБХЗ ХГ	Аймгийн ГХУС АЗСЗ	Улсын төсөв, Орон нутгийн төсөв	40.0	Хамтарсан багийн гишүүдийн хамрагдалт 40%	Хамтарсан багийн гишүүдийн хамрагдалт 70%-д хүрсэн байна.	10.0	2021-2023 онд улсын төсөв 12.0 2024 онд улсын төсөв 2.5 Орон нутгийн төсөв 242.4	2021-2024 онд хүүхэд хөгжил хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх чиглэлээр давхардсан тоогоор 21 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, нийт гишүүдийн 82 хувийг хамруулсан. Аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын 28 хамтарсан баг, нийт 202 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор "Манлайлагч хамтарсан баг" шалгаруулах аяныг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран бүх хамтарсан багийн гишүүдийг хамруулан урлаг, спорт, нөлөөллийн олон талт арга хэмжээг зохион байгуулж, тэдний идэвх, оролцоо нэмэгдсэн. Хамтарсан багийн гишүүдийг мэдээллээр хангах, уялдаа холбоог сайжруулах, шинэчлэн батлагдсан Хүүхэд хамгааллын хуулийг сурталчлах сургалтыг хуваарийн дагуу үе шаттай зохион байгуулж нийт 500 гаруй иргэдийг хамруулж, тэдний хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлсэн. Мөн 8 цэцэрлэг, сургууль, Политехникийн коллежтой хамтран хүүхэд хамгааллын сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж 1020 гаруй эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгчдийг хамруулснаар тэдний хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх мэдлэг, чадвар дээшилсэн. Хамтарсан багаар дамжуулан хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг нийт 2430 иргэн авснаас 1339 хүүхэд хамрагдан нэн шаардлагатай хамгааллын үйлчилгээг авсан байна.	100%
42		Хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад холбогдох байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах (108	2021-2024	ГБХЗ ХГ	Хамтарсан багүүд	Улсын төсөв	60.0	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь 90%	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь 100%-д хүрсэн байна.	15.0	2021-2023 онд: Улсын төсөв 157.0 2024 онд Улсын төсөв 90.0	2021-2024 онд хүүхдийн тусламжийн 108 дугаарын утсанд нийт 965 дуудлага ирсний 95.9 хувийг шийдвэрлэсэн байна. Ирсэн дуудлагын 90 гаруй хувь нь хүүхэд хамгааллын дуудлага эзэлж байна. Үүнээс 2024 онд хүүхдийн тусламжийн 108 дугаарын утсанд нийт 233 дуудлага ирсний 82.4 хувийг шийдвэрлэсэн, 17.6 хувь нь хуулийн хугацаанд шийдвэрлэлтийн шатанд байна. Хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор "Нэгдүгээрт хүүхэд", "Найз байя", "Хүчирхийллийг мэдээлдэг байя" зэрэг	100%

		утас, бусад хүсэлт, гомдол)										<p>нөлөөллийн аян, хүүхдийн тусламжийн 108 утсыг олон нийтэд таниулах ажлын хүрээнд байгууллагын пэйж хуудсаар дамжуулан видео, 13 төрлийн постер, зурагт мэдээллийг хуудас хийн цахим орчинд түгээн ажилласан. Мөн 2100 ширхэг календарийг хэвлүүлэн иргэдэд тархаасан. Хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор ээлжит хяналт шалгалтыг Жаргалант сумын сургууль, Орхон импати сургуулийн дотуур байранд хийж, нөхцөл байдалтай танилцан, хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хамтран ажилласан. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүдтэй хамтран вокзал, Говил, Их залуу багийн чиглэлд үйлчилгээ үзүүлдэг хүүхдийн автобус, 34 цэцэрлэг, 2 өдөр өнжүүлэх төв, 1 хүүхэд харах төвд тус тус орчны аюулгүй байдалд хяналт шалгалтыг зохион байгуулан, гарсан зөрчлийг арилгуулах арга зүйн зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.</p> <p>Эрсдэлт нөхцөлд байгаа гэмт хэрэг, хүчирхийллийн хохирогч, гэрч, яллагдагч 13 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр томилогдон, хүүхдийн эрхийг хамгаалж, эцэг эх асран хамгаалагч нарт хууль эрх зүй, сэтгэл зүйн зөвлөгөө, мэдээлэл хүргэн, өмгөөлөл, эрүүл мэндийн үйлчилгээнд холбон зуучилсан.</p> <p>Хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулснаар нийт 3000 орчим иргэнийг хамруулж, холбогдох байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах зорилгоор 7 байгууллагатай хамтарсан төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлснээр одоогийн байдлаар 90 хувийн хэрэгжилттэй байна.</p> <p>2024 оны 11-р сарын байдлаар хүүхдийн эрхийн зөрчил, үе тэнгийн дээрэлхэлд, хүүхдийн мөнгөн тэтгэмж зэрэг 58 өргөдөл хүлээн авч, 100 хувь шийдвэрлээд байна.</p>	
43		Эрсдэлийн программд бүртгэгдсэн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийг	2021-2024	ГБХЗ ХГ	БТСГ	Улсын төсөв	40.0	Эрсдэлийн программд байгаа хүүхдүүди	Эрсдэлийн программд байгаа хүүхдүүди	10.0	2021-2023 онд: Улсын төсөв 136.0	2021-2024 онд улсын хэмжээнд хэрэгжүүлдэг эрсдэлийн программд бүртгэлтэй эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, хөгжил, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Хүүхдийн ордны урлаг,	100%

		хөгжлийн үйлчилгээнд хамруулах						йн 6% хамруулсан.	йн 10% хамруулсан байна.		2024онд улсын төсөв 50.0	соёл, спортын 7 төрлийн хөтөлбөр, “Янзага” зуслангийн зуны хөтөлбөр, “Номин” даатгал, эрүүл мэнд, хууль эрх зүйн холбон зуучлах үйлчилгээнд давхардсан тоогоор 1123 хүүхдийг хамрууллаа. Тайлант онд “Зуслан” хөтөлбөр, “Номин” даатгалын үйлчилгээ, хүүхдийн ордны хөгжлийн хөтөлбөрийн ардын бүжиг, хар уран зураг, шатар, төгөлдөр хуур, математик, гадаад хэл зэрэг дугуйлан сургалтад 497 хүүхэд хамруулсан нь эрсдэлт Эрсдэлийн программд байгаа хүүхдүүдийн 81 хувийг хамруулсан байна.	
44		Түр хамгаалах байрны үйл ажиллагааг сайжруулах	2022-2024	ГБХЗ ХГ	ХЭЗХ ЦГ	Улсын болон орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Үйлчлүүлсэн иргэдийн тоо	Хамгаалах байрны, үйл ажиллагаа тогтмолжсон байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	2021-2023 Орон нутгийн төсөв-101.0 2024онд Орон нутгийн төсөв 45.0 Олон улсын байгууллагаас 18.0	2021-2024 онд түр хамгаалах байраар нийт 249 үйлчлүүлэгч хүлээн авсныг гэр бүл тус бүрээр нь кейс, бүртгэл нээн хамгааллын үйлчилгээ, хооллох, хувцаслах, усанд оруулах зэрэг үйлчлүүлэгчийн суурь хэрэгцээг хангаж үйлчилгээ үзүүлэх төдийгүй “Түр хамгаалах байр”-аар үйлчлүүлсэн өрхүүдэд эргэх хяналтыг хийж ажиллаж ирлээ. Түр хамгаалах байрны үйлчилгээг Баян-Өндөр сумын Чандмань багийн орон сууцны хороололд 3 өрөө байрыг түрээслэн, нийгмийн ажилтан 1, үйлчлэгч 1, ний 2 орон тооны ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна. Түр хамгаалах байрны чанар стандарт, өдөр тутмын үйл ажиллагаанд Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын газар байнга хяналт тавьж, үйлчилгээг үзүүлж байна. Үүнээс тайлант онд түр хамгаалах байраар 78 иргэн үйлчлүүлснээс 15 нь насанд хүрэгчид, 63 нь хүүхэд үйлчлүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 27 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь түр хамгаалах байрны үйл ажиллагаа тогтмолжсон үр дүнтэй байна. Түр хамгаалах байранд ирсэн дуудлага мэдээллийг ангилан үзвэл: Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл 6, үл хайхрах хүчирхийллийн дуудлага мэдээлэл 8, бэлгийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл 3, сэтгэл санааны хүчирхийллийн дуудлага мэдээлэл 2, бие махбодын хүчирхийллийн дуудлага мэдээлэл 3 тохиолдол тус тус бүртгэгдэж тухайн дуудлагын дагуу 26 кейс нээж ажилласан байна. “Дээрэт” олон улсын байгууллагатай хамтран хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр	100%



												хамгаалах байрны дотоод орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр 18.0 сая төгрөгийн санхүүжилтийг авч эд хогшил болон тохижилтын ажлыг гүйцэтгэснээр үйлчилгээний орчин нөхцөл сайжирсан үр дүнтэй байна.	
45	2.1.3.Залуучуудад чиглэсэн арга хэмжээ, нөлөөллийн үйл ажиллагааг идэвхжүүлж, тэдний оролцоог дэмжинэ.	Залуучуудад чиглэсэн амьдрах ухаан, гэр бүлийн боловсрол олгох, нөхөн үржихүйн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг сайжруулах	2021-2024	ГБХЗ ХГ	Баян-Өндөр сумын ЗДТГ	Улсын төсөв	32.0	Залуучуудын хамрагдалт 25%	Залуучуудын хамрагдалт 45%-д хүрсэн байна.	8.0	2021-2023 онд Улсын төсөв 18.0 Орон нутгийн төсөв 78.0 2024 онд Орон нутгийн төсөв 12.0	2021-2024 онуудад өсвөр үе залуучуудад зориулсан онлайн болон танхимын багц сургалт нөлөөллийн ажлыг 145 багц арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 18130 өсвөр үе, залуучууд хамрагдсан нийт залуучуудын 82 хувийг хамруулсан. Энэ хугацаанд Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд амьдрах ухааны сургалт буюу амьдрах ухааны 12 модуль сургалтыг ШШГГ-ын 437-р хорих анги, зан үйлийн сургалтад хамрагдаж буй өсвөр насны хүүхдүүд, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн оюутан, сурагчдад нийт 53 удаагийн сургалт явуулж давхардсан тоогоор 12000 гаруй иргэнийг хамруулсан. Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд амьдрах ухаан, сургалт нөлөөллийн арга хэмжээнд жөндөр мэргэжил сонголт, хорт зуршил нийгэмд залуусын оролцоо сэтгэл зүйн чиглэлийн 598 постер зөвлөмжийг хийж мэргэжил сонголт, сэтгэл зүйн чиглэлийн 598 постер зөвлөмжийг хийж, цахимаар өсвөр үе залуучуудад сурталчилсан нь 64216 хандалт авсан. 2024 онд Залуучуудад чиглэсэн амьдрах ухаан, гэр бүлийн боловсрол олгох, нөхөн үржихүйн сургалт, сэтгэл зүйн нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд нийт 35 багц сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулж давхардсан тоогоор 5350 залуучуудыг хамруулсан байна. Уг арга хэмжээнд "Уянга өдөр өнжүүлэх төв"-ийн багш нарт "Хандлага ба Харилцаа", "Залуу манлайлагч хөтөлбөр"-ийн сургалт, гар урлалын "Лаа хийж суръя", "Зорилготой хүүхэд - Бидний ирээдүй", байгууллага хамт олны бүлгийн уулзалт сургалт, өсвөрийн сэтгүүлч клубийн чадавхжуулах сургалт, слайд буюу PPT-хэрхэн загварлаг бэлтгэх мэдлэг олгох сургалт, Ерөнхий боловсролын 7-12 ангийн сурагчдад "Өсвөр насны хүүхдийн сэтгэл зүйн онцлог" , Орхон аймгийн Дартсын холбооны дэргэдэх дартсын спорт сонирхдог өсвөр үеийнхэнд зориулсан сургалт, Canva	100%

												программын анхан шатны мэдлэг олгох, Толът жиргээ өсвөрийн сэтгүүлч клубтэй хамтран уншсан номоо хамтдаа ярилцъя , арьс арчилгаа, нүүр будалт make up-ын сургалт, Хятад хэл, Солонгос хэл болон Unitel Hub-Хүүхдийн зохион бүтээх чадварыг хөгжүүлэх Робот угсралт инженерчлэл, Эх оронч залуу гэх мэт олон талт сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулснаар 10560 иргэн хамрагдаж нийт залуучуудын 48% хамруулсан.	
46		Залуучуудын ордны үйл ажиллагааг тогтмолжуулах	2021-2024	ГБХЗ ХГ	Залуучуудын ордон	Улсын болон орон нутгийн төсөв	-	Тохижилт хийгдсэн байна.	Үйл ажиллагаа жигдэрсэн байна.	224.0	Орон нутгийн төсөв 1.0	<p>2021-2024 онд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжтэй хамтран чуулган, хэлэлцүүлэг, сургалт, өдөрлөг, үзэсгэлэн арга хэмжээ зэрэг нийт 220 төрлийн сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулж, давхардсан тоогоор 57460 залуучуудыг хамруулсан нь залуучуудын ордноор үйлчлүүлсэн иргэдийн тоо 2021 оноос 18.2 хувиар нэмэгдсэн үр дүнтэй байна. Мөн Залуучуудын ордны "Орхон аймаг залуучуудын хөгжлийн төв" цахим пэйж хуудсаар дамжуулан өдөр тутмын үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг байршуулж ирсэн ба тус цахим хаягт 52000 хандалттай байна. Орон нутгийн төсвөөс Залуучуудын ордны үйл ажиллагааг тогтмолжуулах зорилгоор шинээр 12 ажлын байрыг бий болгож, үйл ажиллагааны болон тоног төхөөрөмжийн зардалд 2021 онд 457.0 сая, 2022 онд 156.0 сая, 2023 онд 150.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон. Мөн НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн төслийн хүрээнд 40.0 сая төгрөгийн санхүүжилтээр лед дэлгэц, залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх дундын оффис байгуулсан.</p> <p>2024 онд залуучуудын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй залуучууд болон өсвөр үе залуучуудад чиглэсэн нийт 32 төрлийн нөлөөллийн аян, арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 6650 залуучуудыг хамруулсан байна. Залуучуудад чиглэсэн амьдрах ухаан, гэр бүлийн боловсрол олгох, нөхөн үржихүйн сургалт, сэтгэл зүйн нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд нийт 48 сургалт нөлөөллийн үйл ажиллагаанд давхардсан тоогоор 4200 залуучуудыг хамруулсан. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнес сайн дурын</p>	100%

												ажлыг дэмжих холбон зуучлах ажлын хүрээнд "Ирээдүйн эзэд" мэргэжил сонголтын үндэсний аяныг зохион байгуулсан. Аяны үйл ажиллагаанд ерөнхий боловсролын 8 сургуулийн 9-12 дүгээр ангийн 150 гаруй сурагчид оролцсон. Залуучуудын ордны дэргэдэх сонирхлын 9 клубын залуучуудыг идэвхжүүлэх сургалт нөлөөллийн 10 багц ажлыг хамтран зохион байгуулж 1020 залуучуудыг хамрууллаа. Тайлант хугацаанд 72 арга хэмжээнд 9280 залуучуудыг хамруулсан нь аймгийн хэмжээний нийт залуучуудын 42.2 хувьд хүрч ажилласан байна.	
47		Сайн дурын ажилд залуучуудын оролцоог дэмжих, сайн дурын ажилтнуудыг бүртгэлжүүлэх, холбон зуучлах ажлыг зохион байгуулах	2021-2024	ГБХЗ ХГ	ХХҮГ	Улсын төсөв	4.0	Сайн дурын ажилд хамрагдаг сдын тоо 25	Сайн дурын ажилд хамрагдаг сдын тоо 45	1.0	2021-2023 онд Улсын төсөв 10.0 Орон нутгийн төсөв 25.0 2024 онд Орон нутгийн төсөв 8.0	2021-2024 онд байгууллага аж ахуй нэгж, багийн залуучуудын салбар зөвлөлийг уриалж, 60 гаруй байгууллага, 22 багийн залуучуудын салбар зөвлөл нэгтгэн, 120 гаруй сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулж 8200 гаруй залуучууд, олон талт сайн дурын үйл ажиллагаанд хамрагдаж хүүхдийн тоглоомын талбайг засаж сайжруулах, тохижилтын ажил, сайн үйлсийн аян зэргийг зохион байгуулж ажилласан. Үүнээс бүтэн өнчин 19 настай нэг залууг амьдрах гэртэй болгож, хашааны газрыг нь шийдэж, ажил орлоготой болгосон. Үүнээс 2024 онд сайн дурын ажил хийх сонирхолтой 20 гаруй залуучуудыг шинээр бүртгэлжүүлж сайн дурын үйл ажиллагаанд холбон зуучилж ажилласан. Орхон аймгийн Баян-Өндөр сумын 25 багийн залуучуудын салбар зөвлөлийн залуучуудтай хамтран "Нэг баг, Нэг санаачилга" аялах дэвтэр аяны хүрээнд нийт 32 сайн дурын ажил санаачлан зохион байгуулан ажиллаж байна. Залуучуудын ордноос санаачлан "Ном хандивлах-14" хоногийн аяныг зохион байгуулж "Явуулын Номын сангийн" үйлчилгээг Зэвсэгт хүчний 110-р цэргийн анги, ШШГГ-437-р ангид очиж үзүүлэн, зорилтод бүлгийн хүүхэд, залуучуудын оюунд хөрөнгө оруулах, унших номыг нь өргөжүүлэх зорилгоор ном бэлэглэх арга хэмжээг зохион байгууллаа. Ерөнхий боловсролын сургуулийн "Тольт жиргээ" өсвөрийн сэтгүүлч клубтэй хамтран "Уншсан номоо хамтдаа ярилцъя", Энхтайвны корпусын сайн дурын ажилтнуудтай хамтран Ментор хөтөлбөрийн сургалт, өглөөний алхалт, флашмоб, "хамтдаа алхаж" арга хэмжээ, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудыг	100%

												хөгжүүлэх Найдвар төвд очиж сайн дурын ажил, "Өргөө кино театр"-ын урд талын явган замын цас цэвэрлэх, Эрдэнэ багийн ганц бие өндөр настанд түлээ бэлдэх, хашааны өвс цэвэрлэх зэрэг 35 удаагийн сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулж давхардсан тоогоор 5920 залуусыг хамруулсан. /Цахим хандалт 14600/	
48		"Өндөр ёс зүйтэй-өөдрөг иргэд" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2021-2024	НБХ	ГБХЗ ХГ	Орон нутгийн төсөв	30.0	Хөтөлбөрийн хэрэгжилт 65%	Хөтөлбөр хэрэгжиж дуусна.	-	Орон нутгийн төсөв 30.0	100%	

												түүнийг шийдвэрлэх аргачлалын талаар шаталсан хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд зохион байгуулсан нийт арга хэмжээнд 2019- 2022 онд 20000 гаруй иргэд, өсвөр үе залуучуудыг хамруулсан байна. Тус хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж 92% - ийн хэрэгжилттэйгээр дүгнэгдэн хэрэгжиж дууссан.	
49	2.1.4.Ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, төсөл хэрэгжүүлнэ.	“Ач санах” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2021-2024	НБХ	Аймгийн ахмадын хороо	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Хэрэгжилтийн хувь 100%	Батлагдсан төсвийн хүрээнд	2021-2023 онд Орон нутгийн төсөв 170.0  2024 онд Орон нутгийн төсөв 80.0	Ахмад настны Ач санах хөтөлбөр нь 3 зорилтын хүрээнд 20 үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2024 онд хөтөлбөрийн хүрээнд: Олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Зэвсэгт хүчний 103 жил, Монгол цэргийн бахархлын өдөрт зориулсан хүндэтгэлийн арга хэмжээ, “Эх үрийн элбэрэл” тоглолт, Ахмадын баяраар “Ахмадууд дуулж байна” урлагийн наадам, Ахмад настны тухай хуулийг сурталчлан таниулах сургалт, орон нутгийн аялал, аймгийн аварга шалгаруулах волейбол, софт волейбол, үүргэвчтэй аялал тэмцээн, мөн сар бүрийн 15-нд ахмадын “Дуулах өдөр” дуун цэнгүүн зэрэг ахмад настанд чиглэсэн 17 удаагийн арга хэмжээнүүдэд давхардсан тоогоор 14000 гаруй ахмад хамрагдсан байна. Орхон аймгийн ХХҮГ, Улаан загалмайн хороо хамтран Жаргалант сумын 50 ахмад, Баян-Өндөр сумын 100 ахмад настныг өдрийн үйлчилгээнд хамруулсан. Сар шинийн баярыг тохиолдуулан 3350 ахмадуудад Засаг даргын хүндэтгэл үзүүлж, зуны саам амралтад 250 ахмадыг амрах нөхцөлөөр хангаж ажилласан. Хөтөлбөрийн хүрээнд дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр хөтөлбөр 100 хувийн хэрэгжилттэй байна.	100%
50		“Анхдагч” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2021-2024	НБХ	ТББ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Хэрэгжилтийн хувь 100%	Батлагдсан төсвийн хүрээнд	2021-2023 онд Орон нутгийн төсөв 11.0  2024 онд Орон нутгийн төсөв 70.0	Анхдагч дэд хөтөлбөр нь 3 зорилт 10 үндсэн үйл ажиллагааг ажиллагааг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Хөтөлбөрийн хүрээнд МАНЗ-Баатар холбоо, төрийн байгууллагуудын Соёмбо холбоо, Эрдэнэтийн овооны анхдагч илгээлтийн эздийн холбоо, Барилгачин дайчдын холбоо, Залуу насаа эргэн дурсахуй холбооны гишүүдийн дунд зохион байгуулах олон талт үйл ажиллагааны зардалд 29.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Тус дэмжлэгийн хүрээнд хүнд нөхцөлд амьдарч буй 23	100%

											Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хамтын ажиллагааны хүрээнд 2300.0	анхдагчид тусламж, хэвтрийн өвчтэй 65 анхдагчид гэрийн эргэлт, ахмадын сувилалд 86, өдөр өнжүүлэх үйл ажиллагаанд 41 анхдагч тус тус хамрагдсан. Мөн илгээлтийн эздийн 50 жилийн ойн баярыг аймгийн баяр наадамтай хамтатган тэмдэглэн өнгөрүүлж нийт 2200 ахмадуудад 2.3 тэрбум төгрөгийн урамшуулал олгож, 3000 анхдагч ахмадыг 50 жилийн ойн медалиар шагнасан. Тэмдэглэлт өдрүүдийн арга хэмжээг 1, сургалтын үйл ажиллагаа 2, туршлага судлах уулзалт аялал 1, спортын урлагийн 2 төрөлт тэмцээн Эрдэнэт хотын өдөр, анхдагчийн өдөр зэргийг зохион байгуулж 700 гаруй анхдагч, ахмадууд хамрагдсан байна. Хөтөлбөрийн хүрээнд дээрх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр хөтөлбөр 100 хувийн хэрэгжилттэй байна.	
51	2.1.5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өрнүүлэх	2021-2023	ГБХЗ ХГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Хөтөлбөрийн хэрэгжилт 20%	Хөтөлбөр хэрэгжиж дуусна.	-	Орон нутгийн төсөв 50.0	Хөтөлбөрийн хүрээнд 2021-2023 онд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн боловсрол олгох 13 төрлийн 38 арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 25000 иргэн хамруулсан. Мөн цахим нөлөөллийн 12 шторк, 6 нэвтрүүлэг, 220 постер мэдээ, мэдээлэл бэлтгэн мэдээлсэн ба хандалт 283107 байна. 2024 онд жендэрийн салбар зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж, тайлант онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан 25 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлснээр Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээнүүдэд нийт 5590 иргэнийг хамруулсан байна. Үүнд: “Батгэгээн эрдэм” төрийн бус байгууллагатай хамтран “Жендэр ба үе тэнгийн харилцаа” сэдэвт сургалт ярилцлагыг үе шаттай зохион байгуулж, 12 сургуулийн 1440 гаруй өсвөр залуучуудыг хамруулсан. Үе тэнгийн дээрэлхэлт, хорт зуршлын талаарх мэдлэг мэдээлэл дээшилсэн. Өсвөр насны охид эмэгтэйчүүдэд “Шүүдэр охидын төв”-өөр дамжуулан нөхөн үржихүйн эрүүл мэнд, гадаад хэл, амьдрах ухаан, хувь хүний хөгжил зэрэг сургалт нөлөөллийн 12 төрлийн арга хэмжээг зохион байгуулж 1500 өсвөр үе охидыг хамруулснаар нөхөн үржихүйн эрүүл мэнд, жендэрт суурилсан хүчирхийллээс	93.0%

												<p>өөрийгөө хамгаалах мэдлэг мэдээлэлтэй болсон.</p> <p>Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч иргэдэд сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлдэг "Гэр төсөл"-ийн сэтгэл зүйч Мөнхмаа-д 3.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Жендерийн үндэсний хорооноос зохион байгуулсан "Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг багасгахад 2024-2027 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээ"-ний арга хэмжээний талаар танилцуулах 3 удаагийн онлайн сургалтад жендерийн салбар хороо, Баян-Өндөр, Жаргалант сум, төрийн байгууллагын нийт 150 гаруй албан хаагч хамрагдаж мэдээлэл авсан.</p> <p>Мөн жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг 16 хоногийн аяныг "Охид эмэгтэйчүүд хаана ч аюулгүй" уриан дор зохион байгуулна.</p> <p>Монгол улсын их сургуулийн Болдхүү багштай хамтран "Жендэр ба авлига" тандалт судалгааг цахим болон цаасаар явуулж, нийт 2500 гаруй иргэн хамрагдсан.</p> <p>Дээрх арга хэмжээнүүдийг зохион байгуулснаар одоогийн байдлаар хөтөлбөрийн хэрэгжилт 93 хувьтай байна.</p>	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАЛАМЖ**

**2.2.Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг хуулийн хүрээнд чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэнэ.**

52	2.2.1.Нийгмийн халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулна.	Нийгмийн халамжийн үйлчилгээг ehalamj системд шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэх	2020-2024	ХХҮГ	НБХ	Улсын төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	10%	100%	Батлагдсан төсвийн хүрээнд	-	<p>"Цахим Монгол" хөтөлбөрийн хүрээнд 2020 оны 08 дугаар сараас эхлэн нийгмийн халамжийн үйлчилгээ нь ehalamj.mn цахим системд үе шаттайгаар шилжиж эхэлсэн. 2020 онд 6, 2021 онд 26 төрлийн үйлчилгээ дээрх системд шилжүүлснээр 2023 оноос нийгмийн халамжийн 72 төрлийн үйлчилгээ 100% цахимжсаны үр дүнд иргэд нийгмийн халамжийн үйлчилгээнд цахимаар хамрагдан өргөдөл хүсэлтээ гаргах боломж бүрдэж, иргэдийн цаг хугацааг хэмнэн тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь чирэгдэлгүй олгож хэвшсэн. 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжид давхардсан тоогоор 80446 иргэн хамрагдаж 52.8 тэрбум төгрөг зарцуулсан.</p>	100%
53	2.2.2.Хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээ,	Нийгмийн халамжийн багц хуулийн хүрээнд нийгмийн	2020-2024	ХХҮГ	-	Улсын төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	40000 /давхардсан тоогоор/	42000 /давхардсан тоогоор/	Батлагдсан төсвийн хүрээнд	2021-2023 улсын төсөв 97700.0	<p>Нийгмийн халамжийн багц хуулийн хүрээнд 2020-2023 онуудад давхардсан тоогоор 209107 иргэнд нийгмийн халамжийн 72 төрлийн үйлчилгээг хүргэхэд 112.2 тэрбум төгрөг</p>	100%

	шаардлагад нийцүүлэн нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлнэ.	халамжийн 72 төрлийн үйлчилгээг үзүүлэх					хүрээнд				2024 онд Улсын төсөв 52800.0	нийгмийн халамжийн сангаас зарцуулжээ. 2023 оны 01 дүгээр сараас хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийгмийн халамжийн сангаас бүх хүүхдэд олгож эхэлсэн. 2024 онд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжид давхардсан тоогоор нийт 80441 иргэн хамрагдаж, 52.8 тэрбум төгрөг нийгмийн халамжийн сангаас зарцуулсан бол хүүхдийн мөнгөн тэтгэмжид 39187 хүүхэд хамрагдаж 35.1 тэрбум төгрөг зарцуулсан.	
54	2.2.3.Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих нөхцөлд мөнгөн тусламж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хуулийн хүрээнд чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэнэ.	Орон нутгийн төсвөөс санхүүжиж байгаа онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж, /5 төрөл/ олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг (8 төрөл) хуулийн хүрээнд чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх	2020-2024	ХХҮГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	430 иргэн	500 иргэн	Батлагдсан төсвийн хүрээнд	2021-2023 онд орон нутгийн төсөв 1027.2 2024 онд Орон нутгийн төсөв 160.3	2020-2023 онд нийгмийн халамжийн үйлчилгээнд орон нутгийн төсвөөс 532.7 сая төгрөг батлагдсан. Онцгой тохиолдлын тэтгэмжид 161 иргэнд 188.8 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд 12 төрийн бус байгууллагатай хамтран 1239 иргэнийг хамруулсан зорилтот арга хэмжээнд 306.5 сая төгрөгийг зарцуулсан. 2024 онд онцгой тохиолдлын тэтгэмжид 48 иргэн хамрагдаж, 57.6 сая төгрөгийг нийгмийн халамжийн сангаас зарцуулсан. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг 5 байгууллагатай гэрээлэн гүйцэтгүүлж, 355 иргэнийг хамруулан 80.3 сая төгрөгийг зарцуулсан. "Аминчхан яриа" ТББ-тай гэрээ байгуулан байнгын асаргаа шаардлагатай иргэдийн асран хамгаалагч болох 60 иргэнд асаргааны сургалт зохион байгуулж 4.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөлд 12 бүлгийн 24 иргэний төсөл шалгарч 18.4 сая төгрөгийн дэмжлэгийг бүцэлтгүйгээр олгосон..	100%
76		"Эх хэл-Эрдэнэт" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2020-2024	БШУГ	СӨББ ЕБС	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	20.0	-	Хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	5.0	2021-2023 Орон нутгийн төсөв 56.0 2024 онд орон нутгийн төсөв 20.0	Аймгийн ИТХ-ын 2021 оны 04 дүгээр тогтоолоор "Эх хэл-Эрдэнэт" хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрийн хэрэгжилт 2021 онд 84.6 хувь, 2022 онд 82.3 хувь, 2023 онд 85.4 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна. Хөтөлбөрийн 2024 оны хэрэгжилт урьдчилсан гүйцэтгэлээр 90 хувьтай байна. 2021-2024 онд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын үр дүнд төрийн байгууллагуудын 90 хувь нь, хувийн хэвшлийн байгууллагуудын 15 хувь нь хос бичгийн хаягтай болсон байна. Мөн 2021-2024 онд монгол бичгийн анхан, дунд шатны сургалтуудад давхардсан тоогоор нийт 39 байгууллагын 1287 албан хаагчийг хамруулж, үндэсний бичгийн анхан, дунд шатны мэдлэг олгосон байна. Үндэсний статистикийн хорооноос 2021 онд явуулсан "Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа"-нд хамрагдсан төрийн албан хаагчдын 23 хувь нь "Үндэсний бичгийн мэдлэггүй" гэж хариулж байсан бол 2024 онд 20.4 хувь болж 2,6 хувиар буурч, "Үндэсний бичгийн анхан шатны мэдлэгтэй" гэж хариулсан албан хаагчийн хувь 2021 онд 25.8 хувь байсан бол 2024 онд 31.1 болж 5.3 хувиар, "Үндэсний бичгийн дунд шатны мэдлэгтэй" гэж хариулсан албан хаагчийн хувь 2021 онд 31.3 хувь байсан бол 2024 онд 33.3 хувь болж 2 хувиар, үндэсний бичгийн мэдлэг "Маш сайн", "Сайн" гэж хариулсан албан хаагчийн хувь 2021 онд 9.9 хувь байсан бол 2024 онд 11.7 хувь болж 1.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Тус судалгаанд 2024 онд хамрагдсан 4652 төрийн	90%

												албан хаагчийн 64.4 хувь нь буюу 2995 албан хаагч үндэсний бичгийн анхан, дунд шатны мэдлэгийг эзэмшсэн гэсэн судалгааны үр дүн гарсан байна. Тайлан хугацаанд аймгийн хэмжээнд нийт 116 төрийн байгууллагын хэвлэмэл хуудсыг хос бичигт шилжүүлж албан хэрэгт ашиглах боломжийг бүрдүүлсэн. ЕБС-ийн сургуулийн Монгол хэлний хичээлийн масс сургалтын чанар 2020 онд 45.3 хувь байсан бол 2021 онд 47.3 хувь, 2022 онд 53.4 хувь, 2023 онд 53.6 хувь, 2024 онд 57.4 хувь болж өссөн байна.	
77	Олон улс, улсын түвшинд зохион байгуулагдаж буй олимпиад, уралдаан тэмцээнд оролцох багш, сурагчдад дэмжлэг үзүүлж, амжилт гаргасан багш, сурагчдыг урамшуулах	2021-2024	БШУГ	ЕБС	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Дэмжлэг үзүүлж, урамшуулна.	Батлагдсан төсвийн хүрээнд	2021-2023 онд: Орон нутгийн төсөв 6.3	2022 онд улсын олимпиадад оролцож медаль хүртсэн 9 сурагч, 5 багш, сурагчдыг бэлтгэсэн багш нарт 4.0 сая төгрөгийн, 2023 онд улсын олимпиадад оролцож медаль хүртсэн 7 сурагч, 2 багш, сурагчдаа бэлтгэсэн багш нарт 2.3 сая төгрөгийн урамшуулал тус тус олгосон байна. 2024 онд улсын төрөлжсөн олимпиадын багш, сурагчийн төрөлд Орхон аймгийн багш, сурагчид 35 шагналт байр, 29 медальт байр эзэлсэн. Багшийн төрөлд 7 шагналт байр, мөнгө 2, хүрэл 2, тусгай байр 3, сурагчийн төрөлд 28 шагналт байр, алт 3, мөнгө 8, хүрэл 14, тусгай 3 эзэлсэн нь өмнөх оноос алт 3, мөнгө 7, хүрэл 10, тусгай байр 3-аар нэмэгдсэн байна. Мөн математик, физикийн судлагдахуунууд 12 дугаар ангийн төрөлд оролцсон 2 сурагч олон улсын олимпиадад амжилттай оролцсон. Эдгээр багш сурагчдыг аймгийн Засаг даргын 2015 оны А/345 дугаар захирамжаар баталсан "Урлаг, спорт, сурлагын онцгой амжилт гаргасан уран бүтээлч, тамирчин, сурагч, тэдний бэлтгэсэн багш, дасгалжуулагчдыг урамшуулах" журмын дагуу 2025 онд шагнаж урамшуулна. 2021-2024 онд олон улсын олимпиадаас 3, улсын олимпиадаас алт 4, мөнгө 13, хүрэл 29, тусгай 10, нийт 56 шагналт байр эзэлсэн байна	100%	
78	Үндэсний ёс заншил, эх оронч сэтгэлгээ, амьдрах ухаанд суралцуулах агуулга бүхий цахим контент хийх, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр мэргэжлийн	2021-2024	БШУГ	СӨББ ЕБС	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Цахим контент хийнэ.	Батлагдсан төсвийн хүрээнд	-	2022 онд олон улсын эко сургууль, цэцэрлэг төсөлд хамрагдаж буй 4, 5, 14, 15 дугаар сургуулиуд өөрийн онцлогтой ардын зан заншил, байгаль экологийн боловсрол олгох, амьдрах арга ухаанд сургах хөтөлбөртэй болж, улс, аймгийн хэмжээнд туршлагаа түгээн дэлгэрүүлэн ажиллаж байна. Дээрх 4 сургуульд хэрэгжүүлж буй "Ардын ёс заншил", "Дотоод агаарын чанар", "Цахилгааны хэмнэлт", "Байгалийн ухаан" төслийн хүрээнд БОАЖЯ, БШУЯ, Байгаль орчны мэдээлэл, сургалтын	100%	

		байгууллага, иргэдтэй хамтран ажиллах									төв, Монголын үндэсний олон нийтийн телевизтэй хамтран цахим контент хийж олон нийтийн хүртээл болгон, БОАЖЯ-ны төлөөллийг оролцуулан аймгийн хэмжээнд үзүүлэх ажил зохион байгуулсан. 2023 онд Баян-Өндөр сумын ИТХ, БШУГ хамтран "Суралцагч хот хөтөлбөр"-ийн хүрээнд СӨББ-ын хэмжээнд бага насны хүүхдийг үндэсний ёс заншил, эх оронч сэтгэлгээ, амьдрах ухаан, зөв дадал хэвшилд сургах зорилготой цахим контент хийж олон нийтэд хүргэсэн. Мөн "Найз байя" аяныг өрнүүлж, зам тээврийн осол, ахуйн ослоос урьдчилан сэргийлэх агуулга бүхий 5 цахим контент бэлтгэж түгээсэн байна. 27-р цэцэрлэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн талаар 8 цуврал подкаст бэлтгэж эцэг, эх, асран хамгаалагчид хүргэснээр 350 хандалт авч, 113 хүн хуваалцсан байна. 2024 онд өсвөр үеийн хүүхэд, залууст монгол ёс заншил, нүүдэлчин соёл иргэншил, үндэсний давтагдашгүй ижилсэл ба ондоошилд суурилсан угсаатнуудын хэл аялгууг судлах, биет бус өвийг өвлүүлэх, үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бүтээх үзэл санааг уриалах зорилгоор "Өв соёлоо түгээе" эвент өдөрлөгийг аймгийн нийт сургууль, цэцэрлэгийн хүрээнд 2 удаа амжилттай зохион байгуулсан. Тус эвент өдөрлөгт 2 үндэстэн 12 ястны 05-18 насны 34 өв тээгч оролцож, ЕБС-ийн 223 суралцагч, сайн дурын сонирхогч 104, нийт 361 иргэн хамрагдсан.		
79		Боловсролын чиглэлээр улс, бүсийн чанартай 1-ээс доошгүй арга хэмжээг жил бүр орон нутагтаа зохион байгуулах (Олимпиад, уралдаан, тэмцээн, хурал, зөвлөгөөн)	2021-2024	БШУГ	СӨББ ЕБС	Орон нутгийн төсөв, хөтөлбөр	Батлагдсан төсвийн хүрээнд	-	1 арга хэмжээ зохион байгуулна	Батлагдсан төсвийн хүрээнд	2021-2023 онд. Орон нутгийн төсөв 79.4 2024 онд: Орон нутгийн төсөв 39.9	2022 онд улсын Нийгмийн ухааны 24-р олимпиадыг зохион байгуулж, 21 аймаг, 9 дүүргийн 30 багш, 30 сурагч оролцсоноос Орхон аймгийн 14-р сургуулийн багш О.Эрдэнэболд III байранд шалгарсан. Олимпиадыг БШУЯ, аймгийн ЗДТГ, БШУГ, МУБИС, 14-р сургууль хамтран зохион байгуулсан ба олимпиадын зардалд орон нутгийн төсвөөс 39.5 сая төгрөг зарцуулсан. 2023 онд улсын биологийн 33 дугаар олимпиадыг зохион байгуулж, 21 аймаг, 9 дүүргийн, нийт 60 сурагч, 31 багш оролцож орон нутгийн төсвөөс 39.9 сая төгрөг зарцуулсан байна. Олимпиадын хүрээнд аймаг, орон нутгаа улсын хэмжээнд сурталчилж, орон нутгийн аж ахуй нэгж байгууллагуудыг дэмжиж хамтарч	100%

												<p>ажилласан. Мөн биологийн шинжлэх ухааныг орон нутгийн хэмжээнд сурталчилж, энэ чиглэлийн мэргэжлийн багш нарыг чадавхжуулах үйл ажиллагааг МУИС-тай хамтран зохион байгуулсан.</p> <p>2024 онд Монгол, хэл бичгийн улсын 53 дугаар олимпиадыг орон нутагтаа амжилттай зохион байгуулж, 21 аймаг, 9 дүүргийн 60 багш, 30 сурагч оролцож, олимпиадын үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 39.9 сая төгрөг зарцуулсан байна. Олимпиадын хүрээнд багш, сурагчдын монгол хэл, бичгийн мэдлэг, чадварыг сайжруулах сургалтуудыг олимпиадын дэд хороотой хамтран зохион байгуулсан. Мөн аймгийн мэргэжлийн багш нарын зохиосон ном, гарын авлагыг багш, сурагчдад дурсгал болгон өгсөн нь бусад орон нутагт өөрийн багш нарын арга туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд чухал ач холбогдолтой үйл ажиллагаа болсон.</p>	
80		ЕБС-иудад Хүүхдийн хөгжил, төлөвшлийн ажилтнуудыг үргэлжлүүлэн ажиллуулж, сэтгэл зүйч мэргэжилтэй боловсон хүчнээр хангах	2020-2024	БШУГ	ЕБС	-	-	17	Сэтгэл зүйч ажиллуул ах 2 сургуульд	-	-	<p>Аймгийн хэмжээнд 2022 оноос төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудад 17 тэгш боломж, хүүхдийн хөгжил хариуцсан ажилтан, 19 сэтгэл зүйч ажиллаж эхэлсэн.</p> <p>ЕБС-д ажиллаж буй сэтгэл зүйчдийн 84.2 хувь нь "Боловсролын сэтгэл зүйч" байна.</p> <p>Тайлант хугацаанд ЕБС-ийн сэтгэл зүйчид сэтгэл зүйн гарааны үнэлгээг 2601 сурагч, 170 эцэг эх, асран хамгаалагч, 306 багш, 21 удирдах ажилтанд, сэтгэл зүйн бүлгийн зөвлөгөөг 1421 сурагч, сэтгэл зүйн бүлгийн сургалтыг 17000 гаруй сурагч, 1334 багш, 68 удирдах ажилтанд явуулж сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэн 848 сурагчид хувийн хэрэг нээж ажилласан. Мөн жил бүр "Сонсьё, Хайрлая, Мэдэрье" сэтгэл зүйн өдөрлөгийг уламжлал болгон зохион байгуулж, иргэд олон нийтэд сэтгэл зүйн боловсрол олгох, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг зохион байгуулж хэвшсэн байна.</p> <p>2023 оноос ерөнхий боловсролын сургуулиудад захирал, нийгмийн ажилтан, хүүхэд төлөвшлийн ажилтан, сэтгэл зүйч нарын хамтарсан "Нийгэм сэтгэл зүйн алба"-ыг байгуулан ажилласнаар хүүхэд хамгааллын бодлогыг амжилттай хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн. 2024 онд "Гүүд нейброс" ОУБ-тай хамтран 2, 7, 15-р сургуулийн сэтгэл зүйчдийн өрөөг тохижуулж, сурагч, эцэг, асран</p>	100%

												хамгаалагчдад сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх таатай орчин, нөхцөлийг бүрдүүлсэн.	
81		Хүүхдийг цахим халдлагаас урьдчилан сэргийлэх, цахим хэрэглээний зохист байдлыг бий болгох сургалтуудыг ЕБС-ийн хэмжээнд тогтмол зохион байгуулах	2021-2024	БШУГ	ЕБС	Орон нутгийн төсөв, байгууллагын төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	ЕБС-уидад жилд 2 удаа	Батлагдсан төсвийн хүрээнд	-	<p>2021 онд ЕБС-иудын сэтгэл зүйчид хамтран хүүхдийг цахим гэмт хэргийн золиос болох, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажлыг хийж, хөл хорионы үеийн нийгэм, сэтгэл зүйн айдсыг даван туулах дэмжлэг бүхий 15 хичээлийг цахим орчинд байршуулж 1669 хүнд хүргэсэн байна.</p> <p>2022 онд дээрх ажлын хүрээнд 2 сургалт, 2 нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- "Хүүхдээ сонсох өдөр" арга хэмжээний хүрээнд ГБХЗХГ, Цагдаагийн газартай хамтран "Цахим орчны зохистой хэрэглээ-донтолт болох нь" уулзалтыг зохион байгуулж, дунд болон ахлах ангийн 130 сурагч хамрагдсан.</li> <li>- Анги удирдсан багш, эцэг эх, асран хамгаалагчдад "Цахим орчны зохистой хэрэглээ" сэдвээр танхимын сургалтыг хийж, 15674 багш, эцэг эх хамрагдсан.</li> <li>- Цахим орчны зөв хэрэглээ, дэлгэцийн донтолтоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ЕБС-иудын хүүхэд хамгааллын баг нийт 57 зурагт хуудсыг цахим орчинд байршуулж, олон нийтэд хүргэсэн байна.</li> </ul> <p>2023 онд аймгийн Цагдаагийн газартай хамтран 6-12 дугаар ангийн "Иргэний ёс зүйн боловсрол" хичээлийн цагаар цахим халдлагаас урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалтыг 2 удаа зохион байгуулсан. Энэхүү сургалтад өмчийн бүх хэлбэрийн 25 сургуулийн 283 бүлгийн 9905 хүүхэд хамрагдсан. Сургууль тус бүр ГБХЗХГ болон Цагдаагийн газартай хамтран "Цахим орчны зохистой хэрэглээ-донтолт болох нь" уулзалтуудыг зохион байгуулж, ахлах ангийн сурагчид эцэг, эх, асран хамгаалагчийн төлөөллийг оролцуулсан. Мөн энэ чиглэлээр сургуулиудын "Хүүхэд хамгааллын баг" нийт 57 зурагт хуудсыг цахим орчинд байршуулж, олон нийтэд хүргэсэн байна.</p> <p>Анги удирдсан багш, эцэг эх, асран хамгаалагчдад "Цахим орчны зохистой хэрэглээ", "Зөв хэрэглээ", сэдвээр танхимын сургалтыг хийж нийт 8900 орчим эцэг, эх асран хамгаалагч оролцсон. 2024-2025 оны хичээлийн жилд "Хүүхэд хамгааллын тухай хууль" хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан сургууль, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын</p>	100%



												багууд “Гэр айлчлал” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Ингэснээр хүүхдийн амьдарч буй орчин нөхцөлд дүгнэлт хийж, эрсдэлийг илрүүлэх, эрэмблэх, бууруулах, холбон зуучлах зэрэг хариу үйлчилгээг шаардлагатай хүүхдүүдэд үзүүлж байна. Тайлант хугацаанд ЕБС-иудын “Нийгэм сэтгэл зүйн алба”-наас цахим хуудсаараа дамжуулан 19737 хүнд цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, мэдээллийг хүргэсэн байна.	
82	3.1.4.Бүх шатны боловсролын байгууллагын багшлах боловсон хүчний мэргэжил арга зүйн хөгжлийг дэмжих, ажлын үр дүнг бодитойгоор үнэлж, дүгнэх, урамшуулах, харилцан туршлага солилцох боломжийг бүрдүүлнэ.	“Багш” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж бүх шатны боловсролын байгууллагын багшлах боловсон хүчний мэргэжил арга зүйн хөгжлийг дэмжих	2021-2024	БШУГ	СӨББ, ЕБС, Их, дэд сургууль, МСҮТ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Хөтөлбөрийн хэрэгжилтийг 100%-д хүргэнэ.	Батлагдсан төсвийн хүрээнд	2021-2023 онд: Орон нутгийн төсөв 296.0 2024 онд: Орон нутгийн төсөв 160.0	Аймгийн ИТХ-ын 2021 оны 06 дугаар тогтоолоор “Багш” хөтөлбөрийг 3 зорилт 17 арга хэмжээ, 20 үйл ажиллагаатай баталж, багш нарыг судалгаа шинжилгээний ажил хийх арга зүйд суралцуулах, анги удирдсан багшийг мэргэшүүлэх, хөгжүүлэх, багш, ажилтны ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх, Математик, Монгол хэлний хичээлийн сургалтыг сайжруулах, элсэлтийн ерөнхий шалгалт, анги нийтийн сургалтын чанарыг дээшлүүлэх зэрэг олон шинэлэг арга хэмжээг тусган хэрэгжүүллээ. Хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилт 88.2, 2022 оны хэрэгжилт 93.3, 2023 оны хэрэгжилт 94.7 хувьтай тус тус үнэлэгдсэн. 2024 онд хөтөлбөрийн үнэлгээ урьдчилсан гүйцэтгэлээр 90 хувьтай байна. Хөтөлбөрийн хүрээнд явагдсан ЭЕШ-ын чанарыг дээшлүүлэх олон талт арга хэмжээний үр дүнд хэмжээст онооны аймгийн дундаж 2020 онд 507 байсан бол 2021 онд 547.55, 2022 онд 550.33, 2023 онд 553.0, 540.8 болж тогтмол өссөн байна. Багш, ажилтнуудад чиглэсэн төрөл бүрийн сургалт үйл ажиллагааны үр дүнд сургууль, цэцэрлэгүүдийн гүйцэтгэлийн үнэлгээний хувь дээшилсэн байна. Боловсролын үнэлгээний төвтэй хамтран зохион байгуулсан багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр 1-4 дүгээр түвшинд үнэлэгдэж урамшуулал авч буй ЕБС, СӨББ-ын багшийн тоо 2022 онд 536 байсан бол 2024 онд 639, байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдсан төрийн өмчийн цэцэрлэгүүдийн дундаж үнэлгээ 2022 онд 88.02 хувь байсан бол 2024 онд 88.9 хувь, ЕБС-иудын үнэлгээ 2022 онд 74.3 хувь байсан бол 2024 онд 75.9 хувь болж тус тус өссөн үзүүлэлттэй байна. Мөн сургалтын чанарын үзүүлэлт 2020 онд 80.5 хувь байсан бол 2021 онд 89%, 2022 онд 82.6%, 2023	90%

												онд 85.2%, 2024 онд 85.4% хувь болж өссөн байна.	
83		Орон нутгийн онцлогт тохируулан сургууль, цэцэрлэг, багшийн ажлын үр дүнг бодитойгоор үнэлж, дүгнэх аргачлал боловсруулан хэрэгжүүлж, сургалтын чанар ажлын үр дүнгээр шалгарсан багш нарыг урамшуулах	2021-2024	БШУГ	СӨББ ЕБС	Орон нутгийн төсөв	40.0	20 багш	20 багш ажилтан	10.0	2021-2023 онд: Орон нутгийн төсөв 31.9	2021 онд сургалтын чанарыг дээшлүүлсэн 35 багш, эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаанд тэргүүлсэн 12 удирдах ажилтан, амжилт гаргаж ажилласан 56 багш, 9 байгууллагыг шагнаж урамшуулсан. Мөн тус онд ЭЕШ-д сурагчид нь 800 оноо авсан 9 багшийг тус бүр 500.0 төгрөгөөр шагнаж урамшуулахад орон нутгийн төсвөөс 4.5 сая төгрөг зарцуулсан. 2022 онд ажлын үр дүнгээр шалгарсан болон ЭЕШ, анги нийтийн сургалтын чанарыг дээшлүүлсэн 30 багш, удирдах ажилтан, боловсролын салбарын үйл ажиллагааг дэмжин ажилласан төрийн болон төрийн бус 6 байгууллагыг шагнаж урамшуулахад орон нутгийн төсвөөс 12.6 сая төгрөг зарцуулсан байна. 2023 онд ажлын үр дүнгээр шалгарсан болон анги нийтийн сургалтын чанарыг дээшлүүлсэн багш нарыг урамшуулах үйл ажиллагааг "Монголын багш нарын 57 дахь өдөр" -өөр зохион байгуулж 445 багш, ажилтныг шагнаж урамшуулахад 10.8 сая төгрөг зарцуулсан байна. Мөн 2023 оны элсэлтийн ерөнхий шалгалтад сурагчдаа амжилттай бэлтгэсэн 8 багшийг 4.0 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа. 2024 онд ажлын үр дүнгээр шалгарсан болон анги нийтийн сургалтын чанарыг дээшлүүлсэн багш нарыг урамшуулах үйл ажиллагааг "Монголын багш нарын 58 дахь өдөр" -өөр зохион байгуулна.	100%
84	3.1.5.Бүх шатны боловсролын байгууллагын ажилтан албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	"Багш" хөтөлбөрийн хүрээнд бүх шатны боловсролын байгууллагын багш, ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх	2021-2024	БШУГ	СӨББ ЕБС	Орон нутгийн төсөв	-	60 багш, ажилтан	Жилд 60 багш, ажилтан	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвөөр	2021-2023 онд: Орон нутгийн төсөв 46.7	"Багш" хөтөлбөрийн хүрээнд нийгмийн дэмжлэг олгох журмын дагуу 2021 онд 39 багш, ажилтанд 16.7 сая төгрөг, 2022 онд 18 багш, ажилтанд 11.0 сая төгрөг, 2023 онд шинэчилсэн журмын дагуу 36 багш, ажилтанд 19.0 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус олгосон байна. 2024 онд журмын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг 12-р сард зохион байгуулна. 2021-2024 ЕБС, СӨББ-уудын хамтын гэрээний хүрээнд эрүүл мэндийн чиглэлээр 203 багш, ажилтанд, багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр 158 багш, ажилтанд, нийгмийн бусад асуудлыг шийдвэрлэхэд 443 багш, ажилтан, нийт 804	90%

												багш, ажилтанд мөнгөн дэмжлэг тусламжийг үзүүлсэн.	
85		Шаардлагатай цэцэрлэгүүдэд багш нарыг 2 ээлжээр ажиллах нөхцөлийг бүрдүүлэх	2021-2024	БШУГ	СӨББ	Улсын болон орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Цэцэрлэгүүдэд багш нарыг 2 ээлжээр ажиллуулна.	Батлагдсан төсвийн хүрээнд	2023 онд: Улсын төсөв 651.2 2024 онд: Улсын төсөв 1042.5	2022 оны 03-р сарын 01-нээс ачаалал ихтэй 10 цэцэрлэгийн 84 бүлэгт ээлжийн 42 багш ажиллаж эхэлсэн. Ээлжийн багш ажиллаж буй 10 цэцэрлэг өглөө 07:00 цагаас орой 19:00 цаг хүртэл 12 цагаар үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд эцэг, эхчүүд ажил, хөдөлмөрөө тайван эрхлэх боломжийг бүрдүүлсэн. Ээлжийн багшаар ажиллаж буй багш нарыг ажлын байран дээрээ хөгжих боломжоор хангах ажлын хүрээнд сайжруулсан хөтөлбөрийн хэрэгжилт, зөвлөмж, үр дүнгийн талаар сорил, тест боловсруулан шалгалт авч 4 удаагийн чадваржуулах сургалтад хамруулсан.	100%
86	3.1.6.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн жирийн ангид шилжин суралцах боломжийг нэмэгдүүлэх, орчин нөхцөлийг сайжруулах, сэргээн засах үйлчилгээг нийгэм, хамт олонд нь түшиглэн үзүүлэх үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулна.	Багш, ажилтнуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамруулах	2021-2024	БШУГ	СӨББ ЕБС	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	4.0	-	2 багш	1.0	2021-2023 онд: Орон нутгийн төсөв 21.0 2024 онд:Орон нутгийн төсөв 8.2	2021 онд багш нарын мэргэжил дээшлүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш нарыг чадавхжуулах 14 удаагийн 379 багш, 2022 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт тэгш хамруулах, шаардлагатай хүүхдийг ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн чиглэлээр нийт 640 гаруй багшийг тус тус сургалтад хамруулсан. 2023 онд “Тэгш боломж” төслийн хүрээнд: -БХАН-тэй хамтран 2 удаагийн 4 кредитийн сургалтыг зохион байгуулж 62 багш хамрагдсан. -СӨБ, ЕБС-ийн дэмжлэгийн багийг чадавхжуулах сургалтыг 2 удаа зохион байгуулж, дэмжлэгийн багийн бүх гишүүдийг хамруулсан. -“Тэгш хамран сургах боловсролын соёл, бодлого, үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх нь” сургалтыг зохион байгуулж, нийт 63 багш хамрагдсан байна. Орон нутагт энэ чиглэлээр ажиллах боловсон хүчнийг нэмэгдүүлж 1 үндэсний сургагч багш, 60 орон нутгийн сургагч багш бэлтгэгдсэн байна. 2024 онд “Багшлахуй ба хүүхдийн хөгжлийн бэрхшээл” сэдэвт сургалтыг МУБИС-ийн багш нартай хамтран зохион байгуулж ЕБС-ийн Тэгш боломж хүүхдийн хөгжил хариуцсан ажилтан, “Дэмжлэгийн баг”-ийн ахлагч, ялгаатай хэрэгцээ шаардлагатай хүүхэдтэй ажиллаж буй	100%

												ЕБС, СӨББ-ын 75 багш, удирдах ажилтан хамрагдаж мэргэжил дээшлүүлсэн байна. 2021-2024 онд МУБИС, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран 6 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор СӨБ, ЕБС-ийн нийт 360 гаруй багш, ажилтныг хамруулснаар аймгийн төрийн өмчийн 32 цэцэрлэг, 17 сургуульд хөгжлийн бэрхшээлттэй хүүхэдтэй ажиллах 1-2 сургагч багштай болж дэмжлэгийн багийн үйл ажиллагаа тогтмолжсон. "Тэгш боломж" төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан 9 танхим байгуулагдаж тэдгээр төвүүдэд 120 гаруй хүүхэд үйлчлүүлж байна. Аймгийн хэмжээнд СӨББ-д 12, ЕБС-д 60 багш хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан "Ганцаарчилсан сургалт"-ын төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаа бөгөөд эдгээрт багш нарт хуульд заасны дагуу үндсэн цалингийн 10 хувийн нэмэгдлийг тогтмол олгож байна.	
87		Жаргалант сумын сургууль, 7-р сургууль, 27-р цэцэрлэгийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг зөөх дунд оврын автобустай болгох	2022-2024	БШУГ	СӨББ ЕБС	Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	Батлагдсан төслийн хүрээнд	1 автобус	1 автобус	Батлагдсан төслийн хүрээнд	2021-2024 онд: Улсын төсөв 60.0 Орон нутгийн төсөв 130.0	2022 онд орон нутгийн төслийн хөрөнгө оруулалтаар Жаргалант сумын сургуулийн хүүхдийн автобусыг шинэчилж, COUNTY маркийн дунд оврын автобус, 2023 онд "Тэгш боломж" төслийн хүрээнд 130.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянбулаг багийн 27 дугаар цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг зөөх тусгай зориулалтын "Starrex" маркийн авто машиныг тус тус хүлээлгэн өгч, хүүхдүүдийг цэцэрлэг, сургуульд зөөвөрлөж байна. Ерөнхий боловсролын 7 дугаар сургуульд COUNTY маркийн дунд оврын автобусыг ашиглаж байна. Уг автобусаар тус сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй 49 хүүхдийг зөөвөрлөж байна. Тус сургуулийн автобусыг шинэчлэх зорилгоор 60.0 сая төгрөгийг Боловсролын яамнаас, 35.0 сая төгрөгийг сургуулийн нөхөн хангалтын зардлаас гаргаж нийт 95.0 сая төгрөгийг шийдвэрлэж, 2 удаа тендер сонгон шалгаруулалтыг зарлан үргэлжилж байна.	100%
88	3.1.7.Бүх нийтийн боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар менежментийг дээшлүүлж, орон	Иргэдийн эрэлт, хэрэгцээнд тулгуурласан бизнес амьдрах ухаан, ёс суртахуун төлөвшил, гоо зүй,	2021-2024	БШУГ	НТБТ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	15.0	-	Хөтөлбөр хэрэгжүүлнэ.	5.0	-	2022 онд аймгийн Насан туршийн боловсрол төв 5 агуулгын хүрээнд 82 хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, 70 гаруй аж ахуй нэгж, байгууллагын 4249 хүнд сургалтын чиглэлээр үйлчилгээ үзүүлж, 11757 орчим иргэнийг нөлөөллийн ажилд хамруулсан. 2023	100%

	нутгийн захиргааны байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэн "Насан туршийн боловсрол төв"-ийг хүн амын насан туршийн боловсролыг дэмжигч, мэдээлэл түгээгч байх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.	гэр бүлийн, байгаль орчны, иргэний боловсрол олгох гэсэн чиглэлээр сургалтыг олон талт хэлбэрээр зохион байгуулж, ардын уламжлалт гар урлал, амьдрах ухааны чиглэлээр шавь сургалтыг иргэдийн дунд зохион байгуулах									онд иргэдийн боловсролын түвшин дээшлүүлэх захиалгат сургалтад гэр бүл, амьдрах ухаан, иргэний, ёс суртахуун, гоо зүйн боловсролын агуулгын хүрээнд 60 гаруй байгууллага, Баян-Өндөр сумын 10 гаруй багийн 5220 иргэнийг хамруулсан. Мөн үндэсний бичгийн сургалтад 12 байгууллагын 290 ажилтан, англи хэлний хэрэглээний 10 удаагийн сургалтад 185 иргэн, компьютерын хэрэглээний анхан ба дунд шатны 16 удаагийн сургалтад 172 иргэн, оёдол эсгүүрийн сургалтад 79 иргэн, шатрын сургалтад 120 иргэн, гитар хөгжмийн сургалтад 15 иргэн, төгөлдөр хуур хөгжмийн сургалтад 16 иргэн тус тус хамрагдсан байна. Сургалтын 10-30 хувь нь онол, 70-90 хувь нь дадлага, бие даалт хэлбэрээр явагдаж, төгссөн иргэдэд гэрчилгээ олгосон. 2024 онд НТСТ-өөс бүх насны иргэдийн хэрэгцээнд тулгуурласан төрөл бүрийн сургалтыг 17 хөтөлбөр 75 сэдвээр явуулж 6819 иргэнийг хамруулсан. Орон нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх чиглэлээр "Үндэсний хувцас оёж, эсгэх" оёдол эсгүүрийн 50 цагийн сургалтад 64 иргэн хамрагдсан байна. 2021-2024 онд иргэдийн хэрэгцээнд суурилсан төрөл бүрийн сургалт, үйл ажиллагааны 53 хөтөлбөрт давхардсан тоогоор 40999 иргэн хамрагдаж, эдгээр иргэдийн 40 гаруй хувь нь ажлын байраар хангагдаж үлдсэн хувь нь өрхийн үйлдвэрлэл эрхэлж байна.		
89	Насан туршийн боловсролын төвд бүх насны иргэд ашиглах боломжтой цахим сургалтын кабинетыг бий болгож, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах		2021-2024	БШУГ	НТБТ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	18.0	-	Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	6.0	2022 онд: Төсөл хөтөлбөр 18.5	2022 онд БШУЯ, Насан туршийн боловсролын үндэсний төв, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох" төслийн хүрээнд 18.5 сая төсөвт өртөгтэй цахим сургалтын кабинетын хэрэглэгдэхүүнийг аймгийн Насан туршийн боловсролын төвд нийлүүлсэн. 2024 онд тус төвд нийт 7 суурин компьютерыг бусад байгууллагуудын тусламжаар хүлээн авч шаардлагатай засвар үйлчилгээ хийж, компьютерын танхимыг шинээр байгуулсан. Тус танхимаар иргэдэд зориулсан компьютерын хэрэглээний сургалтад 194 иргэнийг хамруулсан байна. БШУЯ-наас 5 ширхэг зөөврийн компьютерыг тус төвд нийлүүлсэн.	100%

СОЁЛ УРЛАГ

90	3.2.Эрдэнэтийн өв соёлыг хадгалах, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлэх, соёл урлагийн байгууллагын материаллаг бааз, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, иргэдэд үзүүлэх, соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, соёлын үйлдвэрлэлийг дэмжиж, мэргэжлийн боловсон хүчнээр хангана.	Соёл, урлагийн байгууллагуудыг мэргэжлийн боловсон хүчнээр хангах, мэргэжил дээшлүүлэх сургалтад үе шаттай хамруулах ажлыг зохион байгуулах	2021-2024	БШУГ	СУБ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	6.0	-	Жилд 2-3 уран бүтээлч	1.5	2021-2023 онд: Орон нутгийн төсөв: 28.8 сая 2024 онд Орон нутгийн төсөв 13.6 сая	Соёл, урлагийн байгууллагуудыг мэргэжлийн боловсон хүчнээр хангах, мэргэжил дээшлүүлэх сургалтад үе шаттай хамруулах ажлын хүрээнд 2022 онд аймгийн Музейн ажилтнуудын Улаанбаатар хотод мэргэжил дээшлүүлэх, Номын төв, сургуулийн номын санчдад зориулсан "Орчин цагийн номын сангийн хөгжлийн чиг хандлага", бүжгийн багш бэлтгэх сургалтууд, "Соёлыг түгээе" аяны хүрээнд СУИС-тай хамтран аймгийн соёл, урлагийн байгууллагын ажилтнууд, уран бүтээлчид, соёлын төв, ЕБС, СӨББ-ын байгууллагын багш нарыг чадавхжуулах 2 өдрийн сургалтуудад 120 гаруй ажилтан, албан хаагчийг хамруулсан. 2023 онд аймгийн хэмжээнд соёл, урлагийн салбарын мэргэжлийн боловсон хүчнийг нэмэгдүүлэх чиглэлээр Хүүхэд, залуучуудын театрын 14 уран бүтээлчийг мэргэжлийн нүүр хувиргалтын 2 өдрийн сургалтад хамруулсан. Аймгийн Музей Үндэсний музейтэй хамтран төвийн бүсийн музейн ажилтнуудын дунд зохион байгуулсан "Музейн үзмэр дэглэлт, хадгалалт, хамгаалалт", "Музейн үзмэр тайлбарлах арга зүй", "Музейн боловсролын хөтөлбөр" сэдэвт сургалтуудад аймгийн Музейн 9, Соёлын төвүүдийн орон нутаг судлах танхимын 5 ажилтан тус тус хамрагдсан. Мөн "Соёлыг түгээе" аяны хүрээнд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Соёл урлагийн цогцолбороос аймгийн соёлын төвүүдийн бүжгийн багш, дууны багш, хөгжмийн багш, техникийн ажилчид, номын санчдад соёлын ажлын арга зүй, онол практик хосолсон 5 өдрийн сургалтыг зохион байгуулж 30 ажилтан хамрагдсан байна. 2024 онд Монгол бичгийн сургалтад соёл, урлагийн салбарын 32 албан хаагч, аймгийн Хүүхэд, залуучуудын театрт явагдсан "Хүүхэддэй амилахуй" мэргэжлийн сургалт болон тайзны хөдөлгөөний 14 хоногийн сургалтуудад тус театрын 14 жүжигчин хамрагдсан байна. Мөн аймгийн Музейн даргыг Хонконгт зохион байгуулагдсан "Museum summit-2024" олон улсын хөтөлбөрт арга хэмжээнд оролцож мэргэжил дээшлүүлэхэд 2.8 сая төгрөг, соёл, урлагийн салбарын 100 албан хаагчийн морин хуурын сургалтад 10.8 сая	100%
----	---	---	-----------	------	-----	------------------------------------	-----	---	-----------------------	-----	---	---	------

												төгрөгийн дэмжлэгийг орон нутгийн төсвөөс олгосон байна. Мөн соёлын яамнаас зохион байгуулсан гэрэл, дууны техник, тайзны тоног төхөөрөмжийн мэргэжлийн сургалтад “Баян-Өндөр”, “Баянцагаан” соёлын төвийн 2 ажилтан, СУИС-ийн эчнээ хөтөлбөрт “Аялгуу” соёлын төвийн 2 ажилтан тус тус суралцаж байна. 2024 оны байдлаар соёл, урлагийн салбарын мэргэжлийн боловсон хүчний хангалт 84 хувьтай байна.	
91		Аймгийн номын төвийн өргөтгөл, Номын өргөө бүхий цогцолбор барилга, Даваат, Наран багуудын соёлын төвийн барилгыг ашиглалтад оруулах, соёл, урлагийн байгууллагын барилгыг өргөтгөх, шинээр барих ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	2020-2024	БШУГ	СУБ	Улсын болон орон нутгийн төсөв	-	-	-	-	Улсын төсөв 1500.0 Орон нутгийн төсөв 4300.0	Улсын төсвийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Даваат багийн соёлын төвийн барилгыг 2021 оны 01 сард ашиглалтад оруулсан. Орон нутгийн төсвийн 4.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Номын өргөө бүхий цогцолбор"- ын барилгыг 2024 оны 04 дүгээр сард ашиглалтад хүлээн авсан. Мөн улсын төсвийн 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй Наран багийн соёлын төвийн барилгын ажил нэмэлт санхүүжилт шаардлагатайгаар 82 хувийн гүйцэтгэлтэй ажил зогссон байна. 2024 онд тус барилгын үлдэгдэл ажлын төсвийг Барилгын хөгжлийн төвийн магадлалд оруулж барилгын төсөвт өртөг 1.3 тэрбум төгрөгийг 2025 оны улсын төсөвт тусгах саналыг зураг төсвийн хамт хүргүүлсэн боловч 2025 оны төсөвт тусгагдаагүй байна.	90%
92		Соёл, урлагийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, хувцас хэрэглэлээр хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	2020-2024	БШУГ	СУБ	Улсын болон орон нутгийн төсөв	165.0	-	Тоног төхөөрөмжөөр хангана.	50.0	2021-2023 онд: Орон нутгийн төсөв 661.4 2024 онд: Орон нутгийн төсөв 479.6	2021 онд Хүүхэд залуучуудын театр, аймгийн Музейг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэлээр хангахад зориулж, орон нутгийн төсвөөс 32.0 сая төгрөг зарцуулсан. Мөн соёл, урлагийн байгууллагуудын орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр аймгийн Музейн засварт 7.5 сая, Номын төвийн засварт 49.9 сая, тус төвийн дээврийн засварт 21.7 сая, нийт 79.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулсан. 2022 онд соёл, урлагийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэлээр хангахад зориулж улсын төсвөөс 40.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Үүнд: Соёл, урлагийн газарт 18.3 сая, "Аялгуу" соёлын төвд 17.8 сая, Номын төвд 6.8 сая, Хүүхэд, залуучуудын театрт 1.6 сая төгрөгийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж олгосон. 2023 онд аймгийн Нийтийн номын санд	100%

											шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авахад 55.6 сая, "Аялгуу", "Хэмнэл" соёлын төвд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад 134.4 сая, аймгийн Музейд виртуал төхөөрөмж авахад 19.4 сая, Жаргалант сумын Соёл мэдээллийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл авахад 93.4 сая, тус төвд их засвар хийхэд 206.6 сая нийт 509.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцууллаа. 2024 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар "Аялгуу" соёлын төвд 27.0 сая, "Баянцагаан" соёлын төвд 20.8 сая, аймгийн Соёл, урлагийн газарт 44.8 сая, Хүүхэд, залуучуудын театрт 95.0 сая, шинээр ашиглалтад орсон "Номын өргөө" цогцолборт 292.0 сая, нийт 479.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нийлүүлсэн байна.		
93		Хувийн хэвшлийн соёл, урлагийн байгууллага, иргэдэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах	2020-2024	БШУГ	СУБ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	80.0	-	Дэмжлэг үзүүлнэ.	20.0	2021-2023 онд: Орон нутгийн төсөв 88.3 2024 онд Орон нутгийн төсөв 66.7	2022 онд "Эрдэнэт" дуу бүжгийн чуулгын 3 уран бүтээлч, 14 дүгээр сургуулийн 1 сурагчийн бие даасан тоглолтод 15.8 сая, "Таван эгшиг" төгөлдөр хуурын улсын уралдаанд оролцох замын зардалд 1.5 сая сургалтын төв, "Тод анир" зохиолчдын салбар зөвлөлөөс зохион байгуулсан 2 арга хэмжээнд 3.5 сая, нийт 20.8 сая, 2023 онд 7 уран бүтээлчийн бие даасан тоглолт болон шинэ уран бүтээл, үзэсгэлэнгийн зардалд 21.6 сая, соёл урлагийн чиглэлээр явагдсан 5 уралдаан тэмцээнд 12.9 сая, аймгийн "Зураач, урчуудын холбоо", "Номын шидэт хайрцаг" төрийн бус байгууллагаас зохион байгуулсан үзэсгэлэн, сургалтад 12.0 сая, 2 хамтлагийн бие даасан тоглолтод 9.0 сая, "Эрдэнэт" дуу, бүжгийн чуулгын уран бүтээлчдийг "Цэнгэлийн эгшиг" уралдаанд оролцоход 5.0 сая, "Өсөх ирээдүй" бүжгийн хамтлагт 1.0 сая, 1 сурагч, 2 уран бүтээлчийг АНУ, Франц, ОХУ-д зохиогдсон уралдаанд оролцоход 6.0 сая, нийт 67.5 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсэн байна. 2024 онд найруулагч Д.Отгонбаатараас санаачилсан "Шашин урлагийн цэнгүүн"-нд 5.0 сая, 1 дүгээр сургуулийн 12г ангийн сурагч, уран бичээч О.Очирбатын "Бийрийн зам" үзэсгэлэнд 2.3 сая, "Солонгын аяз" нийтийн цэнгээнт бүжгийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 1.0 сая, Эрдэнэт хотод бүжгийн спорт үүсч хөгжсөний 30 жилийн ойн олон талт үйл	100%



											ажиллагааны зардалд 30.0 сая, "Авьясас билиг" сургалтын төвийн 10 жилийн ойн тайлан тоглолтын зардалд 6.5 сая, МЗЭ-ийн Орхон аймаг дахь салбараас зохион байгуулсан яруу найргийн уралдаанд 1.5 сая, чөлөөт уран бүтээлч Д.Мөнх-Эрдэнийн "Хайрын сарнай" тоглолтын зардалд 1.5 сая, "Уран эгшиг" сургуулийн найрал хөгжмийн багш Д.Пүрэвсүрэнгийн "Хөгжмөөр хөглөгдсөн амьдрал - 40" тайлан тоглолтын зардалд 3.0 сая, Монголын хараагүйчүүдийн нийгэмлэгийн гишүүн С.Чинбатын "Сэтгэлийн гэгээ" хандивын тоглолтын зардалд 2.5 сая, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын "Эрдэнэт" ДБЧ-ын уран бүтээлч Д.Дагвадоржийн Буриад улсад зохион байгуулагдсан дуурийн дуу дуулаачдын фестивалд оролцоход 1.0 сая, аймгийн ХЗТ-ын жүжигчин Б.Түвшинжаргалын бие даасан шинэ уран бүтээл "Хатан сэнтийн хайлан" түүхэн жүжгийн зардалд 3.5 сая, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Баяжуулах үйлдвэрийн соёл, нийтийн ажлын арга зүйч Б.Нямдэлгэрийн ОХУ-д явагдсан олон улсын дуулаачдын уралдаанд оролцоход 1.8 сая, "Хэмнэл" соёлын төвийн бүжгийн дугуйлангийн сурагчдын "Хүн домог" үндэсний урлагийн наадамд оролцоход 3.0 сая төгрөг, сурагч У.Дөлгөөн-Ундралын АНУ-д олон улсын төгөлдөр хуурын уралдаанд оролцох замын зардал 2.0 сая, "Баян-Өндөр" соёлын төвийн ахмад ажилтан С.Эрдэнэцэцэгийн "Бидний дуулал-2" тоглолтын зардалд 2.1 сая, нийт 66.7 сая төгрөгийн дэмжлэгийн орон нутгийн төсвөөс олгосон байна.		
94	3.2.1.Соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин, гадаад харилцааг өргөжүүлж, соёл, урлагийн үйлчилгээг аялал жуулчлалтай холбон сурталчлах, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Соёл, урлагийн байгууллагын ажилтнуудыг гадаад улс орнуудад туршлага судлах, мэргэжил дээшлүүлэх боломжоор хангах	2022-2024	БШУГ	СУБ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	75.0	-	10 уран бүтээлч Жил бүр	25.0	2021-2023 онд: Орон нутгийн төсөв 10.1 2024 онд: Орон нутгийн төсөв 15.0	2022 онд Япон, Болгар улсад зохион байгуулагдсан хөгжмийн болон дуурийн дуулаачдын уралдаанд оролцсон уран бүтээлч, багш сурагчдад нийт 4.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 2023 онд ОХУ-д зохиогдсон дуурийн дуулаачдын уралдаанд оролцсон чөлөөт уран бүтээлч Б.Заяатад 1.5 сая, АНУ-д төгөлдөр хуурын уралдаанд оролцсон Ц.Энх-Ундаргад 1.5 сая, Жаргалант сумын соёлын төвийн 1 ажилтан Франц улсад "Чингис хаан дэлхийг өөрчилсөн нь" үзэсгэлэнд оролцоход 3.0 сая төгрөгийн дэмжлэг тус тус үзүүлсэн байна. Мөн Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Соёл, урлагийн цогцолборын уран бүтээлч Н.Цэрэнпил БНСУ-д	90%

											<p>зохиогдсон "MAMF-2023" олон улсын соёлын фестивалд "Соёлын биет бус өв өвлөн уламжлагч" төрлөөр, тус цогцолборын уран бүтээлч Д.Дагвадорж, М.Маналжав нар ОХУ-ын хөгжмийн зохиолч Исаак Дунаевскийн нэрэмжит Олон улсын дуулаачдын XII дахь удаагийн уралдаанд тус тус оролцсон байна. Аймгийн Хүүхэд, залуучуудын театрын 6 уран бүтээлч БНХАУ-ын ӨМӨЗО-ны кино багтай хамтран "Шөнийн манаа" түүхэн олон ангит кинонд тоглож байна. Эдгээр уран бүтээлчдэд аймгийн Хүүхэд, залуучуудын театраас 2 сарын цалинтай чөлөө олгож, мэргэжил ур чадвараа дээшлүүлэх боломжоор хангасан. 2024 онд аймгийн Музейн даргыг Хонконгт зохион байгуулагдсан "Museum summit-2024" олон улсын хөтөлбөрт арга хэмжээнд оролцоход 2.8 сая, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Соёл, урлагийн цогцолборын дуучин Д.Дагвадоржийг ОХУ-ын Буриад улсын Улаан-Үд хотод зохион байгуулагдах Лхасрана Линховоины нэрэмжит дуурийн дуу дуулаачдын фестивалд оролцоход 1.0 сая, тус үйлдвэрийн соёл, нийтийн ажлын арга зүйч Б.Нямдэлгэрийг ОХУ-ын Москва хотод зохион байгуулагдсан И.Дунаевскийн нэрэмжит олон улсын дуулаачдын уралдаанд оролцоход 1.8 сая, Соёл, урлагийн салбарын 20 албан хаагчийг ОХУ-ын Буриад улсад туршлага судлуулахад 9.4 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгийн төсвөөс тус тус олгосон байна.</p>	
95	Орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллага болон бусад уран бүтээлчдийг шинэ уран бүтээл гаргахад нь дэмжлэг үзүүлэх	2021-2024	БШУГ	СУБ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	110.0	-	Дэмжлэг үзүүлнэ.	30.0	<p>2021-2023 онд: Улсын төсөв 40.0 Орон нутгийн төсөв 40.0 2024 онд: Орон нутгийн төсөв 101.5</p>	<p>2021 онд зөврийн музей байгуулах төсөл, "Жороо баахан улаан" дууг дүрсжүүлэх, "Бачата" бүжгийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох Орхон аймгийн "Өсөх ирээдүй" бүжгийн спортын клубын бүжигчдийн замын зардалд дэмжлэг үзүүлж хамтран ажилласан. 2022 онд дуучин Д.Нямсүрэн, Х.Мөнхбаяр, Б.Нямдэлгэр нарын бие даасан тоглолтод нийт 14.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, аймгийн Хүүхэд, залуучуудын театрын 2 уран бүтээлийн зардалд 40.0 сая төгрөгийг улсын төсвөөс олгож тус тус дэмжлэг үзүүлсэн. 2023 онд аймгийн Хүүхэд залуучуудын театрын найруулагч Е.Баярмагнайн тайз, дэлгэц хосолсон театрчилсан тоглолтод 5.7 сая, аймгийн "Зураач, урчуудын холбоо"-ноос зохион байгуулсан "Эрдэнэтийн хавар"</p>	100%

											<p>үзэсгэлэнд 2.0, "Мэлмий" гэрэл зургийн бүлгэмийн зурагчин Т.Шинэсүлдийн Эрдэнэт хотын шилдэг гэрэл зургуудаас бүрдсэн шинэ уран бүтээлд 4.9 сая, аймгийн Хүүхэд, залуучуудын театрын "Асаж буй толгод" жүжгийг Өмнөговь, Дундговь аймагт аялан тоглоход 3.2 сая, тус театраас зохион байгуулсан "Хүүхэлдэйн урлагийн их наадам"-д 2.5 сая, Дундговь аймгийн "Уяхан замбуу тивийн наран" эвент арга хэмжээнд оролцоход 4.0 сая төгрөг, нийт 22.3 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн.</p> <p>2024 онд аймгийн Хүүхэд, залуучуудын театрын шинэ уран бүтээл Ерөнхий сайд асан А.Амарын тухай "Улаан манан" драмын жүжгийн зардалд 98.0 сая, тус театрын жүжигчин Б.Түвшинжаргалын бие даасан шинэ уран бүтээл "Хатан сэнтийн хайлан" түүхэн жүжгийн зардалд 3.5 сая төгрөгийн дэмжлэг тус тус үзүүлсэн байна.</p>		
96		Орон нутагт гадаад дотоодын аялал жуулчлалыг татах зорилгоор улс, бүсийн чанартай соёл, урлагийн арга хэмжээг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах	2021-2024	БШУГ	СУБ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	80.0	-	2 арга хэмжээ зохион байгуулна	25.0	<p>2021-2023 онд: Орон нутгийн төсөв 421.9</p> <p>2024 онд: Орон нутгийн төсөв: 106.0</p>	<p>2022 онд Аймгийн Соёл, урлагийн газар, Орхон аймгийн Бүжгийн холбоод хамтран "Бүжин наадъя" бүжгийн фестивалийг зохион байгуулсан. Фестивальд 13 аймгийн 1300 гаруй бүжигчид оролцсон бөгөөд орон нутгийн төсвөөс 6.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Орхон, Булган аймгийн хамтын ажиллагааны гэрээний хүрээнд "Хангинахын шугуйн шагайн тойром" соёл, спортын үйл ажиллагааг Булган аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулсан. 2023 онд "Бүргэдийн баяр-2023" арга хэмжээг орон нутагтаа зохион байгуулж Казах түмний соёл, ёс заншлыг сурталчилсан. Уг үйл ажиллагаанд Баян-Өлгий аймгаас 13 бүргэдчин оролцож, гадаад, дотоодын 8000 гаруй иргэд үзэж сонирхсон бөгөөд худалдаа, үйлчилгээ, зочид буудлын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгж, байгууллагууд нийт 9.2 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.</p> <p>Мөн аймгийн аялал жуулчлал, уул уурхайн салбарын онцлогийг илэрхийлсэн эвентийг хөгжүүлэх, сурталчлах зорилгоор "Зэс фестиваль"-ийг зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд хоол үйлдвэрлэл, зэс бүтээгдэхүүний худалдаагаар орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчид 23.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.</p>	100%

											2024 онд аймгийн Гончигсүмлэн хийдтэй хамтран "Пуу жилийн мөсөн шагайн хишиг харваа" тэмцээн, аймгийн Биеийн тамир спортын газартай хамтран "Эрдэнэт мөнгөн өвөл" спортын наадам, "Эрдэнэтийн бал" цэнгээнт бүжгийн наадам, "Баян-Өндөр" хайрхан, тэнгэрийн 7 бурхан одны тахилга зэрэг орон нутгийн онцлог бүхий соёлын, урлагийн арга хэмжээг зохион байгуулсан. Мөн Орхон аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 1.1.4, 1.3.3-т заасны дагуу "Соёлыг түгээе" аяныг "Хотын соёл-Хамтын соёл" уриан дор төрийн албан хаагчид, иргэд, хүүхэд залуучууд, аж ахуй нэгж байгууллагуудыг нийгмийн ёс зүйг дээдэлсэн, өөрийн хотын үнэт зүйлсээр бахархдаг, эерэг харилцаа хандлага бүхий ухамсарт зан үйл, соёлд суралцуулах, иргэдийн нийтийн соёлыг дээшлүүлж, соён гэгээрүүлэх" зорилгоор "Соёлыг түгээе" аяныг 2021-2024 онд 4 удаа зохион байгуулсан. Аяны хүрээнд нийгмийн эерэг хандлагыг нэмэгдүүлж, бүх нийтийн соёлын боловсролын дээшлүүлэх чиглэлээр төвийн болон орон нутгийн соёл, урлагийн байгууллага, иргэд, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран боловсрол, эрүүл мэнд, спорт, гэр бүл, хүүхэд залуучууд, нийтийн тээвэр, тохижилт үйлчилгээ зэрэг нийгмийн томоохон салбаруудад чиглэсэн соёл, нөлөөллийн олон талт арга хэмжээг зохион амжилттай зохион байгуулсан.		
97		Улсын хэмжээний шилдэг уран бүтээлийг орон нутгийн иргэдийн хүртээл болгоход дэмжлэг үзүүлэх	2022-2024	БШУГ	СУБ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	1 уран бүтээл	Батлагдсан төсвийн хүрээнд	2021-2023 онд: Орон нутгийн төсөв 40.0 2024 онд: Орон нутгийн төсөв 20.0	2022 онд УДЭТ-ын уран бүтээл "Анна Каренина" жүжгийг, 2023 онд "Соёлыг түгээе" аяны хүрээнд Монгол улсын филармоний Морин хуурын чуулгын шилдэг уран бүтээлийн тоглолтыг 3 удаа орон нутгийн иргэдийн хүртээл болгоход орон нутгийн төсвөөс тус тус 20.0 сая төгрөгийг зарцууллаа. 2024 оны орон нутгийн төсөвт энэ чиглэлээр 20.0 сая төгрөг батлагдсан бөгөөд 2024 оны 12 дугаар сард УДЭТ-ын уран бүтээлийг иргэдийн хүртээл болгохоор төлөвлөж байна.	100%
98	3.2.2.Соёлын биет болон биет бус өв, түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хадгалах хамгаалах,	Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг гэрээгээр хамгаалах өрхийн тоог нэмэгдүүлж иргэд олон нийтийн	2021-2024	БШУГ	Аймгийн Музей	Орон нутгийн төсөв	12.0	11 өрх	20 өрхөд урамшуулал олгоно.	4.0	2021-2023 онд: Орон нутгийн төсөв 8.0 2024 онд: Орон	Аймгийн хэмжээнд түүх соёлын үл хөдлөх дурсгалын www.rich.mongoluv.mn программд бүртгэгдсэн 53 дурсгалт газрын 368 дурсгал байна. 2021 онд аймгийн нутаг дэвсгэрт байрлах түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг гэрээгээр хамгаалж буй 12 айл өрхтэй гэрээг шинэчлэн байгуулж, гэрээгээр хамгаалах	100%

	сурталчлах ажлын чанарыг нэмэгдүүлэн, иргэд олон нийтийн хяналт оролцоог нэмэгдүүлнэ.	хяналт оролцоог сайжруулах								нутгийн төсөв 6.0	бүсчлэлийг шинэчилсэн. 2022 оноос гэрээгээр хамгаалах өрхүүдийн тоог нэмэгдүүлж аймгийн Засаг даргын А/227 дугаар захирамжаар Баян-Өндөр, Жаргалант сумын нийт 20 өрхтэй гэрээ байгуулж нийт 368 түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг зохион байгуулж, дээрх өрхүүдэд 4.0 сая төгрөгийн урамшуулал олгосон. 2023 онд дээрх өрхүүдтэй гэрээг сунгаж аймгийн Засаг даргын А/691 дүгээр захирамжаар нийт 4.0 сая төгрөгийн урамшуулал, 2024 онд аймгийн Засаг даргын А/438 дугаар захирамжаар 6.0 сая төгрөгийн урамшууллыг орон нутгийн төсвөөс олгосон. Эдгээр түүх соёлын дурсгалт газруудыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын кадастрын мэдээллийн санд бүртгэж оруулах ажлыг зохион байгуулж байна. Мөн аймгийн ИТХ-ын 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 19/02 дугаар тогтоолоор түүх, соёлын үл хөдлөх дурсгалт 8 газрын 162 дурсгалыг Жаргалант сумын хамгаалалтад авсан.		
99		Айргийн гозгорын археологийн малтлагыг үргэлжлүүлэн хийж аймгийн Музейн үзмэрийн сан хөмрөгийг баяжуулах	2023-2024	БШУГ	Аймгийн Музей	Орон нутгийн төсөв	60.0	-	Малтлага судалгааны ажлыг хийх	30.0	2024 онд: Орон нутгийн төсөв 30.0	2023 онд Соёлын яамнаас олгосон зөвшөөрлийн дагуу Монгол улсын Үндэсний Музей, БНХАУ-ын Ардын Их сургуультай хамтран Жаргалант сумын Айргийн гозгорын дурсгалт газарт 2023 оны 06 дугаар сарын 18-наас 07 дугаар сарын 11-нийг дуустал 3 дурсгалд малтлага судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг малтлагаас гарсан 2 ширхэг вааранд судалгаа хийж, бүртгэлжүүлсэн байна. 2024 онд аймгийн Музей Монголын Үндэсний музейтэй хамтран Жаргалант сумын "Айргийн гозгор"-ын дурсгалт газар малтлага судалгааны ажлыг эхлүүлсэн. Уг ажилд орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөг зарцуулсан бөгөөд малтлагаас гарсан олдворуудаар аймгийн Музейн үзмэрийн сан хөмрөгийг баяжуулахаар төлөвлөж байна.	90%
100		Соёлын биет бус өв тээгчдийг сурталчлах ажлыг техник, технологийн шийдлийг ашиглан	2021-2024	БШУГ	СУБ	Орон нутгийн төсөв	40.0	-	Сурталчлах ажлыг зохион байгуулна	10.0	2021-2023 онд: Орон нутгийн төсөв 34.0 2024 онд: Орон	2021 онд соёлын биет бус өв тээгчдийг сурталчлах, алдаршуулах ажлын хүрээнд өв тээгчдийн судалгааг шинэчилж, 120 өвлөн уламжлагчийг цахим орчинд сурталчилсан. Мөн "Номин" телевизтэй хамтран шилдэг 15 өвлөн уламжлагчаар "Эрдэнэтийн өв соёл" видео контентыг хийж иргэдийн хүртээл болгоход 4.0	100%

		шинэлэг хэлбэрээр зохион байгуулах								нутгийн төсөв 9.0	<p>сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Энэ нь иргэд, хүүхэд багачуудад уламжлал, өв соёлыг таниулах, түгээн дэлгэрүүлэх чухал нөлөө үзүүлсэн томоохон ажил болсон. 2022 онд соёлын биет бус өв өвлөн уламжлагчдын улсын үзлэг тооллогыг зохион байгуулж, бүртгэлийн <a href="http://www.ich.mongoluv.mn">www.ich.mongoluv.mn</a> сайтад 198 хүний бүртгэлийг хийж, нийт өв тээгчдийн мэдээллийг цаасан болон цахим хэлбэрээр хадгалж байна. Соёлын яамнаас зохион байгуулсан "Нүүдэлчин Монгол" фестивалд аймгийн биет бус өв тээгч, өвлөн уламжлагчид оролцоход орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 2023 онд соёлын биет бус өв өвлөн уламжлагчдыг сурталчлах зорилгоор МҮОНТ-ийн "Монгол өв соёл" 4 цуврал нэвтрүүлэгт угийн бичгийг арьсан дээр тусгай аргаар 8 үеэ судалж хөтөлсөн 2 иргэн, монгол марк цуглуулга, эсгий урлал, ширмэл ширдэг, модон эдлэл, модны үндсээр гар аргаар сийлбэр хийх, Урианхай ардын уртын дуу болон ерөөл магтаал, зодог шуудаг хийх, Монгол ардын оньсон тоглоом, гангаар гэр ахуйн эдлэл хийх, алт мөнгөний дархан, Монгол бичиг, Монгол зураг, зоосон ширээ, уран хатгамал, бурхан урлалын төрлөөр соёлын өвийг өвлөн уламжлагч 56 иргэнийг оролцуулж орон даяар сурталчилсан. 2024 онд "Монголын баялаг-330" төслийн хүрээнд Баян-Өндөр, Жаргалант сумдын түүх соёлын үл хөдлөх дурсгал, дурсгалт газар, соёлын биет бус өвийн чиглэлээр баримтат кино нэвтрүүлэг хийлгэж олон нийтэд хүргэсэн. Мөн МҮОНТ-ийн "Монгол түмний мэнд" нэвтрүүлэгт өвлөн уламжлагч 4 иргэн, "Дөрвөн бэрх" нэвтрүүлэгт 5 иргэн, "Үндэсний соёлын өв" нэвтрүүлэгт бий биелээч 25, икэл хуурчин 2 иргэнийг тус тус оролцуулж, улсын хэмжээнд сурталчилсан. Эдгээр ажилд орон нутгийн төсөв болон сумдын төсвөөс 9.0 сая төгрөг зарцуулсан байна. Мөн <a href="http://www.ich.mongoluv.mn">www.ich.mongoluv.mn</a> программд бүртгэлтэй 189 өвлөн уламжлагчийг телевизийн 13 нэвтрүүлэг, баримтад кино, 76 контентод оролцуулж сурталчиллаа.</p>
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ											

3.3.Шинэ технологи нэвтрүүлэх, инновацыг дэмжих төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.													
101	3.3.1.Аймгийн онцлог, давуу талд тулгуурлан катодын зэс боловсруулах үйлдвэрлэл, технологийн парк байгуулна.	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т үйлдвэрлэл технологийн парк байгуулах ажлын хүрээнд исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төслийг хэрэгжүүлэх	2021-2022	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	ХБТХ ОХ БОАЖ Г	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	167.3	-	Төслийг ажлын явцыг 100%-д хүргэсэн байна.	-	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас 2021-2023 онд 83.7сая 2024 онд 183.0 сая төгрөг	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын захиалгаар “Катодын зэсийн үйлдвэрийн ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлыг “Майнинг Шорт Лонг Терм” ХХК гүйцэтгүүлж, гүйцэтгэгч компани ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн дэмжигдсэн. ТЭЗҮ-ээр 109.2 \$ буюу 362.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 10 мян.тн/жил катодын зэс үйлдвэрлэн гаргах хүчин чадалтай байхаар байна. “Майнинг Шорт Лонг Терм” ХХК-иас “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн байдлаар боловсруулсан зураг төслийг дүгнүүлэн гэрээг дуусгавар болгох саналыг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т ирүүлсний дагуу тус ажлыг хянаж үзээд “Иж бүрдэл дутуу, төрийн захиргааны холбогдох байгууллагуудаар хянуулан баталгаажуулаагүй зураг төслийг цаашид “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т ашиглах боломжгүй” гэж шийдвэрлэсэн тул 2024 оны 7 дугаар сард гэрээ цуцлах саналыг гүйцэтгэгч компанид хүргүүлсэн. Мөн “Үүсмэл орд”-той холбоотой тус төслийг цаашид “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ санхүүжүүлэх шаардлагатай эсэх талаар “Чиглэл хүсэх тухай” 2024 оны 08 дугаар сарын 16-ны ГЕ-69-12/5420 дүгээр албан бичгийг АҮЭБ-ийн сайдад хүргүүлсэн. Ажлын явц 63.8%-тай байна. Катодын зэсийн үйлдвэрийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх ажлыг “Төгрөг баян хангай” ХХК -тай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгүүлж, БОАЖЯ-ны мэргэжлийн комиссын 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн хүлээн авсан. Үйлдвэрийн Техник, технологийн түвшний үнэлгээг ШУТИС-ийн МТС-тай гэрээ байгуулан ажиллаж байгаа ба эцсийн тайланг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны мэргэжлийн комиссоор хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. Тус ажлын гэрээний хугацаа 2024 оны 12 дугаар сард дуусна.	30%
102		“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т үйлдвэрлэл технологийн парк байгуулах ажлын хүрээнд зэсийн	2021-2024	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	ХБТХ ОХ БОАЖ Г	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	1628.4	-	Төслийн хүчин чадалд хүргэнэ.	325.8	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас 2021-2023	Зэсийн баяжмалыг тасралтгүй ажиллагаатай хос SKS технологиор хайлуулан, боловсруулах металлурги-химийн үйлдвэр байгуулах ТЭЗҮ-ийг БНХАУ-ын ENFI болон NFC консорциумтай хамтран боловсруулж УУХҮЯ-ны дэргэдэх	70%

		баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл хэрэгжүүлэх		эр" ТӨҮГ						<p>онд 123.4 сая</p> <p>2024 онд 488.5 сая</p>	<p>Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар ТЭЗҮ-ийг хэлэлцүүлж дэмжигдсэн. Зэсийн үнэ 8340 \$-ын түвшинд 762 сая ам.долларын хөрөнгө оруулалтын төсөвтэй батлагдсан.</p> <p>Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрээс ялгарах металлургийн хийг боловсруулж, элементийн хүхэр үйлдвэрлэх туршилтын ажлыг БНХАУ-ын ENFI компани гүйцэтгэж байна. Элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтыг БНХАУ-ын Шинжиан Уйгарын өөртөө засах орны Xinjiang Xinxin Mining Industry компанийн харьяа Karatongke Copper Nickel Mine хайлуулах үйлдвэрлэлийн бүсэд явуулж байна. Туршилтын үйлдвэрийн бүх тоног төхөөрөмж, барилга угсралтын ажил 100 хувь дууссан ба "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь туршилтад ашиглах 500 тн шигшсэн нүүрс бэлтгэн БНХАУ-руу тээвэрлэх ажлыг зохион байгуулан үйлдвэрт хүргүүлж, туршилтын ажлыг эхлүүлж эхний үр дүнгээр үндсэн үзүүлэлтүүд гарсан тул үйлдвэрийн ТЭЗҮ-д тодотгол хийж ирүүлсэн байна.</p> <p>Зэсийн баяжмал хайлуулах боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-д ЭБМЗ-өөс өгсөн зөвлөмжийн дагуу "Аж үйлдвэрийн бүсэд мөрдөх агаарын чанарын стандартууд болон зэс хайлуулах үйлдвэрийн хаягдал утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисуудын ялгарлын олон улсын стандартуудыг судалж, үндэсний болгон боловсруулж батлуулах" ажлыг "Эс Ай Си Эй" ХХК гэрээний дагуу гүйцэтгэж байгаа ба ажлын явц 85%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Стандартуудын засвар хийгдсэн хувилбаруудыг 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр СХЗГ-ын <a href="https://www.estandart.gov.mn/">https://www.estandart.gov.mn/</a> вэбсайтад стандартын төсөлд олон нийтээс санал авахаар 60 хоногийн хугацаанд байршуулсан. Мөн гэрээний 2.1 дэх заалтад нэмэлт өөрчлөлт оруулж, үйлчилгээ үзүүлэх хугацааг 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдөр хүртэл сунгасан. Хүхрийн хүчлийг ашиглан фосфорын бордоо үйлдвэрлэх туршилт судалгааг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Судалгаа, шинжилгээний хүрээлэнгийн ажилтнууд гүйцэтгэж байна.</p>
--	--	--	--	----------	--	--	--	--	--	--	---



											<p>Зэсийн баяжмал хайлуулах боловсруулах үйлдвэрийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийгдсэн.</p> <p>Зэсийн баяжмал хайлуулах боловсруулах үйлдвэрийн техник технологийн түвшний үнэлгээ хийлгэх ажлыг гүйцэтгүүлэхээр "Эрдэнэс үндэсний судалгаа хөгжлийн төв"-тэй 2024 оны 06 дугаар сард гэрээ байгуулсан. Эцсийн тайланг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр хүргүүлсэн.</p>		
103		<p>Эрдэнэтийн баяжуулах үйлдвэрт өргөтгөл, шинэчлэл, ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи, эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг байгуулах төслүүдийг хэрэгжүүлэх</p>	2021-2024	"Эрдэнэтийн үйлдвэр" ТӨҮГ	ХБТХ ОХ БОАЖ Г ҮТТ "ШУТ П"	"Эрдэнэтийн үйлдвэр" ТӨҮГ	1495.1	-	Төслийн ажлын явц 80%. Төслийн ажлыг үргэлжлүүлнэ.	26.7	<p>Эрдэнэтийн үйлдвэр ТӨҮГ-аас 2021-2023 1053.0 сая</p> <p>2024 онд 397.2 тэрбум</p>	<p>Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн хүрээнд эхний ээлжинд хам баяжуулалтын 5-р секцийг шинэчилсэн бол үргэлжлүүлэн хам баяжуулалтын жилд 12 сая.тн хүдэр боловсруулах хүчин чадал бүхий 2, 3-р секцийг шинэчлэх төслийг хэрэгжүүлж байна. Тус төслийн гүйцэтгэгчээр FLSmidth Mongolia компани шалгарч 2023 оны 5 дугаар сард гэрээ байгуулан төслийн ажил гэрээ, төлөвлөгөөний дагуу явагдсанаар эхний ээлжийн ажил 100%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.</p> <p>Баяжуулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх өргөтгөл, шинэчлэлийн дараагийн шатанд өөрөө нунтаглах хэсгийн хүдэр боловсруулах 4-р шинэ шугамын хүчин чадлыг 2.0 сая.тн/ жилээр өргөтгөх төсөл хэрэгжиж байна. Тус төслийн ажлын зураг төслийг боловсруулан экспертизээр баталгаажуулж, өргөтгөлийн МШЦ 6.71x9.75 маркийн №9 тээрэм суурилуулах ажлыг тендерт шалгарсан БНХАУ-ын Jiangxi Nairu mining machinery компани 2023 оны 1 дүгээр сард байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэж байна. Үндсэн тоног төхөөрөмж болох тээрэм, түүний иж бүрдлүүдийн үйлдвэрлэл дуусаж, хяналтын угсралт хийгдсэнээр үндсэн тоног төхөөрөмжүүд 95%, цахилгаан хэрэгсэл 90% нийлүүлэгдэж, суурилуулалтын ажил төлөвлөгөөний дагуу хийгдэж байна. Энэхүү өргөтгөлийг хийснээр Эрдэнэтийн үйлдвэр нь жилд 40 сая тонн хүдэр боловсруулах зорилгод хүрэх юм.</p> <p>Мөчлөгт урсгалт тээврийн технологийн хувьд бутлуурын байгууламжийн суурь, түшиц хана, өөрөө буулгагч болон конвейерийн шилжих станцуудын татлагат суурийн ажилд нийт 3191м.куб бетон цутгалт хийгдсэн. Бутлуурын</p>	90%

												байгууламжийн түшиц хана барих ажил ба өөрөө буулгагч машины зогсоол, буцаан булалтын ажлыг гүйцэтгэж дуусгаан ирсэн тоног төхөөрөмжийг ангилан ялгаж, угсралтад бэлтгэсэн. Конвейерийн урьдчилсан угсралтын ажлын хүрээнд Конвейер N22 болон ВЕЗ-ийн 252 ш модулийг угсраад байна. Конвейерийн шилжих станцын 16 ширхэг татлагат сууриудыг цутган овоолго үүсгэгч болон цахилгаан автоматжуулалтын зарим инженерингийн зураг боловсруулагдаж, овоолго үүсгэгчийн суурийн ажил эхэлсэн. Одоогийн байдлаар конвейер хөтлөгч болон буцах станцын угсралт, суурь байрлуулах ажил болон конвейер №2-ийн трассын түвшнийг тааруулах, нягтруулах ажил хийгдэж байгаа ба мөчлөгт урсгалт тээврийн технологи 56 хувьтай байна. Шинээр баригдаж буй Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг 2024 оны 3-р сард туршилтын журмаар ажиллуулж нийт 55 тн тэсрэх бодис үйлдвэрлэж туршин тэсэлгээний улсын мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт гарах, хөндлөнгийн экспертийн дүгнэлт гарах ажлууд хийгдэж байна. Агаар сэлгэлтийн системийн угсралтын ажлыг бүрэн гүйцэтгэж дууссан. 2024 оны 09-р сараас бүрэн автоматжуулсан горимоор шинэ үйлдвэрийг ажиллуулж, 30 тн тэсрэх бодис үйлдвэрлэж, ил уурхайн нэг блокийн дангаар нь цэнэглэж 09 сарын 27-нд тэсэлгээний ажлыг гүйцэтгэсэн. 10 дугаар сард технологийн жигдрүүлэлт хийж тус үйлдвэрлэсэн тэсрэх бодисоор тэсэлгээний ажлыг явуулж байна. Үйлдвэрийн барилгын ажил дууссан, барилгын улсын комисс ажилласан. Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн гүйцэтгэл 97 хувьтай байна.	
104	3.3.2. Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркийг түшиглэн боловсрол эрдэм, шинжилгээ, үйлдвэрлэлийн уялдаа холбоог бий болгон, сургалтын чанарыг	Их, дээд сургууль, МСҮТ, ЕБС-ийн ахлах ангийн сурагчдыг хамруулсан гарааны бизнесийг дэмжин хөгжүүлэх	2021-2024	ХБТХ ОХ "ШУТ П" Хувийн хэвшил	ХХАА Г ХХҮГ Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	35.0	Гарааны 5 төслийг дэмжсэн.	Гарааны 5 бизнес санааг дэмжин хөгжүүлнэ	10.0	ШУТП-ийн өөрийн орлогоос 10.0	2021-2023 онд "Боломжоос өөрчлөлт рүү" шинэ санаа, шилдэг технологийн уралдаан зохион байгуулж, 20 гаруй гарааны бизнесийн санаа бүртгэснээс 5 төслийг шалгаруулан тус бүр 400.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож дэмжсэн. Бизнес инкубаторт 10 гарааны бизнесийг 2 жилийн хугацаанд ажлын байраар хангаж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлснээр металлург, гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэл,	85%

	дээшлүүлэх, оюутан суралцагчдын бүтээлч байдлыг хөгжүүлнэ.										технологийн судалгааны үйлчилгээ зэрэг бизнес бий болсон. "Судлаач-Энтрепренер" хөтөлбөр хэрэгжүүлж инновацийн төсөл, гарааны компани хөгжүүлэх 18 залуу судлаач, оюутны төсөл хүлээн авч, оролцогчдыг 2 сарын турш сургалтад хамруулан шилдэг оролцогч 2 оюутныг төслөө хэрэгжүүлэхэд ажлын байраар хангаж, 1 төсөлд нь 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. "Гарааны бизнес-2023" төслийг хэрэгжүүлэн хүнсний шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, ногоон сууц үйлдвэрлэл, өрхийн болон бичил үйлдвэрлэлийн нийт 33 төсөлд нийт 270.0 сая төгрөгийг эргэн төлөх нөхцөлтэйгөөр олгосон. Хүүхэд залуучуудад программ, код хөгжүүлэх сургалт явуулж буй "Код лаб" сургалтын төвд орон нутгийн төсвөөс 33.0 сая төгрөгийн өртөг бүхий 12 ширхэг зөөврийн компьютер олгосон. Тус сургалтын төвөөс 62 сурагчийг программ, код хөгжүүлэх сургалтад хамруулж чадавхжуулсан. 2024 онд Орхон политехник коллеж, Эрдэнэт ШУТП хамтран 3 удаагийн уулзалт зохион байгуулж, хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, багш, ажилтан, оюутнуудын гарааны бизнест дэмжлэг үзүүлэхээр оёдлын 8 ширхэг тоног төхөөрөмж гэрээгээр ашиглуулж эхэлсэн. Мөн Политехникийн коллежийн дэргэд гарааны бизнес хөгжүүлэх залуу ажилтнуудын төслийн багтай хамтран ажиллаж байна. Одоогийн байдлаар Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркаас 17 гарааны бизнесийг дэмжин хөгжүүлээд байна.	
105	Бизнес эрхлэгчдэд зөвлөх үйлчилгээг үе шаттай хүргэх, чадавхжуулах	2021-2024	ХБТХ ОХ "ШУТ П" Хувийн хэвшил	ХХАА Г ХХҮГ Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	35.0	10 бизнес эрхлэгч	10.0	Олон улсын төсөл хөтөлбөр 420.0	2021-2023 онд Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Прогресс төсөл, Эрдэнэт ШУТП-ийн хамтран ажиллах гэрээний хүрээнд 120 бизнес эрхлэгчид санхүүгийн менежмент, бизнесийн стратеги, брэнд хөгжүүлэлтийн зөвлөх үйлчилгээг үзүүлснээс 40 бизнес эрхлэгчид нийт 380.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийж дэмжлэг үзүүлсэн. Бизнес хөгжлийн төвд "Бизнес ширээ" ажиллуулж бизнес эрхлэх, татвар, тохирлын гэрчилгээ, хөнгөлөлттэй зээл болон хөрөнгө оруулалтын боломж, оюуны өмчийг хамгаалах	100%	

											<p>зэрэг 10 төрлийн мэдээллийг 250 гаруй иргэнд өгч анхан шатны мэдлэг олгосон.</p> <p>"Хөгжлийн шийдэл" Төрийн бус байгууллагын BEST хөтөлбөр нь бизнес эрхлэгчдэд зөвлөх үйлчилгээ үзүүлж төсөл бичих арга зүйд суралцуулан зээлийн ашиглалт, зарцуулалтын чиглэлээр сургалт өгснөөр хүнс, хувцас үйлдвэрлэл, газар тариалан болон бусад чиглэлээр 37 иргэн, аж ахуйн нэгж төсөл бичиж арилжааны банкуудаас 1.9 тэрбум төгрөгийн бизнесийн зээл авч, 76 ажлын байр хадгалагдан, 6 ажлын байр шинээр нэмэгдсэн. 2023 онд өрхийн болон бичил үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор оёдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 2 иргэнд оёдлын машины тоног төхөөрөмж, 1 иргэнд дугуй засварын тоног төхөөрөмж тус тус олгогдсон.</p> <p>2024 онд Рийч органик косметик, Ган компас, Стеам сургалт, Экора грийн гоулд, Ойстер гровинг субстрат, Бидэрт манхан, Талхны цех, Пенофасад, Мөөг кластер, Эко будаг гэсэн нийт 9 бизнес эрхлэгчид оффис, үйлдвэрлэлийн нийт 1,200м<sup>2</sup> ажлын байр ашиглуулж, улирал тутамд сургалт, арга хэмжээнд оролцуулан ажиллаж байна. БШУЯ-ны Эрдэм хакатон арга хэмжээнд Экора грийн гоулд ХХК шилдгээр шалгарч 20.0 сая төгрөгийн грант, ХНХЯ-аас зохион байгуулсан "Шилдэг стартап, гарааны бизнес болон залуучуудын багт санхүүгийн дэмжлэг олгох улсын уралдаан"-нд Ган компас компани шилдгээр шалгарч 20 сая төгрөгийн грант тус тус авсан. Мөн иргэдэд Бизнес ширээгээр тасралтгүй зөвлөгөө өгч, бизнес ширээ, кластер, стартап 3 цахим систем бий болгохоор мэдээлэл боловсруулж байна.</p>		
106	3.3.3.Инновацын төсөл хэрэгжүүлэх хүрээнд технологийн парк, технологи дамжуулах төв, гарааны бизнесийг хөгжүүлж, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг	"Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн парк" ОНӨААТҮГ-ын дэргэд технологи дамжуулах төв байгуулах	2021	"ШУТ П" ХБТХ ОХ	Сумдын ЗДТГ ХХАА Г	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	2.0	-	-	-	2021-2022 онд Улсын төсөв 50.0	<p>2022 онд "Эрдэнэт ШУТП"-ийн дэргэд технологи дамжуулах төв байгуулж, "Эрдэнэт-2022 инноваци, технологийн өдрүүд" арга хэмжээг зохион байгуулан 15 бизнес эрхлэгчид инновацын зөвлөгөө өгч шилдэг 3 төсөлд тус бүр 10.0 сая төгрөг олгосон. 2023 онд "БМОМ" ХХК, "Мөөг кластер" ХХК-иудад технологийн хөгжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлж, Шинжлэх ухаан, технологийн сантай хамтран хальтиргаанаас сэргийлэх материал, сахар үйлдвэрлэл, дулааны станцын хаягдал</p>	100% 2021 онд бүрэн хэрэгж иж дууссан

	гадаад, дотоодын зах зээлд гаргах, тэлэх, нээлттэй болоход нь дэмжлэг үзүүлнэ.										үнс дахин боловсруулах чиглэлээр судалгааны ажил хийж байна. Технологи дамжуулах төв 2021 онд паркийн нэгжээр байгуулагдан инновацын сургалт, судалгаа, дамжуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. БШУЯ-тай 2024 оны 05 дугаар сард инновацын төсөл бүртгэх гэрээ байгуулах, бүс нутгийн хэмжээнд ажиллах кластер байгуулах судалгаа хийх ажлуудыг хийж гүйцэтгэсэн.	
107	Бизнес эрхлэгчдэд инновацын төслийн ТЭЗҮ боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг зах зээлд гаргах, хөгжүүлэхийг дэмжих	2021-2024	"ШУТ П" ХБТХ ОХ	ХХҮГ Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	34	1 бизнес эрхлэгчид технологи дамжуулсан.	3 бизнес эрхлэгчийг дэмжинэ.	10.0	Олон улсын байгууллага 32.0	2022 онд цаас, хүнсний хог хаягдлыг дахин боловсруулж түлш үйлдвэрлэх, яс дахин боловсруулах, арьс шир боловсруулах чиглэлээр төсөл хэрэгжүүлж буй 3 бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүний технологийн хөгжүүлэлт, зах зээлд гаргахад бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлж дэмжин ажилласан. 2023 онд хүнсний ногооны үр үйлдвэрлэлийн төслийг инновацийн төслөөр хөгжүүлэхээр зөвлөх үйлчилгээ үзүүлж, "Баяжуулагч-Одод" ХХК-ийн хатаасан аарц, "Идэрбаялаг" ХХК-ийн давсалсан махны хатаамал зэрэг инноваци шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжихэд тус бүр 6.0 сая, цаасны хог хаягдлаар эко түлш боловсруулах үйлдвэрлэл эрхэлж буй 1 компанид үйлдвэрлэсэн түлшээ нөөцлөхөд зориулж 20.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. Мөн 11 өрхийн үйлдвэрлэл эрхлэгч нэгдэн хоршоо байгуулж мөөг ургуулах хөрс үйлдвэрлэж байна. Ингэснээр сард 500 кг мөөгийг ургуулах боломж бүрдүүлээд байна. Иргэн Зулчимэгийн амттан үйлдвэрлэл, "Ган компас" ХХК-ийн экспортын тоглоом үйлдвэрлэл, "Мөөг кластер" ХХК-ийн чипс үйлдвэрлэл, тариалалтын ухаалаг чингэлэг үйлдвэрлэл, эмийн мөөг тариалалт, "Бидэрт манхан" ХХК-ийн хуванцар эдлэл үйлдвэрлэл, "БМОМ" ХХК-ийн биомасс боловсруулах зэрэг 9 төслийг дэмжин хөгжүүлж байна. "Инновац" иж бүрэн сургалтын хөтөлбөрөөр паркийн дэргэдэх 10 төслийн 35 ажилтанд сургалт зохион байгуулж, сургалтын үр дүнд компаниуд инновацын бүтээгдэхүүн, төслийн хөгжүүлэлт эхлүүлсэн, менежмент, бүртгэлийн цахим систем нэвтрүүлсэн. Эко будаг ХХК хаягдал шил, автомашины дугуй ус	100%

												тусгаарлагчид ашиглах, Пенофасад ХХК тоос дарах шингэн үйлдвэрлэл зэрэг төслүүд санаачлан хөгжүүлж байна.	
ДӨРӨВ.ЭРҮҮЛ ХҮНС, ЦЭВЭР ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ													
ЦЭВЭР ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ													
4.1.Байгаль орчныг хамгаалах, хүрээлэн буй орчны бохирдол, аюулыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.													
108	4.1.1.Байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, эрт илрүүлэх, урьдчилан мэдээлэх тогтолцоог бэхжүүлж, үүсэж болзошгүй аваар ослыг бууруулна.	Гэр хорооллын үерийн хамгаалалтын далан сувгийн бэлэн байдлыг ханган ахуйн хог цэвэрлэгээг улирал бүр зохин байгуулах	2021-2024	ХЗА	ХТГ ОБГ ХХҮГ	Орон нутгийн төсөв	60.0	Хотын хэмжээнд	100%	15.0	2021-2023 онд орон нутгийн төсөв 189.8 2024 онд Орон нутгийн төсөв 169.6	2021-2023 онд Хотын захирагчийн алба, Онцгой байдлын газар, Баян-Өндөр сум, Хот тохижуулах газар зэрэг байгууллагууд хамтран сар бүр 2 удаа төлөвлөгөөт үзлэг хийж 66.3 км шороон сувгийг сэргээж ухах, жилд 4 удаагийн үерийн сувгийн их цэвэрлэгээг зохион байгуулан 560 <sup>3</sup> хог хаягдлыг цэвэрлэсэн. Мөн давхардсан тоогоор авто замын 42ш гарц хог хайргаар бөглөрснийг цэвэрлэсэн. 2024 онд Хотын захирагчийн алба, Онцгой байдлын газар, Хот тохижуулах газар, Баян-Өндөр сумын ЗДТГ-аас хамтарсан ажлын хэсэг 2024 оны 05 дугаар сараас 07 дугаар сарыг дуустал хугацаанд инженерийн хийцлэлтэй үерийн далан, байгалийн судаг, шуудуунд тогтмол үзлэг хийж ажиллаж, нийт давхардсан тоогоор 55 км урт далан шуудуунд үзлэг хийж 160м3 хог шороо цэвэрлэж тээвэрлэсэн. Мөн хавар, намрын улиралд 23.4 км урт шороон суваг, шуудууг сэргээж ухах ажлыг хийж гүйцэтгэсэн. Хотын доторх үерийн сувгийг сэргээн засварлах, Зэст, Уртбулаг, Согоот багуудад байрлах үерийн усны трап засварын ажлыг хийж гүйцэтгэсэн. Үерийн үед дрон нисгэж эрсдэлийг үнэлэн иргэдэд тухай бүрд мэдээ мэдээллийг өгч сэрэмжлүүлэн ажилласан.	100%
109		Гэр хорооллын шороон үерийн хамгаалалтын суваг шинээр татах	2021-2024	ХЗА ОБГ	ХТГ	Орон нутгийн төсөв	100.0	Хотын хэмжээнд	95%	30.0	2021-2023 онд Орон нутгийн төсөв 189.8 2024 онд Орон нутгийн төсөв 32.4	2021-2023 онд 66.3 км шороон сувгийг шинээр болон сэргээн ухах ажилд орон нутгийн төсвөөс 189.8 сая төгрөгийг зарцуулсан. 2024 онд гэр хорооллын үерийн сувагт 3 удаа их цэвэрлэгээг хийж 160м3 хог хаягдлыг ачиж тээвэрлэсэн. Мөн гэр хорооллын үерийн хамгаалалтын сувагт 5-р сард үзлэг хийж нийт 11.2 км үерийн суваг сэргээх ажлыг хийж эхлүүлснээр одоогийн байдлаар Яргуйт, Баян-Овоот, Уртын гол, Эрдэнэ, Их залуу Дэнж багийн 9.6 км шороон сувгийг сэргээж, шинээр 450м сувгийг татах ажил хийгдээд байна. Одоогийн байдлаар аймгийн хэмжээнд 72.8 км шороон үерийн суваг байгаагаас инженерийн	70%

												хийцлэлтэй 10.2 км, далд 11.0 км, 51.6 км нь байгалийн гуу жалга болон авто замын ус зайлуулах хаялага байна.	
110		Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, зам талбай, тохижилтын нэгдсэн мэдээллийн сан байгуулж болзошгүй аваарыг түргэн шуурхай илрүүлж, засварлах ажлыг зохион байгуулах	2021-2024	ХЗА	ХЗА ОНӨГ ОБГ СТСХ	Батлагдсан төсвийн хүрээнд	80.0	-	Аюул эрсдэлийг бууруулна	Батлагдсан төсвийн хүрээнд	2021-2023 онд Орон нутгийн төсөв 2100.0 2024 онд орон нутгийн төсөв 1300.0	2023 оноос эхлэн Eddenet.mn сайтаар дамжуулан иргэдийн мэдээллийн дагуу холбогдох газруудтай хамтран газар дээр нь үзлэг шалгалт хийж болзошгүй гэмтэл эвдрэлийг илрүүлж, засварлах ажлыг зохион байгуулж, уг сайтад нийт 19 хүсэлт ирснийг 100 хувь судалж шийдвэрлэсэн. Мөн аваарын байдалтай байсан ДГТ-3-р байрны подвалын инженерийн шугам сүлжээг шинэчлэх шинэчлэх ажилд 79.9 сая төгрөг, төрийн албан хаагчдын чийрэгжүүлэлтийн танхимын инженерийн шугам сүлжээ, узелыг засварлаж шинэчлэх ажилд 79.3 сая төгрөг, Говил баг, Арбулаг хэсэгт 6/0.4 кВ-ын 160 кВА дэд станц, 6/0.4 кВ-ын ЦДАШ барих ажилд 96.2 сая төгрөг, Уурхайчин багт хот дахин төлөвлөлтийн барилгажуулах төслийн цэвэр усны шугам шилжүүлэх ажилд 243.6 сая төгрөг, Уртын гол багт баригдсан 260 айлын орон сууцны ус, дулаан, дамжуулах төвд нэмэлт тоноглол суурилуулах ажилд 36.7 сая төгрөг, Чандмань багт Эко хорооллын гадна шугам сүлжээний шинэчлэлт, засварын ажилд 543.8 сая төгрөг, Дэнж багийн Баруун Дэнжийн 4 дүгээр гудамжинд байршилтай ус түгээх байранд цэвэр усны нөөцийн сав байрлуулах /гадна пандусны хамт/ ажилд 13.2 сая төгрөг нийт 1.1 тэрбум төгрөгийг болзошгүй аваарын зардлаар шийдвэрлэснээр нийт ажлын гүйцэтгэл 81 хувьтай хэрэгжсэн. 2024 онд эвдрэл үүсэн инженерийн шугам сүлжээ, барилгын байгууламжийн талаар аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулснаар аймгийн Засаг даргын 7 захирамж гарч 24 бараа материалын, 19 ажлын зардалд аймгийн болзошгүй аваарын зардлаас нийт 1.3 тэрбум төгрөг зарцуулан засварын ажлыг хийж гүйцэтгэж байна.	90%
111	4.1.2.Гэр хорооллын дахин төлөвлөлт, шинэ суурьшлын бүсийг бий болгох, байгальд ээлтэй, эрчим	Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаах хэрэгсэл нэвтрүүлэх	2021-2024	ХЗА БОАЖ Г	Баян-Өндөр сумын ЗДТГ	Улсын болон орон нутгийн төсөв, төсөл	Батлагдсан төсвийн хүрээнд	-	50 өрх	Төсөв болон Хувийн зардал	2021-2023 онд Орон нутгийн төсөв 150.0	Агаар бохирдуулагч суурин эх үүсвэрийн тоог бууруулах зорилгоор 2022 онд 49 өрхөд, 2023 онд 60 өрхөд, 2024 онд 73 өрхөд тус тус монгол гэрийн дулаалга, цахилгаан халаалтын багц/ЧИП/-ыг олгож яндангийн тоог 182 ширхгээр бууруулсан. Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд	100%

	хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилга байгууламжийг нэмэгдүүлэх, дэд бүтэц барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.					хөтөлбөр					2024 онд Орон нутгийн төсөв 150.0	2024 онд Хабрид хаус ХХК-тай хамтран Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн багц бүтээгдэхүүнийг 13 өрхөд хөнгөлөлттэй үнээр олгож, агаар бохирдуулагч эх үүсвэрийн тоог буурууллаа. Мөн гэр, байшингийн халаалтын эх үүсвэрээ өөрийн хөрөнгөөр цахилгаан халаалтаар шийдвэрлэж, яндангаа буулгасан 184 өрх нэмэгдсэнээр өссөн дүнгээр 379 өрх эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаах хэрэгсэл нэвтрүүлээ.	
112		Бие даасан сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй барилга, гэрэлтүүлэг шинээр барих (Нарны болон салхины эрчим хүч)	2021-2024	ХЗА ХБТХ ОХ	БОАЖ Г Баян-Өндөр сумын ЗДТГ	Төсөл хөтөлбөр Иргэдийн оролцоо	500.0	-	25 өрх	Төсөв болон Хувийн зардал	Орон нутгийн төсөв 750.0 НҮБХС 700.0 сая	НҮБ-ийн Хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлж буй Яргуйт багийн төрийн байгууллагуудын дулааны эх үүсвэрийг газрын гүний дулаанаар шийдвэрлэх төслийн ажлыг Смарт Энержи ХХК гүйцэтгэж байна. Төслийн хүрээнд нийт 26 цооног өрөмдөхөөс 19 цооног өрөмдөж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Хидро Инженеринг ХХК-иар гүйцэтгүүлж, баталгаажууллаа. Төслийн гүйцэтгэлд НҮБ-ийн Хүүхдийн сан, аймгийн ЗДТГ хамтран хяналт тавин ажиллаж байна. Уг төсөл хэрэгжсэнээр 300 орчим айл өрхийн энгийн зуухны янданг буулгасантай тэнцэх хэмжээний бохирдлыг бууруулна. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах ажлын хүрээнд БОУАӨЯ, НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Баян-Өндөр сумын гэр хорооллын 19 м.кв хүртэлх талбай бүхий монгол гэртэй 24 айл өрхийн гэрийн дулаалга, халаалт, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн иж бүрэн багцыг олгох, хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг тооцож, баталгаажуулах төслийг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулж, тоног төхөөрөмжийн суурилуулалтыг хийж байна. 17-р сургуулийн уурын зуухыг шинэчлэх, бие даасан эрчим хүчний үүсвэртэй болгож, агаарын бохирдлыг бууруулах зорилгоор "Гор газ" ХХК бүрэн автоматжуулагдсан 1400 квт-ын хүчин чадалтай, тохируулга бүхий хяналт удирдлагын систем, хийн түлшний усан халаалтын зуухыг суурилуулахаар ажиллаж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар хийн хангамжийн болон дулааны хэсэг болон дулааны узелийн 10х5 хэмжээний барилга, бүх шугамын холболт, цахилгааны ажил бүрэн хийгдэж аюулгүй ажиллагааны систем	50%



												ашиглалтад орсноор туршилт, зүгшрүүлэлтийн ажил хийгдэхэд бэлэн болсон. Гэр хорооллын Цагаанчулуут багт 1 өрх нарны эрчим хүч хураах 4 панель ашиглаж, өрхийнхөө цахилгааны хэрэглээ болон нам даралтын цахилгаан халаагуурыг халаан ашиглаж байна.	
113	4.1.3. Хотын доторх ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг стандартын түвшинд хүргэж, шинэчилнэ.	“Ногоон-Эрдэнэт” төслийг боловсруулан хэрэгжүүлэх	2021-2024	ХЗА	БОАЖ Г ЦНБ	Орон нутгийн төсөв	1000	-	Төслийн хэрэгжилт 25%	Төлөвлөгөө биелэгдсэн байна.	2021-2023 орон нутгийн төсөв 1,340.0 2024 онд орон нутгийн төсөв 450.0	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Орхон аймгийн хэмжээнд 2030 он хүртэл хугацаанд 20.0 сая ширхэг мод тарих "Ногоон Эрдэнэт" хөтөлбөрийг боловсруулан аймгийн ИТХ-ын 2022 оны 07/02 дугаар тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд 3 зорилтын хүрээнд 14 арга хэмжээтэй байхаар төлөвлөн хэрэгжүүлэн ажиллаж байна. Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд Орхон аймгийн хэмжээнд 2022 онд 1.234.847 ширхэг мод, 2023 онд Дэнж багийн нутаг дэвсгэр Тарлан толгойн энгэрт 17.5 га-д ойн төгөл, Жаргалант суманд 6.6 га-д газар тариалангийн ойн зурвас, Сархиа уул, Хангал гол, Эрдэнэт хаалга орчим, Эрдэнэт голын эх, Хүрэн булгийн ам зэрэг газруудад 12.66 га талбайд нийт 1.888.068 ширхэг мод тарьсан. Мод тарих ажлыг зохион байгуулснаар 2023 онд Дэнж багийн нутаг дэвсгэр Тарлан толгойн энгэрт 17.5 га-д ойн төгөл, Жаргалант суманд 6.6 га-д газар тариалангийн ойн зурвас, Сархиа уул, Хангал гол, Эрдэнэт хаалга орчим, Эрдэнэт голын эх, Хүрэн булагийн ам зэрэг газруудад 12.66 га талбайд нийт 1888068 ширхэг мод тарьсан. 2024 онд 1.474.671 ширхэг мод тарих олон талт ажлыг зохион байгууллаа. Мод тарих ажлыг зохион байгуулснаар нийт 294.06 га талбайд суурь он /242100/-оос өссөн дүнгээр таримал модны хэмжээг 4.839.686 ширхэгт хүргэж Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн нэгдүгээр үе шатны хугацааг 100 хувьд хүргээд байна.	100%
114		Нийтийн эзэмшлийн талбайн ногоон байгууламжийг иргэд аж ахуй нэгж, байгууллагуудын оролцоотойгоор нэмэгдүүлэх	2021-2024	ХЗА	Сумдын ЗДТГ	Байгууллагын зардал	ААНБ н зардал	20 ААНБ	25 ААНБ	Хувийн зардал	-	Хотын доторх нийтийн эзэмшлийн ногоон байгууламж нэмэгдүүлэх зорилгоор 2022-2023 онд нийтийн эзэмшлийн гудамж талбайд нийт 24996 мод, бут, сөөг тарьж, 15040м2 талбайд Согоовор болон өлөнгө сортын үрээр зүлэгжүүлэлт, 4100м2 талбайд хуйлдаг зүлэг тарьж зүлэгжүүлсэн. 2024 онд бүх нийтийн мод тарих ажлын хүрээнд хавар, намар Хангал гол дагуу, Сархиа уул,	100%

												Хүрэнбулгийн ам, Далиу булаг, Дэл хошуу, Тарлан толгойн энгэр зэрэг газар болон айл өрхүүд хашаандаа мод тарих ажлыг зохион байгуулснаар нийт 5 төрлийн нийт 88498 ширхэг мод тарьж, усалгаа тордолтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Аймгийн хэмжээнд нийт ногоон байгууламж 294.06 га талбай болсноор 1 хүнд ноогдох ногоон байгууламжийг 9.2 м <sup>2</sup> -д хүргэлээ.	
115	4.1.4.Гэр хороололд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлэх, усны зөв хэрэглээний талаар бүх нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.	Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан эко ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлэх	2021-2024	ХБТХ ОХ БОАЖ Г ХЗА	Сумдын ЗДТГ	БОХАХ 3 болон улсын төсөв, олон улсын төсөл хөтөлбөр	800.0	500 ш	200 ш	200.0	2021-2023 онд орон нутгийн төсөв 600.0 2024 онд Орон нутгийн төсөв 290.0	2019 онд БОАЖЯ, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөртэй хамтран 500 өрхийн нүхэн жорлонг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар сольж бохирдуулагч эх үүсвэрийн тоог бууруулсан. 2020-2023 онд нийт 1218ш эко ариун цэврийн байгууламжийг шинээр барьж ашиглалтад оруулснаар аймгийн хэмжээнд нийт 1718 эко ариун цэврийн байгууламжтай болоод байна. БОУАӨЯ, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дэмжлэгтэйгээр аялал жуулчлалын отоглох цэгүүдэд аялагч, түр амрагч нарт зориулсан MNS5924:2015 стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж, хогийн цэг бүхий түр буудаллах буудал байгуулж, тухайн орон нутгийн хөрс, гүний усны бохирдол, хог хаягдлыг бууруулж, аялагч, амрагчдыг эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах, байгаль орчныг хамгаалах зорилгоор улсын хэмжээнд 6 байршилд нийтийн ариун цэврийн байгууламж барих ажлыг Дархан нэгдэл ХХК гэрээний дагуу хийж гүйцэтгэлээ. Тус ажлын хүрээнд аялал жуулчлалын түр буудаллах цэг болох Эрдэнэт хаалга орчмын нийтийн ариун цэврийн байгууламжид зориулсан гүний худаг шинээр гаргах байршлыг мэргэжлийн байгууллагатай хамтран тодорхойлж, нарны гэрлээр цэнэглэгддэг шон, ангилдаг хогийн сав бүхий 3.5х7м урттай эко ариун цэврийн байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэн ашиглалтад орууллаа. 2024 онд Гэр хорооллын иргэдийн ус хангамжийн эх үүсвэрийг хөрсний бохирдлоос хамгаалж, эрүүл ахуйн бүсэд ойр байрлалтай Дэнж багийн 20 өрхийн нүхэн жорлонг шинэчилснээр нийт 1738 ширхэг эко ариун цэврийн байгууламжийг шинэчлэн ажиллалаа.	100%

												Мөн нүхэн жорлонгийн тоог бууруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2024 онд өөрийн хөрөнгөөр эко ариун цэврийн байгууламж барьсан болон бага оврын цэвэрлэх байгууламж суурилуулсан иргэнд 1 удаагийн урамшуулал олгох журмыг боловсруулж, Баян-Өндөр сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж, нийт 200 өрхийг хамруулахаар иргэдийн хүсэлтийг хүлээн авч байна. Мөн аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 22 ШТС-д эко ариун цэврийн байгууламжийг барилаа.	
116		Усны хэрэглээний талаар зөв мэдлэг, хандлага, дадлыг бий болгох сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах	2021-2024	ХБТХ ОХ БОАЖ Г МХГ СГСГ 3	Сумд ын ЗДТГ "ЭУДТ С" ОНӨХ К	БОХАХ 3	4.0	16 удаа	4 удаа	1.0	2021-2023 онд Орон нутгийн төсөв 5.0  2024 онд Орон нутгийн төсөв 5.0	Жил бүр дэлхийн усны өдрийг тохиолдуулан усны үнэ цэн, усны өдөр тутмын зөв зохистой хэрэглээ, усыг хайрлан хамгаалах, ач холбогдлын талаар мэдээлэл сурталчилгаа, сургалт, тэмцээн гэх мэт олон талт арга хэмжээг зохион байгуулж ирсэн. 2020-2023 онд хотын ус хангамж, түгээлт, нийлүүлэлтийн талаар сурагчдын дунд аялал зохион байгуулж, Бүрэнбүстийн унд, ахуйн ус хангамжийн эх үүсвэрт ажилласан. Ерөнхий боловсролын сурагчдын дунд усны чиглэлээр АХА танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулж, тэмцээнд амжилттай оролцсон сурагчдыг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнасан. Хүүхэд, залуучуудын театртэй хамтран "Ус" драмын жүжгийг сурагчдад үзүүлж, усны үнэ цэнэ, ач холбогдлын талаар мэдээлэл хүргэлээ. "Гүүд нэйборс" олон улсын ТББ-ын Монгол дахь суурин төлөөлөгч, Орхон аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу "Ундны ус эрүүл ахуй" хөтөлбөрийн хүрээнд сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулж аймгийн БОАЖГ, ЭМГ, Баян-Өндөр сумын сумын ЗДТГ, Яргуйт, Их залуу, Эрдэнэ, Дэнж багийн ажлын албаны албан хаагчид хамрагдлаа. Дээрх хөтөлбөрийг орон нутгийн хөгжлийн хөтөлбөрт тулгуурлан, өрхийн түвшинд ундны усны аюулгүй байдлыг хангах, ариун цэврийн байгууламжийн оновчтой хэрэглээний талаар өрхийн гишүүдийн ойлголтыг нэмэгдүүлж, эрүүл аж төрөх зөв дадал хэвшилтэй болохыг дэмжих зорилгоор гэр хорооллын 1166 иргэнд сургалт хийсэн. 2024 онд дэлхийн усны өдрийг "Ус ба энхтайван" уриан дор тэмдэглэж, усны нөөцийн	100%

											<p>нэгдсэн менежментийг хэрэгжүүлэх, оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилготой “Усны нөөцийн нэгдсэн менежмент - талуудын оролцоо” форумыг Усны газраас зохион байгууллаа. Тус арга хэмжээнд Сав газрын захиргаадын дарга, мэргэжилтнүүд, Сав газрын талуудын оролцооны зөвлөл, аймаг, нийслэлийн БОГ-ын усны асуудал хариуцсан мэргэжилтнүүд, их дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, мэргэжлийн холбоод, ус ашиглагч байгууллагууд, олон Улсын төсөл хөтөлбөрийн төлөөлөл болох нийт 250 орчим хүн оролцлоо.</p> <p>Мөн Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Баян-Өндөр сумын ИТХ, Сэлэнгэ голын сав газрын захиргаа, 8-р цэцэрлэгтэй хамтран цэцэрлэгийн багш нарын дунд “Усны зөв хэрэглээ” сэдэвт шилдэг илтгэл шалгаруулах уралдаан, аймгийн БОГ, Баян-Өндөр сумын ЗДТГ, Насан туршийн суралцахуйн төвүүд хамтран аймгийн хэмжээнд гэр бүл, иргэдэд зориулсан богино хэмжээний дүрс, бичлэгийн бүтээлийн уралдааныг тус тус зохион байгуулж, шилдэг оролцогчдыг шагнаж урамшууллаа.</p>		
117	4.1.5.Агаарын бохирдлыг бууруулах боломжит судалгааг хийж төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологийг бодлогоор дэмжинэ.	Эрдэнэт хотын агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлж, бохирдлыг бууруулах	2021-2024	ХБТХ ОХ БОАЖ Г ХЗА Сумд ын ЗДТГ	ААНБ	БОХАХ 3 болон улсын төсөв	330.0	Pm10- ст- с 1.4 дахин давсан	MNS4585: 200 ст-ын түвшин	100.0	<p>2021-2023 онд Орон нутгийн төсөв 60.0</p> <p>2024 онд Орон нутгийн төсөв 1522.4</p> <p>Төсөл хөтөлбөр /ОУБ/ 8.52 \$</p>	<p>Орхон аймгийн хэмжээнд хотын төв, гэр хороолол орчимд агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO2), азотын давхар исэл (NO2) тодорхойлох агаарын чанарын хяналт шинжилгээний суурин 2 харуул дээр тогтмол хяналт, шинжилгээ хийгдэж дүн мэдээг <a href="http://192.168.100.13/currentweather/edts/login.asp">http://192.168.100.13/currentweather/edts/login.asp</a> дотоод сүлжээнд өдөр бүр дамжуулж байна. Агаарын чанар 2024 хяналт шинжилгээний дүнгээр хүхэрлэг хийн дундаж агууламж 3 мкг/м<sup>3</sup> буюу агаарын чанарын MNS 4585:2016 стандарт дахь Хүлцэх агууламж 450 мкг/м<sup>3</sup> -аас хэтрээгүй байна. Азотын давхар ислийн дундаж агууламж 99 мкг/м<sup>3</sup>, стандартын Хүлцэх агууламж 200 мкг/м<sup>3</sup> -аас хэтрээгүй байна. Агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлээр 13614 айл өрх, 11 аж ахуйн нэгж, байгууллагын 28 уурын зуух, 24398 авто тээврийн хэрэгсэл байна. Агаар бохирдуулагч суурин эх үүсвэрийн тоог бууруулах зорилгоор монгол гэрийн дулаалга, цахилгаан халаалтын багц /ЧИП/-ыг олгож яндангийн тоог 182 ширхгээр бууруулсан. Агаарын бохирдлыг</p>	90%

											<p>бууруулах ажлын хүрээнд 2024 онд Хабрид хаус ХХК-тай хамтран Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн багц бүтээгдэхүүнийг 13 өрхөд хөнгөлөлттэй үнээр олгож, агаар бохирдуулагч эх үүсвэрийн тоог буурууллаа. Мөн гэр, байшингийн халаалтын эх үүсвэрийг өөрийн хөрөнгөөр цахилгаан халаалтаар шийдвэрлэж, яндангаа буулгасан 184 өрх нэмэгдсэнээр өссөн дүнгээр 379 өрх эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаах хэрэгсэл нэвтрүүлээд байна. Эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг бүрдүүлэх ажлын хүрээнд Дэлхийн банкны 8.52 сая долларын санхүүжилтээр төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээнд холбогдсон 4763ш өрхийг 2 тарифт ухаалаг тоолуурт шилжүүлж, Баян-Өндөр сумын гэр хорооллын 16 багийн гудамж хоорондын 0.4кВ-ын 6719 ширхэг цахилгааны модон тулгуурыг төмөр бетон шонгоор сольж, 260.18 км СИП кабель татагдаж, 6/0.4кВ-ын 3ш дэд станц баригдлаа. Цахилгааны хүчдэлийн уналт ихтэй Рашаант, Яргуйт, Баян-Овоот, Шанд, Даваат, Уртын гол, Их залуу, Цагаанчулуут, Наран багуудад 6кВ-ын хуваарилах байгууламж дэд станцыг орон нутгийн төсвийн 1.39 тэрбум төгрөгөөр гүйцэтгүүлж, эрчим хүчний уналтыг буурууллаа. Мөн цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлтийг өрх бүрт эдлүүлэх зорилгоор орон нутгийн төсвийн 124.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2 тарифт тоолуурыг худалдан авч, Эрдэнэт Ус ОНӨХК-д харъяалагддаг хэсгийн 780 айл өрхөд хөнгөлөлттэй үнээр олголоо. НҮБ-ийн Хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлж буй Яргуйт багийн төрийн байгууллагуудын дулааны эх үүсвэрийг газрын гүний дулаанаар шийдвэрлэх төслийг Смарт Энержи ХХК гүйцэтгэж байна. Төслийн хүрээнд нийт 26 цооног өрөмдөхөөс 19 цооног өрөмдөж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Хидро Инженеринг ХХК-иар гүйцэтгүүлж, баталгаажууллаа. Төслийн гүйцэтгэлд НҮБ-ийн Хүүхдийн сан, аймгийн ЗДТГ хамтран хяналт тавин ажиллаж байна. Уг төслийг хэрэгжүүлснээр 300 орчим айл өрхийн энгийн зуухны янданг буулгасантай тэнцэх хэмжээний бохирдлыг бууруулна.</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	---

												Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах ажлын хүрээнд БОАЖЯ, НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Баян-Өндөр сумын гэр хорооллын 19 м <sup>2</sup> хүртэлх талбай бүхий монгол гэртэй 24 айл өрхийн гэрийн дулаалга, халаалт, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн иж бүрэн багцыг олгох, хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг тооцож, баталгаажуулах төслийг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулж, тоног төхөөрөмжийн суурилуулалтыг хийж байна.	
118		Байгальд ээлтэй газын хэрэглээ болон бусад үр ашигтай дэвшилтэт ногоон технологийг бодлогоор дэмжих	2021-2024	ХБТХ ОХ БОАЖ Г	ХЗА Сумдын ЗДТГ	БОХАХ 3 болон улсын төсөв	300.0	Хийн хөдөлгүүр тэй тээврийн хэрэгсэл-1363 ш Хийн халаалтын систем-0	Хийн халаалтын систем - 20	100.0	2021-2023 онд Орон нутгийн төсөв 656.9	Эрдэнэт хотын хэмжээнд ахуйн болон тээврийн хэрэгслийн зориулалтаар шингэрүүлсэн шатдаг хийн түлш түгээдэг 4 аж ахуйн нэгж байгууллага тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. Цахилгаан автомашины хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор Leaf center ХХК-тай хамтран иргэдэд цахилгаан автомашины ач холбогдлыг танилцуулах өдөрлөгийг Амарын талбайд 4 өдрийн турш зохион байгуулж, 6 төрлийн цахилгаан автомашиныг нийт 10-12 мянган хүнд сурталчилж, мэдээллээр хангаж ажиллалаа. Цахилгаан автомашины хэрэглээг дэмжих зорилгоор томоохон худалдааны төвийн гадна зогсоолд цахилгаан машин цэнэглэх станц байрлуулахаар Leaf center ХХК-тай хамтран ажиллаж байна. Аймгийн хэмжээнд хийн хөдөлгүүртэй 1164 ширхэг, цахилгаан хөдөлгүүртэй 12 ширхэг, хосолсон хөдөлгүүртэй 12041 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн байна. Даваат багт байрлалтай 17 дугаар сургуулийн уурын зуухыг буулгаж шинээр бүрэн автоматжуулагдсан тохируулга бүхий хяналт удирдлагын системтэй хийн түлшний усан халаалтын зуух суурилуулахаар 656.9 сая төгрөг батлагдсан. Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгөөр тендер зарлаж ажил гүйцэтгэгчээр Горгаз ХХК Горгаз ХХК шалгарч ажлыг гүйцэтгэл 80 хувьтай явагдаж байна.	100%
119	4.1.6.Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ.	Эрдэнэт хотын хатуу хог хаягдлын боловсруулах, татан зайлуулах менежментийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх	2021-2023	ХБТХ ОХ ХЗА	ХТГ	Гадаадын зээл	30150.0	-	Төслийн хэрэгжилт 90%	-	Засгийн газар хоорондын хөнгөлөлттэй зээл 9 сая евро	Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах" төслийг хэрэгжүүлэх гэрээг байгуулж, Бүгд Найрамдах Польш улсын Засгийн газар, Монгол улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хамтран хэрэгжүүлж байна. Төслийг хэрэгжүүлэхээр Польш улсын ППЭйч	70%

											Мелиорекс ХХК шалгарч, түлхүүр гардуулах нөхцөлтэй ажлын гэрээг Орхон аймагтай 2019 онд байгуулсан. Гэрээний бүрэлдэхүүн хэсэг болох хог хаягдлыг татан зайлуулах 12 ширхэг машин механизмыг бүрэн хүлээн авч Хот тохижуулах газар хүлээлгэн өгсөн. Төслийн хүрээнд баригдах хог ангилан ялгах үйлдвэрийн барилгын сөндвичэн хавтан дутуу хэсэгт угсрах ажил 90%, хатуу хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр хүртэлх авто машины хайрган зам тавих ажил-100%, Үйлдвэрийн хайсан хашаа барих ажил 90%, гадна зам талбайн газар шорооны ажил 95%, хатуу хог хаягдал дахин боловсруулах тоног төхөөрөмж суурилуулалтын ажил 50%, Үйлдвэрийн хаалга угсрах ажил 85%, үйлдвэр хүртэлх цахилгаан шугамын ажил 95%, үйлдвэрийн цонх суурилуулах ажил 75%-тай хийгдэж байна.		
120		Олон нийтэд хог хаягдлын талаар боловсрол олгох, үүрэг хариуцлага оролцоог нэмэгдүүлэх, сургалт зохион байгуулах	2021-2024	ХЗА	БОАЖ Г Баян-Өндөр сумын ЗДТГ	Орон нутгийн төсөв	15.0	Иргэдийн оролцоог 10%-иар нэмэгдүүлсэн байна.	Иргэдийн оролцоог 10%-иар нэмэгдүүлнэ.	5.0	-	2022-2024 онд Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд олон нийтэд хог хаягдлын талаар боловсрол олгох, үүрэг хариуцлага оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд: 1. Хог хаягдлын Алтан дүрэм буюу Хогийг хогийн саванд.", 3R зарчмыг нийт 80 төрийн болон төрийн бус байгууллагуудын 330 ажилтан алба хаагч нарт танилцуулж, дадал болгох ажлыг зохион байгуулсан. Цагаан тоосжилтын эх үүсвэрийн бүс буюу өндөр тархалттай байршилд байрлах хог хаягдлын нэгдсэн цэгийн хөрсний доройтлыг бууруулах цагаан тоосжилтын эх үүсвэрийг багасгах, тархсан хог хаягдлыг хумих, зогсоох, далан байгуулах, нөхөн сэргээлт хийх, ногоон зурвас бий болгох, ойжуулалтын ажлыг хийж 30 гаруй төрийн байгууллагын 486 төрийн албан хаагч, Хот тохижуулах газрын 118 ажилтан алба хаагчид хогийн цэгийн орчмын 104.8 га талбайн түүвэр хог хаягдлыг цэвэрлэн, хог хаягдлын алтан дүрэм нөлөөллийн сургалтад хамрагдсан. "Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд иргэдэд соён гэгээрүүлэх, нөлөөллийн ажлыг хийх сургагч багш бэлдэж, "Соёлоороо ялгарцгаая" сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулж төрийн болон төрийн бус байгууллагын нийт 2560 хүн сургалтад хамрагдсан.	100%

											<p>Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг сурталчлах, иргэдэд соён гэгээрүүлэх, зөв хандлагыг бий болгох зорилгоор богино хэмжээний бичлэг, шторк бэлдэж орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийтийн сошиал хаягаар дамжуулан 32 мэдээ, 60 шторк, контент, бичлэгийг иргэдэд хүргэж ажилласан. Аймгийн хэмжээнд ЯЛГАЖ САЛГАЯ сэдэвт хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах нөлөөллийн аяныг аяныг эхлүүлж 900 өрхийн 2700 иргэд хамрагдсанаар хогийг дахин боловсруулах замаар эргэлтэд оруулж бүтээгдэхүүн болгох, эдийн засгийн ашиг тус хүртэж, эх дэлхийгээ хамгаалах боломжийг эрэлхийлдэг болсон.</p> <p>Аймгийн хөршийн холбоо гудамжны ахлагч нарыг чадавхжуулах тэднээр дамжуулан иргэдийг соён гэгээрүүлэн нөлөөллийн ажлын хүрээнд нийт 1050 иргэнийг сургалтад хамруулж төлөвлөн ажилласнаар аймгийн хэмжээнд 12700 орчим иргэд буюу хүн амын 12%-д хог хаягдлын талаар ойлголт, мэдээ мэдээллийг хүргэсэн.</p> <p>Хот тохижуулах газраас иргэд олон нийтэд хог хаягдлын чиглэлээр мэдээллүүдийг видео болон зурган хэлбэрээр хүргэн ажиллаж байна. 2024 онд нийт 258 мэдээлэл нийтэлж, байгууллагын санал хүсэлт авах 77145454 утсаар иргэдээс 53 санал хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн. Цахим хуудсанд ирсэн 42 иргэдийн санал хүсэлтэд хариу мэдээлэл өгч хариуцсан албан тушаалтантай холбож өгч ажилласан.</p>	
121	Хот тохижуулах газарт техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг үе шаттай хийх	2021-2024	ХЗА ХТГ	ХБТХ ОХ	Орон нутгийн төсөв	Тухайн төсвийн хүрээнд	Парк шинэчлэлт 5%	Парк шинэчлэлт 50%	Батлагдсан төсвийн хүрээнд	<p>2023 онд орон нутгийн төсөв 4050.0</p> <p>2024 онд Орон нутгийн төсөв 1900.0</p>	<p>Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах" төслийн хүрээнд хог хаягдлыг татан зайлуулах 12 ширхэг машин механизмыг Хот тохижуулах газар хүлээлгэн өгсөн.</p> <p>2023 онд орон нутгийн төсвийн нийт 2.65 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хот тохижуулах газрын парк шинэчлэлтийг хийж байна. Үүнд: Хог хаягдал ачиж тээвэрлэх 45 ширхэг хөдөлгөөнт чингэлэг, 7 ширхэг автомашиныг хүлээлгэн өгсөн. 2024 онд орон нутгийн төсвийн 1.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хог хаягдал ачиж тээвэрлэх ковш, бульдозер,</p>	100%



												грейдер, индүү тус бүр 1ш, зам цэвэрлэгээний машин 3ш авсан. Парк шинэчлэлтийг хийснээр Хот тохижуулах газарт 49 машин механизм, 110 хөдөлгөөнт чингэлэгтэй болж, 2024 онд гэр хорооллын хог хаягдлыг 8-9 удаа ачиж тээвэрлээд байна. Хот тохижуулах газрын парк шинэчлэл 90 хувьд хүрсэн байна.	
122	4.1.7.Гүний усны ашиглалтын хязгаарлан, гадаргын усны хуримтлал бий болгож, усны нөөцийг бохирдол, хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, аймгийн цэвэр усны хангамжийн асуудлыг үе шаттай шийдвэрлэж, цэвэрлэсэн болон саарал усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглана.	Гадаргын усны чанарын хяналт, мониторингийг тогтмол, хуваарийн дагуу хийж мэдээллээр хангах	2021-2024	УЦУО ШТ	БОАЖ Г МХГ	Улсын төсөв	-	-	MNS 4586:1998 Стандартын түвшин	-	-	Байгаль орчны шинжилгээний лаборатори нь гадаргын усны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн дагуу 2024 оны жилийн эцсийн байдлаар Хангал голын 4 цэгийн 48, Уртбулаг-Эрдэнэт гол 4, Чингэл-Эрдэнэт гол 4, Орхон голын 2 цэгийн 24 дээжид 23 үзүүлэлтээр нийт 80 дээжид 1840 удаагийн давталттай орчны чанарын хяналт-шинжилгээ хийж гүйцэтгэсэн. 2024 оны 1-р сард Орхон-Хангал доод цэг ёроолдож хөлдсөн тул дээж авах боломжгүй байсан. Шинжилгээний дүнгээр Хангал-Эрдэнэт гол 3-р зэрэг буюу бага бохирдолтой, Орхон гол 2-р зэрэг буюу Цэвэр, Уртбулаг-Эрдэнэт гол 3-р зэрэг буюу бага бохирдолтой, Чингэл-Эрдэнэт гол 2-р зэрэг буюу цэвэр түвшинд байна. Хяналт шинжилгээний дүн мэдээг ЦУОШГ-ын мэдээллийн сан болон БОХЗТ лабораторид сар бүрийн 1-ны дотор дамжуулж байна. Мөн Орхон аймгийн УЦУОШТ-ийн <a href="http://orkhon.tsag-agaar.gov.mn/">http://orkhon.tsag-agaar.gov.mn/</a> сайт дээр сар бүрийн тайлан мэдээг оруулж ард иргэдэд мэдээлж байна.	100%
123		Бохирдуулагч эх үүсвэрүүдийн технологийн хяналтыг сайжруулж, сөрөг нөлөөллийг бууруулах	2021-2024	МХГ БОАЖ Г	УЦУО ШТ	ААНБ-ын өөрийн зардлаар	-	-	-	-	-	Бохирдуулагч эх үүсвэрүүдийн эрсдэлийг бууруулах зорилгоор 2024 онд төлөвлөгөөт хяналт шалгалтаар 45 аж ахуйн нэгж, байгууллага, төлөвлөгөөт бус 2 аж ахуйн нэгж байгууллага, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 9 чиглэлээр 81 иргэн, 67 үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад 13 албан шаардлага 63 заалттайгаар гүйцэтгэж, 50 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд улсын байцаагчийн 278 заалттай албан шаардлага хүргүүлж ажиллалаа. Мөн 2 хуулийн этгээдэд тус бүр 500.0 мянган төгрөгийн торгууль ногдуулж, барагдуулан зөрчлийг арилгуулсан. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн албан байгууллагуудын хяналтын цооногийн усанд УЦУОШТ нь хяналт шинжилгээ хийж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар "Ачит-Ихт"	100%

												ХХК-ийн хяналтын цооногийн ус 96, агаар 18, хөрс 10, "Эрдмин" ХХК-ийн ус 64, агаар 28, хөрс 10, "Эрдэнэт хивс" ХХК-ны бохир ус 29, агаар 2, хөрс 2, "Зэс эрдэнийн хувь" ХХК-ийн хяналтын цооногийн ус 69, агаар 18, хөрс 6 зэрэг нийт 22 аж ахуйн нэгж байгууллагад нийт 295 усанд, агаар 112, хөрс 55 хяналт-шинжилгээ тус тус хийгдсэн байна.	
183		Шинээр бий болж буй суурьшлын бүсэд нийтийн тээврийн үйлчилгээг хүргэх, маршрут нэмэгдүүлэх	2021-2024	ХБТХ ОХ	АТТ	Төр, хувийн хэвшил хамтарч	Хөрөнгө шаардлагагүй.	100%	Шинээр бий болсон суурьшлын бүсэд нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлснээр иргэдийн ая тухтай зорчих боломж бүрдсэн байна.	Хөрөнгө шаардлагагүй	-	Аймгийн хэмжээнд шинээр бий болсон суурьшлын бүс болон асфальтбетон хучилттай авто зам ашиглалтад орсонтой холбогдуулан 2021-2022 онд "Төгөл-Вокзал" чиглэлийг шинээр баталж хэрэгжүүлсэн. 2023 онд аймгийн Засаг даргын А/597 дугаар захирамжаар Ч8: буюу "Даниста-Урд Хабитат-Дэнж-Уртын гол" чиглэл, 2024 оны А/620 дугаар захирамжаар Ч5: буюу "Хүлэг зах-Автовокзал-Говил" гэсэн чиглэлүүдийг тус тус баталж хэрэгжүүлж байна. Ч8, Ч5 чиглэлүүдэд 15 ширхэг шинэ автобусыг ХТГазарт хариуцуулан 2024 оны 07 дугаар сараас эхлэн нийтийн тээврийн үйлчилгээнд явуулж байна. Нийтийн тээврийн үйлчилгээнд явж буй автобусны парк шинэчлэлт хийгдсэнээр 7 чиглэлд 31 дунд оврын автобус үйлчилгээнд явж байна.	100%
184	5.10.2.Сурагчдын автобусны буудал болон хот	Хотын доторх чиглэлийн нийтийн зорчигч тээвэр,	2021-2024	ХБТХ ОХ	АТТ	Орон нутгийн төсөв	460.0	75 сүүдрэвч 80%	10 сүүдрэвч 25%	115.0	2021-2023 онд Орон	2021-2023 онд аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр 8 ширхэг автобусны буудлыг барьж ашиглалтад	47.5%

	хоорондын зорчигч тээврийн үйлчилгээний нэгдсэн авто буудал байгуулж, зорчигч тээвэрлэлтийн аюулгүй байдал, үр ашгийг нэмэгдүүлнэ.	сурагчдын автобусны үйлчилгээнд шаардагдах зогсоол, сүүдрэвч барих							/жил бүр/		нутгийн төсөв 211.3 2024 онд орон нутгийн төсөв 303.5	оруулсан. Аймгийн хэмжээнд нийт 192 автобусны буудал байгаагаас 98 нь буюу 51 хувь нь зогсоолын байгууламж бүхий 94 нь буюу 47.5 хувь нь, стандарт шаардлага хангасан нийтийн тээврийн үйлчилгээний болон сурагчдын автобусны буудал байна. 2024 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Авто вокзалын өмнө 1 ширхэг, Эрх чөлөөний гудамжны хэсэгт /Цагдаагийн газрын урд/ 1 ширхэг, 2А хороололд 1 ширхэг, Жаргалант суманд 3, нийт 6 автобусны буудал шинээр барьж ашиглалтад оруулсан бол Баянцагаан багт 1, Жаргалант суманд 4 автобусны буудлыг стандарт шаардлагад нийцүүлэн иж бүрэн засварласан.	
185		Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний төвлөрсөн "Орхон" авто буудлыг барьж, иргэдийг ая тухай зорчих нөхцөлөөр хангах	2021-2022	Аймгийн ЗДТГ	АТҮТ	Улсын болон орон нутгийн төсөв	-	Аймгийн хэмжээнд авто буудал байхгүй.	-	-	2023-2024 онд Улсын төсөв 4500.0	2023 оноос улсын төсвийн 4.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар орон нутагт зорчигч тээврийн үйлчилгээний нэгдсэн "Авто буудал"-ын барилгын ажлыг эхлүүлж 2024 оны 8-р сард ашиглалтад авч үйл ажиллагааг эхлүүлэн жигдрээд байна. Тус Автобуудал нь 2480м.кв талбайтай, 4-н давхар /В1 давхартайгаа/, гадна авто зогсоол нь 7000м/кв талбайтай, 300 орчим тээврийн хэрэгслийн зогсоолын байгууламжтай, зорчигч тээвэрлэлтийн бүх үйлчилгээг нэг дор нэгтгэн үйл ажиллагаагаа явуулж байна. Авто буудал нь өдөрт хот хооронд, аймаг, сум хоорондын зорчигч тээвэрлэлт болон дамжин өнгөрч байгаа нийт 9 чиглэлийн 90-112 тээврийн хэрэгсэл, 1600-1800 зорчигч дамжин өнгөрүүлж байна. Мөн иргэдэд үзүүлэх үйлчилгээний шуурхай байдлыг хангах зорилгоор дараах байгууллагуудыг үйл ажиллагаа явуулах талбай болон албан өрөө тасалгаагаар хангаж, иргэдэд шаардлагатай үйлчилгээг нэг дороос түргэн шуурхай хүргэн, хамтран ажиллаж байна. Үүнд: Зорчигч тээврийн 7 байгууллага, Төрийн банк, Монгол шуудан үйлчилгээний газар, улсын дугаарын 2 үйлдвэр, даатгалын 7 байгууллага, авто үнэлгээний байгууллагууд тус тус байрлаж үйл ажиллагаа явуулж байна. Хаан банк, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банкуудын АТМ, Киоск төхөөрөмж, "Хурдан" гэрэгэ төхөөрөмжүүд суурилагдсан байна.	100%
186	5.10.3 Аймгийн хэмжээнд хатуу хучилттай замын	Хотын доторх хатуу хучилттай авто	2021-2024	ХБТХ ОХ	ХЗА ХББЗ А	Орон нутгийн төсөв	436.5	Өнөөдрийн байдлаар	300 м хатуу хучилттай	Тухайн жилийн батлагд	2021-2023 онд	Хатуу хучилттай авто замыг нэмэгдүүлэх, өргөтгөл шинэчлэлтийн ажлын хүрээнд: 2021 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө	100%



	сүлжээ болон уулзваруудыг өргөтгөж, авто зам ашиглалтын үйлчилгээг сайжруулна.	замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг эхлүүлэх						аймгийн хэмжээнд нийт 92 км хатуу хучилттай авто зам ашиглагд аж байна.	авто зам барьсан байна.	сан төсвийн хүрээнд	Улсын төсөв 10900.0 орон нутгийн төсөв 12400.0  2024 онд Орон нутгийн төсөв 8800.0	оруулалтаар 7.2 км авто зам, 2022 онд 2.1 км авто замыг бүрэн ашиглалтад оруулсан байна. 2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хатуу хучилттай гэрэлтүүлэг, явган хүний зам бүхий иж бүрэн нийт 1.9 км авто зам, нийт 30 км сайжруулсан шороон замыг тус тус дуусгаж ашиглалтад орууллаа. Мөн Даваат багийн Зураа хэсэгт 1, Шанд багийн 20 дугаар гудамжны баруун үзүүр, 35, 36 дугаар гудамжны дунд 1ш, Эрдэнэ багийн 2, 25 дугаар гудамжны үзүүрт 1 ширхэг нийт 3 ширхэг авто машины гүүрэн гарцыг ашиглалтад оруулсан. 2024 онд орон нутгийн төсвийн 8.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинээр 698м урт асфальт бетон хучилттай авто зам, замын байгууламж, 11 багийн 14 байршил 5.8 км авто замд их засвар шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулсан.	
187		Хотын доторх авто зогсоолыг нэмэгдүүлэх	2021-2024	ХБТХ ОХ	ХЗА ХББЗ А	Орон нутгийн төсөв	840.0	Өнөөдрийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 69650 м.кв авто зогсоол ашиглагд аж байна.	5-6 авто зогсоолыг ашиглалтад оруулсан байна.	Тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд	2021-2023 онд Улсын төсөв 219.2 Орон нутгийн төсөв 1600.0  2024 онд Орон нутгийн төсөв 1400.0	2021 онд 8 байршилд 4209 м2, 2022 онд 10 байршилд 7250 м2, 2023 онд 5898 м2 авто зогсоолыг шинээр барьж ашиглалтад оруулсан. 2024 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 7 байршилд 400 авто машины зогсоол хийхээр төлөвлөгдөн ажиллаж, 2-р цэцэрлэгийн гадна 1034 м2 авто зогсоол, 2-р сургуулийн гадна 2606м2 авто зогсоол, Уран эгшиг сургууль, 17-р цэцэрлэгийн орчим 834 м2 хатуу хучилттай авто зогсоол, 18-р цэцэрлэгийн гадна талбайд 933м2 авто зогсоол, 17-р сургуулийн гадна талд 520м2 хатуу хучилттай авто зогсоолыг тус тус ашиглалтад оруулснаар аймгийн хэмжээнд авто зогсоолыг 5927 м2 талбайгаар нэмэгдүүлсэн байна.	100%
188		Хотын доторх авто замын нөхөөс, тэмдэг тэмдэглэгээг үе шаттайгаар хийх	2021-2024	ХБТХ ОХ	ХЗА ХББЗ А	Орон нутгийн төсөв	299.6	Өнөөдрийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 92 км хатуу хучилттай авто замын 15 % -д нь нөхөөс, тэмдэг	5000 м.кв талбайд нөхөөсний ажил хийгдсэн байна.	Тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд	2021-2023 онд орон нутгийн төсөв 3693.5  2024 онд орон нутгийн төсөв 1077.0	Аймгийн хэмжээнд 2021 онд 38 байршилд 3.2 км авто замд 4796м урт хэвтээ тэмдэглэгээ, 105 байршилд шинээр босоо тэмдэг, 217 босоо тэмдгийг сэргээн засварлаж 5073 м2 талбайд авто замын нөхөөсний ажил, 2022 онд 7200 тэмдэглэгээ сэргээх, 50 ширхэг тэмдэг шинээр суулгаж, 5089.7 м.кв талбайд авто замын нөхөөсний ажил тус тус хийж гүйцэтгэсэн байна. 2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 15 байршилд нийт 16512м2 талбайд халуун асфальтбетоноор авто замын нөхөөс, 40427м хэвтээ тэмдэглэгээ, 125ш авто	100%

								тэмдэглэгээний ажил хийгдэж байна.				замын босоо тэмдэг, тэмдэглэгээ, туузан хашлага тус тус хийж гүйцэтгэсэн байна. 2024 онд авто замын сангийн хөрөнгө оруулалтаар авто замын 4665м2 талбайд халуун асфальтаар, 1305м2 талбайд хүйтэн асфальтаар, 375м2 талбайд RZS-1500 хаягдал асфальтаар, болзошгүй аваарын зардлаар 16273.31м2 талбайд замын эвдрэл нөхөх ажлыг хийж, нийт авто замд шаардлагатай 53 ш босоо тэмдэг суулгах ажлыг хийсэн. 2024 онд аймгийн хэмжээнд нийт 22618.31м2 талбайд авто замын эвдрэлийг нөхсөнөөр авто замын 5.6 хувьд нөхөөс, тэмдгийн ажил хийгдэж шинэчлэгдсэн байна.	
189		“Явган зам” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2021-2024	ХЗА ХББЗ А	ХБТХ ОХ	Улс орон нутгийн төсвөөс	1502.4	-	250.0	2021-2023 онд орон нутгийн төсөв 2800.0 2024 онд Орон нутгийн төсөв 1068.7	2021-2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 26264м2 явган хүний замыг стандарт шаардлагын дагуу барьж байгуулсан байна. 2024 онд MNS 5682:2006 “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам”, техникийн шаардлага, стандартын хүрээнд нийцүүлэн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 7 багийн 12 байршилд 5087м 2 явган хүний авто замыг бүрэн шинэчлэн ажилласан байна. Үүнээс: 2-р хорооллын 2-1а, 2-1б байрны орчим 654м2, 4-р хорооллын 26.27-р байрны орчимд 480м2, 1-5, 6 дугаар байрны орчимд 940.6м2, 3-8, 16, 19 дүгээр байрны гаднах явган хүний 2078м2, 10-р цэцэрлэгийн баруун, зүүн хэсгийн явган шат болон Гендрекцийн зүүн талын 32м2 явган шатны засвар, 5-13,14,15 дугаар байрнуудын орчинд 856м2 явган хүний зам, Их залуу багийн 14-р гудамжны нарийн зөрөгт 336м2 явган хүний зам, Булаг багийн 9, 25 дугаар гудамжинд 70м2 явган хүний зам, Зүүн Дэнжийн 3-р гудамжнаас 14-р сургууль руу уруудсан хэсэгт 152м2 явган хүний зам, Согоот багт амралт чөлөөт цагийн талбай тохижуулах, сэргээн засварлах ажилд 480м2 явган хүний зам, 5-р хорооллын байрнуудын дунд 689м2 явган хүний зам шинээр хийх, Хүрэнбулаг багийн нийтийн эзэмшлийн 329м2 явган хүний замын ажлуудыг хийж тус тус ашиглалтад орууллаа.	100%	
ЗУРГАА.АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО													
6.1.Түүх, соёл, уул уурхайд түшиглэсэн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлсэн, цахим систем бүхий тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.													

190	6.2.Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.	“Хөх Монгол”, “Их шүтээн”, “Ёс заншлын өргөө” цогцолборуудын материаллаг бааз, менежментийг сайжруулж, амралтын бүс болгох	2021-2024	Аймаг, Сумдын ЗДТГ	БОАЖГ	Орон нутгийн төсөв	13.0	-	Аялал жуулчлалын салбараас олох орлого нэмэгдсэн байна.	8.0	2021-2023 улсын төсөв 100.0 Эрдэнэт үйлдвэрийн хамтын ажиллагааны хүрээнд 524.0	<p>БОУАӨЯ, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дэмжлэгтэйгээр Эрдэнэтийн угтах хаалга орчимд түр буудаллах цэгийг бий болгож MNS5924:2015 стандартын шаардлага хангасан 3.5x7м хэмжээтэй эко ариун цэврийн байгууламжийг, гүний худаг, нарны гэрлээр цэнэглэгддэг шон, ангилдаг хогийн савны хамт ашиглалтад орууллаа.</p> <p>Их шүтээн цогцолборт иргэдийн хандив тусламжаар 2021 оноос хойш нийт 82.0 сая төгрөгийн өртөг бүхий 2 ш суваргыг сүсэгтэн олон, иргэдийн хандив, тусламжаар барьж ашиглалтад оруулсан.</p> <p>Мөн “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-н зураг, төсвийн дагуу Их шүтээн цогцолборт 2023 онд авто замын зогсоол, 108 шатыг шинэчлэх, гэрэлтүүлэг бүхий ажлыг нийт 524.0 сая төгрөгөөр Эрдэнэт үйлдвэрийн хамтын ажиллагааны хүрээнд хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан.</p> <p>“Хөх Монгол цогцолбор” байгууламжийг амралт чөлөөт цагийн талбай болгох гадна тохижилтыг засварлах ажлын зургийг боловсруулж байна. Цаашид тус зураг төсөлд нэмэлтээр хийгдэх ажлуудын саналыг иргэдээс авч танилцуулах ажлыг зохион байгуулахаар боллоо. Мөн Ерөнхий боловсролын сургуулиуд 2024-2025 оны хичээлийн жилд гурван улиралтай хичээллэх хуваарь гарч 2024 оны 10 дугаар сарын 28-наас 11 дүгээр сарын 3-ний өдөр хүртэл “Бие даалтын 7 хоног” болгосонтой холбогдуулан СӨБ болон ЕБС-ын сурагчдад Хөх монгол цогцолборын 2 давхарт байрлах түүхэн зургийг үзүүлэн хамтран ажиллаж байна. Ёс заншлын өргөө дээр хуримын арга хэмжээ, ахмадын баяр, хүүдийн үсний найр, монгол наадам, Үндэсний хоол сурталчилгаа гэх мэт арга хэмжээ зохион байгуулагдаж аялал жуулчлалын салбараас олох орлого нэмэгдсэн байна.</p>	100%
191		Зочид буудал, жуулчны баазуудын үйлчилгээний чанар, стандартыг мөрдүүлэх	2021-2024	БОАЖГ	Сумдын ЗДТГ	Хувийн хэвшил	-	Зэрэглэлтэй Зочид буудал-3 жуулчны баазын тоо-1	Шаардлага хангасан байгууллагын тоо 2	-	-	Аймгийн хэмжээнд 532 ор бүхий 25 зочид буудал, 10 дэн буудал үйл ажиллагаа явуулж байгаагаас 3 одны зэрэглэлтэй 2 зочид буудал, 1 одны зэрэглэлтэй 1 зочид буудал, 2 цэцгийн зэрэглэлтэй 1 амралтын бааз үйл ажиллагаа явуулж байна. Зэрэглэл авахаар бэлтгэж буй зочид буудлуудын үйл ажиллагааг орон нутгийн	75%

											<p>ажлын хэсэг шалгаж стандартын хэрэгжилтийг үнэлж бүрэн хангасан байх зөвлөмжийг өгсөн. "Зочлох үйлчилгээний салбарын ажилтнуудыг чадавхжуулах" сургалтыг МУИС-ийн "Аялал жуулчлалын хөтөлбөр"-ийн багш нартай хамтран салбарын ажил үйлчилгээний чанарыг сайжруулах, стандартыг мөрдүүлэх, байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, зочлох үйлчилгээний салбарын ажилчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, үйлчилгээний соёл, найрсаг харилцаа хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн сургалтыг зохион байгуулж нийт 73 хүнийг мэргэшүүлэх сургалтад хамрууллаа. "Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага" MNS 5927:2008 стандартын хэрэгжилтийг ханган ажиллаж буй томоохон зочид буудлуудад орон нутагт зохион байгуулагдсан арга хэмжээний оролцогчид, зочдыг тогтмол байрлуулж хамтран ажиллалаа. Аймгийн зочид буудлын хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор "Hogesso Mongolia", "Монголын зочид буудлуудын холбоо"-той хамтран 25 зочид буудлын жилийн гэрээтэйгээр ажиллах 84 ажилтанд өрөө үйлчилгээ, угаалга, зочин угтагч, зоогийн газрын үйлчлэгч нарыг чадавхжуулах сургалтад хамрууллаа. 2023 онд Шинээр Соррег зочид буудал ашиглалтад орж зэрэглэлийн стандартыг хангаж байгаа тул зэрэглэл авах хүсэлтээ өгөхөөр бэлтгээд байна. Мөн 2024 онд шинээр "ZES-AGULA" ресорт үйл ажиллагаагаа явуулж эхлэн амрагч аялагчдаа авч ажиллаж байна.</p>	
192	6.3.Орхон аймаг, Эрдэнэт хотын соёлын онцлог тохирсон шинэлэг, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжин, аялал жуулчлалаас орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.	Брэнд бүтээгдэхүүнийг шалгаруулан, гадаад, дотоодод сурталчлах, худалдан борлуулах боломжийг нэмэгдүүлэх	2021-2024	БОАЖ Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	15.0	5 брэнд бүтээгдэхүүн	5.0	<p>2021-2023 онд Орон нутгийн төсөв 10.0</p> <p>2024 онд Оорон нутгийн төсөв 10.0</p>	<p>Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, сурталчлан таниулах үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах ажлын хэсэг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдан ажиллаж байна. Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих төслөөс аймгийн хүнсний үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд брендийн сургалт явуулж, шалгарсан Эрдэнэт өндөг ХХК, Идэр баялаг ХХК, Эрдэнэт хот орчмын сүүний үхрийн фермерүүдийн холбоо, Ариус дэсерт катеринг ХХК зэрэг 4 аж ахуйн нэгжид тус бүр 10.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж авах эрх олгож дээрх 4 байгууллагууд тоног төхөөрөмжөөр</p>	100%

											хангагдлаа. Аймгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн дунд зарласан уралдаанд өндөрлөг брэнд, батаар вүүд, сампин брэнд, аранжин брэнд, сүргийн шим зэрэг бүтээгдэхүүнүүд шалгарч “Эрдэнэтэд үйлдвэрлэв” худалдааны цэгээр дамжуулан бүх нийтэд хүргэж байна. Бүх ард түмний өвлийн спортын наадмын хүрээнд аймгийн бэлгэдэл болсон арслан, гүег бүхий чихмэлийг орон нутгийн жижиг дунд бизнес эрхлэгчид худалдаанд гаргаж, улмаар зохион байгуулагдаж буй бүх тэмцээн уралдаанд уг тоглоомыг брэнд болгон гардуулж байна. Мөн "ITM Mongolia-2023" арга хэмжээнд орон нутгийн брэнд Арьсан эдлэл-өндөрлөг брэнд, гар урлал-сампин брэнд бүтээгдэхүүнийг оролцуулан худалдан борлуулах боломжоор хангасан. Эрдмин ХХК-ний 2023 оны шинэ загвар олон үйлдэлт залгуурт аймгийн брэнд бүтээгдэхүүний логог олголоо. "ITM Mongolia-2024" арга хэмжээний үеэр 10 дугаар сарын 25-аас 27-ны өдөр үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, уг арга хэмжээнд 8 аж ахуй нэгж оролцон, 6000 орчим хүнд үйл ажиллагаагаа сурталчлан 11 төрлийн 3000 орчим гарын авлага тарааж, 51 нэр төрлийн бүтээгдэхүүн борлуулж 20.0 сая төгрөгийн орлого төвлөрсөн.		
193		Аймгийн аялал жуулчлалын нэгдсэн маршрутыг шинэчлэн гаргаж мөрдүүлэх, ААНБ, ТББ-уудын үйл ажиллагааг дэмжих	2021-2024	ХБТХ ОХ	БОАЖ Г Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	52.0	14 чиглэлийн маршрут	Гадаад дотоодын аялагчдын тоо нэмэгдсэн байна.	20.0	-	Орон нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтын хүрээнд "Аялал жуулчлалын дунд хугацааны хөтөлбөр"-ийг аймгийн ИТХ-ын 2022 оны 07/03 тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд хил орчмын аялал жуулчлалын К-3 визний зөвшөөрөл бүхий жуулчдад зориулсан 72 цагийн аяллын маршрутыг болон аймаг доторх хотын аяллын 4 маршрутыг бүх нийтэд сурталчлан ажиллаж байна. Мөн аймгийн хэмжээнд аялал жуулчлалын зочлох үйлчилгээ үзүүлдэг 26 зочид буудал, 10 дэн буудал, 23 ресторан, зоогийн газар, 3 амралтын газрын дэлгэрэнгүй судалгааг гаргаж, мэдээллийн сан бүрдүүллээ. Мөн Баян-Өндөр хайрхан /1.4га/ болон Эрдэнэт хаалга /3.4га/ орчимд аялал жуулчлалын бүс болгох, шинэ маршрут бий болгох ажлын хүрээнд ерөнхий төлөвлөлтийн зургийг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүллээ. Бүх ард түмний өвлийн спортын наадам,	90%

											<p>Бүргэдийн баяр, Хамтдаа Эрдэнэтэд хөгжье, Эдийн засгийн форум, Зэс фестиваль зэрэг арга хэмжээнүүдэд ирсэн зочид төлөөлөгчдийг нэгдсэн зохион байгуулалттай зочид буудалд байрлуулах, хооллох, худалдаа үйлчилгээний төвүүдээр үйлчлүүлэх боломжийг бүрдүүлж, Эрдэнэт хотыг танилцуулах "City tour" аяллыг 5 төрлийн маршрутаар зохион байгуулж ажилласан.</p> <p>Зэс фестиваль эвент арга хэмжээг аймгийн томоохон 5 үйлдвэр, 16 ААНБ-тай хамтран жил бүр зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Сэлэнгэ амралт аялал жуулчлалын цогцолбор нь 3 маршрутаар өвлийн вагоны 1 өдрийн аяллыг зохион байгуулан ажилласнаар нийт 529 аялагчийг хүлээж аваад байна</p> <p>Орхон аймагт 2024 онд 23734 орчим жуулчин ирсэн ба үүнээс 990 нь гадаадын жуулчин байна.</p>	
194	6.4.Аялал жуулчлалын салбарт технологийн дэвшил нэвтрүүлж, дотоод, гадаад сурталчилгааг өргөжүүлнэ.	Аялал жуулчлалын нэгдсэн мэдээллийн төв цэгийг хэлбэрээр байгуулах	2021-2024	Аймгийн ЗДТГ	БОАЖ Г Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв БХАХЗ	18.0	-	5.0	2021-2023 он Орон нутгийн төсөв 18.0	<p>Аймгийн зочид буудал, амралт сувиллын газар, ресторан зоогийн газар, үзвэр үйлчилгээ, тээврийн хэрэгслийн мэдээлэл, маршрут, түүх дурсгал зэрэг мэдээллийг багтаасан аялал жуулчлалын welcome.erdenet.mn веб сайтыг бэлэн болгон мэдээ, мэдээллийг цахимаар авах боломжийг бүрдүүлээд байна. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын болон байгууллагын пэйж хуудсаар дамжуулан Welcome to erdenet видео контент болон аялал жуулчлалын цаг үеийн мэдээ, мэдээлэл, зохион байгуулсан ажлыг нийт 8000 орчим хүнд хүргэн ажиллалаа. Монголд зочлох жилийн хүрээнд БОУАӨЯам, АЖХТөвтэй хамтран QR хэлбэртэй мэдээллийг зам дагуух 3 самбарт байршуулан бүх нийтэд мэдээллийг тогтмол хүргэж байна. Монголын Аялал жуулчлалын холбооноос зохион байгуулагддаг ITM аялал жуулчлалын үзэсгэлэнд жил бүр оролцон аймгийн танилцуулга мэдээлэл, видео бичлэгийг цахимаар хүргэх ажлыг киоск, VR төхөөрөмжийн тусламжтайгаар бүх нийтэд хүргэлээ.</p> <p>Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын пэйж хуудсаар өдөр тутмын үйл ажиллагааг иргэдэд хүргэн ажиллаж байна.</p>	100%

195		Өвлийн аялал жуулчлалын материаллаг баазыг нэмэгдүүлж, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх	2021-2024	Аймгийн ЗДТГ	БОАЖГ Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	30.0	-	Гадаад дотоодын аялагчдын тоо нэмэгдсэн байна.	10.0	2021-2023 онд Орон нутгийн төсөв 13.4	Монголын бүх ард түмний спортын өвлийн спортын XVI дугаар наадам, Монголын хүүхдийн спортын өвлийн VII дугаар наадам "Нөхөрлөл-Тэмүүлэл-Амжилт" уриан дор зохион байгуулагдсан ба 12 аймаг, нийслэлийн 7 дүүргийн 722 тамирчдыг оролцуулсан тэмцээнд оролцогчдыг нэгдсэн зохион байгуулалттай зочид буудлуудад байрлуулж, нэгдсэн хоол, унаагаар үйлчлэх, Эрдэнэт хотыг танилцуулах "City tour" аялал, 3 цэгт худалдаа үйлчилгээ, Эрдэнэтийн гар урлал бэлэг дурсгалын бүтээгдэхүүн худалдаалах цэгүүдийг тус тус ажиллуулж бүх нийтэд хүргэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн худалдаа үйлчилгээний байгууллагуудыг уртасгасан цагаар ажиллуулах шийдвэрийг гаргуулан аймгийн ахуйн үйлчилгээний газрууд, зочид буудал, ресторан зоогийн газрууд, хүргэлтийн үйлчилгээний мэдээллээр ханган тамирчид байрласан нийт 20 орчим цэгт хүргэлтийн үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгуулж, худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэн аж ахуйн нэгжид 1 тэрбум орчим төгрөгийн хөрөнгө оруулалт, худалдан авалт хийгдсэн. Казак түмний үндэсний баяр болох Наурызын баярыг тохиолдуулан тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор 03 дугаар сард "Бүргэдийн баяр-2023" эвент арга хэмжээг зохион байгуулж, 12 бүргэдчин Баян-Өлгий аймгаас хүрэлцэн ирж Орхон аймагт анх удаа хамтарсан арга хэмжээг зохион байгуулснаар 8000 орчим хүн оролцож, орон нутгийн бизнес эрхлэгчид орлого олох боломжийг бүрдүүлэн ажилласан. Монгол Улсад орчин цагийн Биеийн тамир, спортын салбар үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойн хүрээнд аймгийн Биеийн тамир, спортын газартай хамтран "Эрдэнэт мөнгөн өвөл-2024" спортын наадмыг зохион байгуулж Улаанбаатар хот болон 8 аймгийн 11 багийн 100 гаруй тамирчид оролцож, гүйлтийн цанын төрлөөр хүүхэд, насанд хүргэгчдийн ангиллаар хурд хүчээ сорин өрсөлдсөн. Эрдэнэ заяа бандида Гончигсүмлэн хийдтэй хамтран "Луу жилийн мөсөн шагайн хишиг харваа" тэмцээн, аймгийн Биеийн тамир спортын газартай хамтран "Эрдэнэт мөнгөн өвөл" спортын наадам, төрийн байгууллагын албан хаагчдын дунд "Цасны баяр" зэрэг 3 арга хэмжээг зохион	100%
-----	--	--	-----------	--------------	-------------------	--------------------	------	---	--	------	---------------------------------------	--	------

												байгуулж нийт 550 хүн оролцсон. Орхон аймагт 2024 онд 23734 орчим жуулчин ирсэн ба үүнээс 990 нь гадаадын жуулчин байна. Гадаад жуулчдын тоо 2022 онд 307, 2023 онд 526, 2024 онд 990 болж өссөн байна.	
<b>ДОЛОО.ҮЙЛДВЭРЛЭЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ</b>													
<b>7.1.Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.</b>													
196	7.1.1.Металлургийн үйлдвэрлэлийн үндсэн хэсэг болох ширмийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	Хувийн хэвшлийн оролцоотой ширмийн үйлдвэр байгуулах	2021-2022	Хувийн хэвшил	ХБТХ ОХ	Хөгжлийн банк	Төслийн санхүүжилтээр	Үйлдвэр байгуулах	Үйлдвэр байгуулсан байна.	Төслийн санхүүжилтээр	-	Үндсэн болон туслах түүхий эд (төмрийн хүдэр, кокс, шохойн чулуу, галд тэсвэртэй материал) нийлүүлэгч компаниудын судалгаа хийгдсэн. Түүхий эдийн шинж чанарын судалгааг хийж гүйцэтгэж байна. Зуухны галд тэсвэртэй доторлогоог шинэчлэн доторлож, агаар халаах зуухны форсунк, хий дамжуулах шугамд засвар хийсэн. Домен зуухны тоосны байгууламжийн уутан филтерүүдийг шинээр сольж, засвар гагнуур хийж, зуухны хаалтуудад тосолгоо үйлчилгээ хийсэн. Зуухны фурмын нөөц бэлдэх ажил хийж шинээр 20 ширхэг фурм хийж нөөцөд бэлдсэн. Түүхий эд ачаалах автомат систем зураг төсөл хийж, угсрах бэлтгэл ажил хийгдэн 2-р ээлжийн 70 м.куб Домен зуухны бүтээн байгуулалт, 70 м.куб-ийн Домен зуухны агаар халаах зуух, материал ачаалах системийн угсралт, гагнуурын ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Хөгжлийн банкны зээлтэй холбоотойгоор 2022 оны 6 дугаар сараас хойш үйл ажиллагаа явуулаагүй байна.	30%
197	7.1.2."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн үйлдвэрлэл, технологийн парк байгуулна.	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэсэн үйлдвэрлэл, технологийн паркийг дэмжин ажиллах	2021-2024	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	ХБТХ ОХ	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	Төслийн санхүүжилтээр	Төслийн хэрэгжилт 50%-д хүрнэ	Төсөл хэрэгжилт 50%	-	2024 онд 15701.0 сая "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	ҮТП-ийн дэд бүтцийн ажлын явц: Авто зам барьж байгуулах ажлын багц-2 буюу автозамын гэрэлтүүлэг барьж байгуулах тендэрт "Оркон тех" ХХК, багц-1 буюу автозам барьж байгуулах ажлын тендэрт "Шилдэг зам" ХХК шалгарч, гэрээ байгуулсан ба гэрээний хугацаа 2024 оны 11 дүгээр сард дуусч байна. - Автозамын захиалагчийн хяналтын зөвлөх үйлчилгээг "Мөнхөд ашдын зам" ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байгаа ба ажлын явц 46.5% -ийн гүйцэтгэлтэй байна. - Төмөр зам барьж байгуулах ажлыг "Туулын гүүр далай" ХХК-тай гэрээ байгуулсан. Төмөр замын зохиогчийн хяналтыг "Максимал" ХХК-тай, Төмөр замын захиалагчийн хяналтын зөвлөх үйлчилгээг "Рэйлвэй консалтинг Сервис" ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Ажлын явц 91%-тай байна.	70%



												<p>- Ус хангамж, ариутгах татуургын систем барьж байгуулах ажлыг "Б-софт" ХХК-тай гэрээ байгуулан ажилласнаар ажлын явц 76%-ийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>- Цахилгаан хангамжийн ТЭЗҮ боловсруулснаар 64.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 220/110/35 кВ-ын Оюут дэд станц, 110/35/10 кВ-ын "ҮТП" дэд станц, 220 кВ, 110 кВ-ын ЦДАШ-ын ажлууд төлөвлөгдсөн. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Зураг төслийн хүрээлэн 220 кВ-ын Оюут дэд станц, 220 кВ-ын ЦДАШ-ын зураг төслийг боловсруулж, Эрчим хүчний сургалт үйлдвэрлэлийн төв ТӨХХК-ийн магадлалаар оруулж, 2024 оны 08 дугаар сард ерөнхий дүгнэлт гарч, баталгаажуулсан. "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨААТҮГ нь 110 кВ-ын дэд станц, 110 кВ-ын ЦДАШ-уудын зураг төсөл "ЭХҮТ" ТӨХХК-ийн магадлалаар оруулж, 2024 оны 04 дүгээр сард ерөнхий дүгнэлт гарч, баталгаажуулж дуусган барьж байгуулах ажлын тендер зарлагдсан.</p> <p>- ҮТП-ын газрыг тойруулан хашаа барих ажлыг "Орчлонтулга" ХХК-тай гэрээ байгуулан ажилласнаар ажил 92%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.</p>	
7.2. Эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.													
198	7.2.1. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрт хамрагдаж хөнгөлөлттэй зээл, батлан даалтын үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлнэ.	Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлд хамруулах	2021-2024	ХБТХ ОХ ХХАА Г	Сумы н ЗДТГ	Улсын төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	1.3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.	Хөнгөлөлттэй зээл олгоно.	Батлагдсан төсвийн хүрээнд	<p>2021-2023 онд: ХХААҮДС 18500.0</p> <p>ЖДҮХС 988.3 Хоршоо хөгжүүлэх сан 1300.0 Төсөл хөтөлбөр 5390.0 ХБИХЭДС 280.0 ШҮТП-аас 100.0</p> <p>2024 онд:</p>	<p>Аймгийн хэмжээнд 2021-2023 онд хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор олгогдсон 5-6 хувийн хүүтэй, хөнгөлөлттэй зээлд 31 аж ахуйн нэгж, 72 иргэн хамрагдаж 18.5 тэрбум, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 6 аж ахуйн нэгжид 988.3 сая, Хоршоо хөгжүүлэх сангаас нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр 79 иргэн, аж ахуйн нэгжид нийт 1.3 тэрбум, Япон улсын Жайка төслөөс нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр 4 төсөлд 3.2 тэрбум төгрөг, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн агентлагийн санхүүжилттэй "Бест" хөтөлбөрийн дэмжлэгээр 37 иргэн, аж ахуйн нэгж 1.9 тэрбум, нийт 229 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид 25.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд 28 иргэн тэнцэж 280.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн агентлагийн санхүүжилттэй "Бест" хөтөлбөрөөс 4 аж ахуйн</p>	100%

										<p>ЖДҮС 1271.5</p> <p>Хоршоо хөгжүүлэх сан 5187.0</p> <p>ХААҮДС 1100.0</p> <p>Шинэ хоршоо хөдөлгөөн 2500.0</p> <p>Аймгийн ЖДҮДС 265.8</p>	<p>нэгжид 40.0 сая төгрөгийн буцалтгүй дэмжлэг, "Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих" (PROGRES) төслөөс 28 жижиг, дунд үйлдвэрлэл болон гарааны бизнес эрхлэгч нарт үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөө шинэчлэн сайжруулахад нийт 250.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг тус тус үзүүлсэн. Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨҮГ-аас "Гарааны бизнес-2022" төсөл зохион байгуулж 3 аж ахуйн нэгжид 100.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт олгосон. 2024 онд ипотекийн зээл авсан 68 иргэн 1.4 тэрбум төгрөгийн зээлийн батлан даалтын үйлчилгээнд хамрагдсан бол 23 бизнес эрхлэгчдэд 507.0 сая төгрөгийн батлан даалттай 2.6 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.</p> <p>"Шинэ хөдөө" төслийн хүрээнд Жаргалант суманд 1.5 тэрбум, Баян-Өндөр суманд 2.2 тэрбум төгрөг батлагдаж 13 нэр төрлийн 26 тоног төхөөрөмж, 100 ширхэг хүлэмжийг 126 өрхийн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд гэрээгээр эзэмшүүлсэн.</p> <p>Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 8 аж ахуйн нэгж 1271.5 сая төгрөг, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд олгож буй хөнгөлөлттэй зээлээс 3 аж ахуйн нэгж 1100.0 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангаас 3 хоршоонд 250.0 сая төгрөг, Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 30 хоршоонд 4937.2 сая төгрөг, нийт 44 аж ахуйн нэгжид 7558.7 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, 55 ажлын байр шинээр нэмэгдсэн байна.</p> <p>Аймгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлээс 7 аж ахуйн нэгж 265.8 сая төгрөгийн зээлийг олгосон.</p>	
199	Бизнес эрхлэгчдийг гадаад, дотоодын төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээл, батлан даалтын үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлэх	2021-2024	ХХАА Г ХБТХ ОХ	Сумдын ЗДТГ	Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	24.0	415.5 сая төгрөгийн зээл, 513.0 сая төгрөгийн батлан даалт гаргасан.	Шаардлага хангасан төслийн тоогоор	4.0	<p>2021-2023 онд Төсөл хөтөлбөр 5390.0</p> <p>ЖДҮХС, ХААҮДС, Бусад эх үүсвэр 20900.0</p>	<p>2021-2023 онд Япон улсын Жайка төслөөс нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр 4 төсөлд 3.2 тэрбум төгрөг, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн агентлагийн санхүүжилттэй "Бест" хөтөлбөрийн дэмжлэгээр 37 иргэн, аж ахуйн нэгж 1.9 тэрбум төгрөг болон жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, бусад эх үүсвэрээс нийт 229 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид 25.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг</p>	100%

										<p>2024 онд ЖДҮХС 1271.5</p> <p>ХААҮДХ 900.0</p> <p>ХХС 7358.7</p> <p>Батлан даалтын сан 2709.4</p>	<p>дэмжих арга хэмжээнд 28 иргэн тэнцэж 280.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгт, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн агентлагийн санхүүжилттэй "Бест" хөтөлбөрөөс 4 аж ахуйн нэгжид 40.0 сая төгрөгийн буцалтгүй дэмжлэг, "Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих" (PROGRES) төслөөс 28 жижиг, дунд үйлдвэрлэгч, гарааны бизнес эрхлэгч нарыг үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөө шинэчлэн сайжруулахад нийт 250.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг тус тус үзүүлсэн. Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨҮГ-аас "Гарааны бизнес-2022" төсөл зохион байгуулж 3 аж ахуйн нэгжид 100.0 сая төгрөг, "Гарааны бизнес-2023" төслийн хүрээнд 270.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт олгосон. 2024 онд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 8 аж ахуйн нэгж 1,271.5 сая төгрөг, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд олгож буй хөнгөлөлттэй зээлээс 2 аж ахуйн нэгж 900.0 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангаас 3 хоршоо 250.0 сая төгрөг, Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 30 хоршоо 4,937.2 сая төгрөг, нийт 43 аж ахуйн нэгжид 7358.7 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдсон. 30 хоршооны 107 гишүүн 2709.4 сая төгрөгийн зээлийн батлан даалтын үйлчилгээнд хамрагдсан.</p>		
200	7.2.2.Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлнэ.	Ахуйн үйлчилгээ хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2021-2024	ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	100.0	Суурь судалгаа хийгдсэн.	Хөтөлбөрийн хэрэгжилтийг 100%-д хүргэнэ.	30.0	<p>2021-2023 онд Орон нутгийн төсөв 10.0</p> <p>2024онд Орон нутгийн төсөв 10.0</p>	<p>Аймгийн хэмжээнд ахуйн үйлчилгээний салбарт 346 цэгт аж ахуйн нэгж, иргэн үйл ажиллагаа явуулж байгаагийн 4.0 хувь нь нийтийн халуун ус, 23.1 хувь нь үсчин, гоо сайхан 24.6 хувь нь хувцас захиалга, засвар, 1.4 хувь нь гэрэл зураг авах, угаах, 0.9 хувь нь хими цэвэрлэгээ, угаалга, 0.9 хувь нь ахуйн электрон, цахилгаан хэрэгсэл засвар, 6.9 хувь нь гутал захиалга, засвар, 5.5 хувь нь гэр ахуйн модон эдлэл захиалга, засвар, 2.3 хувь нь алт, мөнгө, үнэт эдлэлийн захиалга, засвар, 30.6 хувь нь бусад үйлчилгээний чиглэлээр тус тус үйл ажиллагаа явуулж байна. "Ахуйн үйлчилгээг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 11 арга хэмжээ тусган 72 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн. 2024 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэх 4 зорилт 9 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөн</p>	100%

											<p>ажилласнаар төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувийн гүйцэтгэлтэй байна. Тайлант онд дараах онцлох ажлуудыг зохион байгууллаа.</p> <p>Тухайлбал:</p> <p>Мэргэжлийн холбоодтой хамтран ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 5 удаагийн сургалтыг зохион байгуулан, давхардсан тоогоор 254 хүн хамруулж, үсний шинэ загварын тайралт, будалтын технологийг эзэмшиж, орчин үеийн чиг хандлага өвөрмөц урсгалуудыг орон нутгийн үсчин, гоо сайхны үйлчилгээнд нэвтрүүлэх ур чадвар эзэмшсэн.</p> <p>Монголын Үсчин гоо, засалчдын үндэсний холбоотой хамтран “Төв болон хангайн бүс-2024” үсчин, гоо сайхан, хумс засалч дизайн урлалын мэргэжлийн аварга шалгаруулах бүсийн тэмцээнийг Орхон аймагт зохион байгуулж, 6 аймгийн 100 гаруй төлөөлөл оролцсоноос Орхон аймгийн Үсчин, гоо засалчдын холбоо нь тус тэмцээнд 13 төрөлд 19 медаль хүртэж “Шилдэг аймаг”-аар шалгарсан.</p> <p>Амарын талбайд үзэсгэлэн худалдаа, загварын үзүүлбэрийг зохион байгуулж, үндэсний хувцас үйлдвэрлэгчид, эсгий гар урлалын бүтээгдэхүүн, эрүүл мэндийн цай үйлдвэрлэл, шүрэн эдлэл, арьсан эдлэл, төмөр хийц, уран дархан мужаан, эко саван үйлдвэрлэл зэрэг чиглэлээр 40 гаруй иргэн, аж ахуй нэгжийг хамруулж нийт 37.7 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.</p> <p>Жаргалант сумын иргэдэд ахуйн үйлчилгээний салбарын үйлчилгээг зах зээлийн үнээс хямд, нэг цэгээс хүрч үйлчлэх, иргэдийн зардлыг хэмнэх, үйлчилгээ эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор “Явуулын ахуйн үйлчилгээг” сумын Соёлын төвд зохион байгуулж 14 төрлийн үйлчилгээг 185 иргэнд үзүүлсэн.</p> <p>Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй халуун ус, сауны үйлчилгээнд Стандартын үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийж, дүгнэн мэргэжлийн зөвлөмж туслалцаа үзүүлж, стандартын шаардлага хангасан сауны үйлчилгээ эрхэлдэг 5 иргэн, аж ахуйн нэгжийн нийт 8 үйлчилгээний газарт 2 жилийн хугацаатай тохирлын гэрчилгээг олгосон.</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

201		Ахуйн үйлчилгээний чанар, стандартын хэрэгжилтийн түвшин дээшлүүлэхэд сургалт, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулж, тохирлын үнэлгээнд хамруулах	2022-2024	СХЗХ	ХХАА Г Аймгийн ЗДТГ	Орон нутгийн төсөв	6.0	Шаардлага хангасан үйлчилгээний хувь 20%	Жил бүр 10%	2.0	-	2022 онд аймгийн хэмжээнд үсчин, гоо сайхан, хумс заслын үйлчилгээ эрхлэгчид, ажлын байр түрээслэгчдэд "Үс засах үйлчилгээ" MNS 5160:2020, "Гоёлын гоо заслын үйлчилгээ" MNS 5567:2006, "Хумс заслын үйлчилгээ" MNS 6843:2020 стандартын сургалтыг зохион байгуулж 182 хүн, Монголын үсчин, гоо засалчдын холбооны тэргүүлэгч мастер багшийн 5 хоногийн шаталсан сургалтад давхардсан тоогоор 180 үсчин, гоо сайханч хамруулж, давхардсан тоогоор 300 гаруй хүний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлсэн. Ахуйн үйлчилгээний чиглэлээр 8 багийн 71 цэг салбар бүртгэгдсэнээс халуун ус, саун, үсчин, гоо сайхны 68 цэг тогтвортой ажиллаж байна. 11 үйлчилгээнд "Баталгаажуулалтын мэдэгдэл" өгч ажилласнаар стандартын шаардлага хангасан "Сэрвэн цахир", "Үзэмж гоо", "Жавхлан", "Сувд гоо", "Болор" зэрэг 5 үсчний газарт тохирлын гэрчилгээ олгосон. 2024 оны байдлаар ахуйн үйлчилгээний чиглэлээр халуун ус, саун, үсчин, гоо сайхны 68 цэг тогтвортой ажиллаж байна. Ахуйн үйлчилгээний чанар, стандартын хэрэгжилтийн түвшин дээшлүүлэхэд Засгийн газрын 2018 оны 291-р тогтоолоор батлагдсан заавал тохирлын баталгаажуулалтад хамрагдах үйлчилгээний талаар нийт 8 удаагийн мэдээлэл сурталчилгааг зохион байгуулж халуун ус, саун, үсчин, гоо сайхны үйлчилгээ эрхлэгчдийг хамруулснаар энэ онд 2 аж ахуйн нэгж, 3 иргэний 3 нэр төрлийн 8 үйлчилгээ, сауны 3, үсчин, гоо сайхны 4, чийрэгжүүлэх 1 үйлчилгээг баталгаажуулан гэрчилгээ олгосон нь тохирлын гэрчилгээтэй үйлчилгээ 2024 онд 11.7 хувиар нэмэгдэж нийт тохирлын баталгаатай үйлчилгээ 38 хувьд хүрээд байна.	70%
202	7.2.3.Орон нутгийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг дэмжинэ.	"Эрдэнэт үйлдвэрлэл" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2021-2024	ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	191.0	Хөтөлбөрийн хэрэгжилт 70%	Хөтөлбөрийн хэрэгжилт 100%	50.0	-	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны Ээлжит X хуралдаанаар "Эрдэнэт үйлдвэрлэл" дэд хөтөлбөр батлагдсан. Тус хөтөлбөр нь 2018-2021 онд 94.4 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн. "Эрдэнэт үйлдвэрлэл" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр "Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хөтөлбөр"-ийг аймгийн ИТХ-ын 2023 оны 14/02 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж	90%

												байна. Тус хөтөлбөрийн хүрээнд байгуулах "Эрдэнэтэд үйлдвэрлэв төв"-ийн худалдаа үйлчилгээний барилгын зураг төсөв хийх тендерт "Эрдэнийн хүчит суурь" ХХК шалгарч, барилгын зураг төсвийг боловсруулан хүлээлгэн өгсөн. Мөн барилга барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт "Сэнгүн констракшн" ХХК шалгаран ажил эхлээд байна.	
203		"Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх	2021-2024	ХБТХ ОХ ХХАА Г Сумдын ЗДТГ	"ШУТ П" ХХҮГ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	Батлагдсан төсвийн хүрээнд	Хөтөлбөрийн төслийг боловсруулсан.	Хөтөлбөрийн хэрэгжилт 90%	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 20.0	<p>Аймгийн ИТХ-ын 2023 оны 14/02 дугаар тогтоолоор "Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хөтөлбөр" батлуулан 3 зорилтын хүрээнд 10 арга хэмжээ төлөвлөн ажилласнаар 2023 оны жилийн эцсийн байдлаар 83.5 хувийн хэрэгжилттэй байсан. Өрхийн үйлдвэр эрхлэгчдийг чадавхжуулах сургалт зохион байгуулж 52 өрхийн үйлдвэрлэл эрхлэгчийг хамруулснаар өрхийн бизнес загвараа хэрхэн гаргах талаар мэдлэг, мэдээлэлтэй болж зөвлөх үйлчилгээнд хамрагдсан.</p> <p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хүлэмж, оёдол, гутал, мах болон сүү боловсруулах чиглэлээр өрхийн болон бичил үйлдвэрлэл эрхлэгч нийт 880 иргэнд шаардлагатай тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. "Бялхам Ивээл" ХХК-тай хамтран дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, хүлэмжийн аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэдээллээр хангах замаар хүний нөөцийн чадавхыг сайжруулах зорилгоор "Хөдөө аж ахуй технологи" сэдэвт сургалтыг зохион байгуулж, хүлэмжийн аж ахуй эрхлэгч 45 иргэнийг хамруулснаар хөрсний менежментийн болон суулгац, эрт тариалах, усалгааны, халдварт өвчнөөс сэргийлэх, улаан лооль, өргөст хэмх тариалах технологийн мэдлэгтэй болсон. Мөн Сэлэнгэ аймгийн Баруунхараа суманд хүлэмжийн аж ахуйн туршлага судлах аялалд өрхийн тариаланчдыг хамруулсан.</p> <p>"Эрдэнэтэд үйлдвэрлэв-2023" үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, 45 өрхийн үйлдвэрлэл эрхлэгч оролцлоо.</p> <p>2024 онд өрхийн болон бичил үйлдвэр, үйлчилгээг дэмжих Шинэ хөдөө-Орхон төслийн хүрээнд 17 нэр төрлийн 29 тоног төхөөрөмж,</p>	94.0%

											<p>100 ширхэг хүлэмжийг өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд гэрээгээр эзэмшүүлсэн. Аймгийн өрхийн болон бичил, жижиг, дунд үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих тусгай сангаас 7 өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид 265.8 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдсон. Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, өдөрлөг, арга хэмжээг А.Амарын талбайд зохион байгуулж, үндэсний хувцас, эсгий гар урлалын бүтээгдэхүүн, эрүүл мэндийн цай үйлдвэрлэл, шүрэн эдлэл, арьсан эдлэл, төмөр хийц, уран дархан мужаан, эко саван үйлдвэрлэл, уран зураг, бичлэг зэрэг өрхийн болон жижиг дунд бизнес эрхэлдэг 44 иргэн, аж ахуй нэгж оролцож, 37.7 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн.</p> <p>Улаанбаатар хотод зохион байгуулагдсан "Алтан намар-2024" нэгдсэн үзэсгэлэн худалдаанд 6 өрхийн тариаланч оролцож 108.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн.</p> <p>Тус хөтөлбөрийн хүрээнд байгуулах "Эрдэнэтэд үйлдвэрлэв төв"-ийн худалдаа үйлчилгээний барилгын зураг төсөв боловсруулагдан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Барилга угсралтын ажил эхлэх шатанд явж байна.</p> <p>2024 оны жилийн эцсийн байдлаар Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хөтөлбөр"-ийн хэрэгжилт 94.0 хувьтай байна.</p>		
204	7.2.4.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрийг зээлийн бодлогоор дэмжин ажиллах	2021-2024	ХБТХ ОХ ХХАА Г Сумдын ЗДТГ	ХХҮГ	Улсын төсөв болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	2.000.0	7 төсөл 330.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан.	500.0 сая төгрөгийн зээлд хамруулна.	-	<p>2021-2023 онд ХААҮДС 18500.0</p> <p>ЖДҮС 988.3</p> <p>ХХСан 1300.0</p> <p>Төсөл хөтөлбөр 5100.0</p> <p>2024 онд</p>	<p>Аймгийн хэмжээнд 2021-2023 онд хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор олгогдсон 5-6 хувийн хүүтэй, хөнгөлөлттэй зээлд 31 аж ахуйн нэгж, 72 иргэн хамрагдаж 18.5 тэрбум, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 6 аж ахуйн нэгжид 988.3 сая, Хоршоо хөгжүүлэх сангаас нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр 79 иргэн, аж ахуйн нэгжид нийт 1.3 тэрбум, Япон улсын Жайка төслөөс нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр 4 төсөлд 3.2 тэрбум төгрөг, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн агентлагийн санхүүжилттэй "Бест" хөтөлбөрийн дэмжлэгээр 37 иргэн, аж ахуйн нэгж 1.9 тэрбум, нийт 229 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид 25.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна.</p> <p>2024 онд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 8 аж ахуйн нэгж 1,271.5 сая төгрөг,</p>	100%

										<p>ЖДҮС-1272.0</p> <p>Хоршоо хөгжүүлэх сан 250.0</p> <p>ХААҮДС 900.0</p> <p>Шинэ хорошоо хөдөлгөөн 4937.2</p>	<p>Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд олгож буй хөнгөлөлттэй зээлээс 2 аж ахуйн нэгж 900.0 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангаас 3 хоршоо 250.0 сая төгрөг, Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 30 хоршоо 4937.2 сая төгрөг, нийт 43 аж ахуйн нэгжид 7358.7 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдож, 55 шинэ ажлын байр нэмэгдсэн. Хүнсний үйлдвэрийн 17 нэр төрлийн 29 тоног төхөөрөмжийг өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 29 иргэнд сонгон шалгаруулалтаар гэрээгээр эзэмшүүлсэн. Эрдэнэт хивс" ХХК нь 8 нэр төрлийн бүтээгдэхүүн экспортод гаргаж, "Эрдэнэт кашмер" ХХК нь 2023 онд нэхэх, сүлжих цехийн хүчин чадлыг сайжруулсан. "Мөнх баян алт" ХХК нь Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн Progress төслөөс хонины ноосон эсгий табчик, эсгий дотортой арьсан гутал, ажлын эсгий гутал үйлдвэрлэхээр 9.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг авч, тоног төхөөрөмжөө шинэчлэн бүрэн автомат үйлдэлтэй болгосноор шинээр 6 ажлын байрыг бий болгон 13 ажлын байр хадгалагдаж, жилд 2500-3000 хос эсгий табчик үйлдвэрлэн экспортолж байна.</p>		
205		<p>Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд тохирлын баталгаажуулалтаар дэмжлэг үзүүлэх</p>	2021-2024	СХЗХ	ХХАА Г МХГ	Орон нутгийн төсөв	20.0	Нийт үйлдвэрлэлийн 20%	Нийт үйлдвэрлэлийн 40%	5.0	-	<p>Аймгийн хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа мал төхөөрөх 3, мах, махан бүтээгдэхүүний 8, сүүний 3, гурил, тэжээлийн 4, ноос ноолуурын 4, арьс ширэн бүтээгдэхүүний 2, нийт 24 үйлдвэр ажиллаж байна. Үүнээс 2024 онд Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 2, мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 6, ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 2 нийт 10 аж ахуйн нэгжийн хүсэлтээр 14 нэр төрлийн 143 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээ олгон, бүтээгдэхүүнээ тохирлын баталгаатайгаар хэрэглэгчдэд нийлүүлэх, тендэрт өрсөлдөхөд болон гадаад оронд экспортлоход нь дэмжлэг үзүүлсэн. Эрдэнэт хивс, ХХК-ийн үйлдвэрлэж экспортод гаргадаг 3 нэрийн бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олгосон, Эрдэнэт кашмер ХХК-ийн 3 нэр төрлийн 40 нэрийн бүтээгдэхүүнд "Баталгаажсан тэмдэг" олгож бүтээгдэхүүнээ тохирлын баталгаатайгаар хэрэглэгчдэд</p>	88%



												нийлүүлэх, тендерт өрсөлдөх, экспортод гаргахад нь дэмжлэг үзүүлсэн. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 8 үйлдвэр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ гадаадад экспортолж байгаа ба тус үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний экспортод гаргах тухай бүрт тохирлын баталгаажуулалтад хамруулан гэрчилгээжүүлж, гадаад худалдааг хөнгөвчиллөө. Ингэснээр нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 35.2 хувийг экспортод гаргаж байна.	
7.3.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ.													
206	7.3.1.Тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалангийн хүрсэн түвшинг тогтворжуулан хөгжүүлнэ.	Төмс, хүнсний ногооны техник шинэчлэлийг үргэлжлүүлэн, ашиглалтыг сайжруулан, агропарк байгуулах	2021-2022	ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	240.0	-	-	2022-2023 онд Орон нутгийн төсөв 3600.0	2022 онд аймгийн хүн амын хэрэгцээт төмсний 86 хувь, хүнсний ногооны 72 хувийг орон нутгийн үйлдвэрлэлээр хангасан. 2023 онд 12 аж ахуйн нэгж, 563 өрх нийт 5584 га талбайд тариалалт хийж, ургацын мэдээгээр тооцоход аймгийн хүн амын хэрэгцээт үр тариа 100 хувь, төмс 43.3 хувь, хүнсний ногоо 100 хувь орон нутгийн үйлдвэрлэлээр хангасан. 2022 онд Техник дундын төв нь нийт 147 иргэний 196.5 га талбайд 5 төрлийн үйлчилгээ үзүүлсэн. 2023 онд Техник дундын үйлчилгээний төвийн үйл ажиллагааг өргөжүүлэн орон нутгийн төсвийн 177.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар техник, тоног төхөөрөмж худалдан авч 10 төрлийн ажил үйлчилгээг давхардсан тоогоор 257 иргэнд үзүүлсэн нь 2022 оны мөн үеэс 70.0 хувиар өссөн. 2024 онд Агропаркийг түшиглэн Жаргалант суманд төмс, хүнсний ногооны 500 тн багтаамжтай бүрэн механикжсан зоорийг ашиглалтад орууллаа. Агропаркийн техник дундын төв нь нийт 6 зүтгэх хүчний трактор, 12 төрлийн тоног төхөөрөмжтэй үйл ажиллагаа явуулж, хаврын тариалалтад 251 иргэний 189 га талбайд 6 төрлийн үйлчилгээ, ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэх ажилд иргэдийн захиалгаар өвс хадах, тармах, хаман боох, төмс хураахад давхардсан тоогоор 343 иргэний 335.3 га талбайд 4 төрлийн үйлчилгээг үзүүлсэн бөгөөд дундын төвийн үйл ажиллагаа жигдэрсэн. Мөн аймгийн газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд "Тариалангийн үйлдвэрлэлийн нэгдсэн систем"-ийг ашиглах, мэдлэг олгох сургалт, Орхон, Булган, Хөвсгөл аймгийн "Бүсийн тариаланчдын зөвлөгөөн", Өрхийн тариалалтыг	90%	

												дэмжих хөтөлбөрийн багц сургалтуудын хөтөлбөрт "Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтыг сайжруулах, техник, технологийн шинэчлэл хийх зорилгоор тухайн жилд худалдан авсан техникт 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх" тухай арга хэмжээний талаар сурталчлан таниулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүний үр дүнд Баян-Өндөр сумын 2 тариаланч трактор, тоног төхөөрөмж худалдан авч plant.mofa.gov.mn цахим системээр илгээснээр 97.0 сая төгрөгийн буцаан олголт авсан байна.	
207		Төмс, хүнсний ногооны талбайг хашаажуулах ажлыг зохион байгуулах	2022-2024	ХХАА Г ХБТХ ОХ	Сумдын ЗДТГ	Улсын төсөв	84.0	Жаргалант сумд төмс, хүнсний ногооны 250 га талбайг хашаажуулсан.	Төмс, хүнсний ногооны 20 га талбайг хашаажуулна.	28.0	2023 онд Орон нутгийн төсөв 200.0 2024 онд Улсын төсөв 624.0	2019-2020 онд улсын төсвийн 200.0 орчим сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 193 иргэний эзэмшлийн 257 га төмс, хүнсний ногооны талбайг хашиж хамгаалсан. Үүнд Жаргалант сумын "Бөөн бургас"-т 10.2 км, Мухар буланд 15 км ногооны хашааг ашиглалтад оруулж, сумын Засаг даргын Тамгын газрын өмчид шилжүүлэн өгсөн. 2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр Жаргалант сумын Бөөн бургастад 3.6 км хашаа шинээр барьж, 36-р тоочигч 1.5 км хашаа сэргээн засварласнаар 49 иргэний эзэмшлийн 51 га талбайг хашиж хамгаалсан. 2024 онд Бөөн бургас, 36-р тоочигч 18.6 км хашааг шинээр барьж ашиглалтад оруулсан. Мөн Жаргалант сумын тариалангийн талбайн хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаалах зорилгоор нийт 12 байршилд 140 км хашаа барихаар судалгаа гарган Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлснээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 624.0 сая төгрөгийн өртөг бүхий тариалангийн талбайн хашааны төмөр бетон шон 24000 ширхгийг манай аймагт хуваарилсныг татан авч үр тарианы үйлдвэрлэл эрхлэгч 9 аж ахуйн нэгж, 3 иргэнд гэрээгээр эзэмшүүлсэн. Үүний үр дүнд нийт 9 аж ахуйн нэгж 254 иргэний эзэмшлийн 5153 га талбайг хашиж хамгаалсан.	100%
208	7.3.2.Усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлж үр тариа, тэжээл, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний	Усалгааны тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй зээлээр худалдан авахад иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин ажиллах	2022-2024	ХХАА Г ХААД С	-	Улсын төсөв болон төсөл хөтөлбөр	600.0	1 аж ахуйн нэгж 50 га талбайн инженерийн хийцтэй усалгалтын	-	-	2023 онд Улсын төсөв 178.8 2024 онд Улсын төсөв	2022 онд инженерийн хийцтэй худагтай 10 га талбайд хүнсний ногоо тариалж 135 тн буюу га-аас 135 цн, гадаргын усалгаатай 273 га талбайд төмс тариалж 3072 тн буюу га-аас 112.5, хүнсний ногоо 493.2 га талбайд тариалж 5948 тн буюу га-аас 120 цн ургац тус тус хураан авсан. 2023 онд "Шинэ хөдөө-Орхон" төслийн хүрээнд	100%

	тариалангийн талбай, нэгжээс авах ургацын хэмжээг нэмэгдүүлнэ.							системийн дэмжлэгт хамрагдсан.			120.0  Орон нутгийн төсөв 94.0	улсын төсвийн хөрөнгөөр 12 ширхэг 1 га талбай услах хүчин чадалтай бороожуулах усалтын системийг тариаланчдад олгосноор усалгаатай тариалангийн талбай нэмэгдсэн. 2023 онд төмс 145 га, хүнсний ногоо 455 га талбайд усалгаатай нөхцөлд тариалсан бөгөөд үүнээс гадаргуугийн усалгаатай 510 га буюу 85 хувь, усалгааны тоног төхөөрөмжөөр 90 га буюу 15 хувь байна. Усалгаатай нөхцөлд төмс 145 га-аас 1628 тонн буюу га-аас 112 цн, хүнсний ногоо 455 га-аас 9520 тн буюу га-аас 209 цн ургац тус тус хураан авсан. Төмс, хүнсний ногооны талбайд усны зарцуулалт багатай усалгааны дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх зорилгоор "Шинэ хөдөө-Орхон" төслийн хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр 1 га талбай услах хүчин чадалтай бороожуулах усалтын систем нийлүүлсэн. Үүнд: 2023 онд 12, 2024 онд 4 ширхэг, Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих төслийн хүрээнд 2024 онд 4 ширхэг нийт 20 ширхэг усалгааны системийг сонгон шалгаруулалт зарлан 18 иргэн, 2 аж ахуйн нэгж байгууллагад гэрээгээр эзэмшүүлсэн. Үүний үр дүнд төмс, хүнсний ногооны усалгаатай талбайн хэмжээ 20 га талбайгаар нэмэгдсэн.	
209	Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2021-2024	Аймгийн ЗДТГ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	600.0	Жил бүр 1000 өрхийг хөтөлбөрт хамруулсан.	Хөтөлбөрийн хэрэгжилт 100%	150.0	2021-2023 онд Орон нутгийн төсөв 40.0 2024 онд Орон нутгийн төсөв 30.0	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан "Өрхийн тариалалтыг дэмжих" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, жил бүр шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөвт тусган ажиллаж байна. 2023 онд орон нутгийн төсөвт 40.0 сая төгрөг тусгаснаар хөтөлбөрт хамрагдсан Баян-Өндөр сумын 26 багийн 500 өрхөд 5 төрлийн үрийн багц олгож, төмс, хүнсний ногоо тариалах гарын авлагаар ханган, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 80 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр олгосон 13 төрлийн 2.6 тн үрийг 235 өрх, аж ахуйн нэгжид олгосноор нийт 735 өрх, аж ахуйн нэгж 8 га талбайд төмс, 140 га талбайд хүнсний ногоо тариалсан. Аймгийн хэмжээнд 2 иргэн, 11 аж ахуйн нэгж 2200 м.кв талбайд 3 улирлын хүлэмжийн аж ахуй эрхэлж байна. Өвлийн хүлэмжийн аж ахуй	98%	

											<p>эрхлэхээр Засгийн газраас олгогдож буй хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар 2 аж ахуйн нэгжийн материал банкинд судлагдаж байна. Улсын төсвийн хөрөнгөөр "Үйлдвэрлэгч баг" төслийн хүрээнд 90, "Шинэ хөдөө-Орхон" төслийн хүрээнд 10, нийт 100 ширхэг хүлэмжийг иргэн, аж ахуйн нэгжид олгосноор хүлэмжийн талбай 1.2 га талбайгаар нэмэгдсэн. 2023 онд 5.1 га талбайд хүлэмжийн тариалалт хийж, 305 тн ургац хураан авснаар өмнөх оноос 55 тн-р нэмэгдсэн.</p> <p>Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран зохион байгуулсан "Хөдөө аж ахуйн технологи"-ийн сургалтад 45 өрхийн тариаланчийг хамруулсан. 2024 онд Жаргалант сумын 500 өрхийг хамруулан, 30 тн төмсний үр, 50 кг шар лууван, 30 кг хүрэн манжин, 30 кг шар манжин, 25 кг урт сонгинын үрийг олгосон. Үүний үр дүнд төмс 11 га, шар лууван 16 га, шар манжин 5 га, хүрэн манжин 5 га, урт сонгино 3 га талбайд тариалах үрээр ханган ажилласан. Газар тариалангийн үйлдвэрлэлийн цахим бүртгэлийн систем болон "Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам"-ыг танилцуулах, төрөөс олгож буй урамшуулал, дэмжлэгт хамрагдахад системийг хэрхэн ашиглах, материалыг цахимаар бүрдүүлэх зэрэг багц сургалтыг зохион байгуулан мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Тус хөтөлбөрийн хэрэгжилт 98.0 хувьтай хэрэгжиж байна.</p>		
210	7.3.3.Малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг чадавхжуулах сургалтад хамруулах, туршлага судлах арга хэмжээг зохион байгуулах	2022-2024	ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	30.0	-	2-оос доошгүй сургалтад хамруулсан байна.	10.0	<p>2021-2023 онд Төсөл хөтөлбөр 15.0</p> <p>2024 онд Орон нутгийн төсөв 8.5</p>	2021-2022 онд эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 5 иргэн, аж ахуйн нэгжид 332.2 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. 2023 оны байдлаар аймгийн хэмжээнд 168 иргэн эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаа нь өмнөх оноос 27.0 хувиар өссөн үзүүлэлттэй байсан. 2023 онд "Хоршоо хөгжүүлэх сан"-аас мах, сүүний чиглэлийн үхэр сүргийн чанарыг сайжруулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд 6 иргэнд 138.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч фермерүүдийг дэмжих ажлын хүрээнд "Эрдэнэт хот орчмын сүүний үхрийн фермерүүдийн холбоо"-нд ногоон тэжээл боох төхөөрөмж худалдан	100%

	хөгжлийг дэмжинэ.											<p>авахад орон нутгийн төсвөөс 8.0 сая, Прогресс төслөөс 7.0 сая, нийт 15.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр 3 аж ахуйн нэгж, 1 иргэнд нийт 3.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.</p> <p>2024 онд хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээг бууруулахаар сав, баглаа боодлын дотоодын үйлдвэрлэлийг дэмжиж улсын төсвийн 8.5 сая төгрөгийн хөрөнгөөр "Чиглэл" ХХК-д үйлдвэрлэгдсэн хүнсний зориулалтын савыг орон нутгийн сүү боловсруулах 2 үйлдвэр, сүүний чиглэлийн эрчимжсэн мал аж ахуй эрхэлдэг 16 малчин, фермерүүдэд олгож дэмжлэг үзүүлсэн. Эрүүл ахуйн шаардлага хангасан сүүг малчдаас хүлээн авч сүүний үйлдвэрт нийлүүлснээр ард иргэдийг эрүүл аюулгүй хүнсээр хангах боломж бүрдэж байна.</p> <p>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хөдөө аж ахуйн их сургууль, Мал аж ахуйн биотехнологийн сургуультай хамтран эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, 66 хүнийг хамруулан өндөр ашиг шимт малыг төрөлжүүлэн өсгөн үржүүлэх, мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, олон наст тэжээлийн ургамал тариалах, орон нутгийн түүхий эдээр дарш бэлтгэх арга технологийг эзэмшсэн.</p> <p>Төвийн бүсийн эрчимжсэн мал аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэхэд авч хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд хариуцлагатай мал үржүүлэг технологийн хэлэлцүүлэг болон "ШИЛМЭЛ МАЛ-2024" үзэсгэлэн худалдаанд манай аймгаас 4 эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч оролцож туршлага судалсан.</p>	
211	Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх	2021-2024	ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	220.0	өвс 190 тн, тэжээл 70 тн	Аюулгүйн нөөцийг 100% бэлтгэнэ.	60.0	2021-2023 онд орон нутгийн төсөв 160.0	2022 онд аймгийн аюулгүйн нөөцөд 100 тн өвс, 37.5 тн тэжээл, сумдын аюулгүйн нөөцөд 118 тн өвс, 35.9 тн тэжээл, нийт 218 тн өвс, 73.4 тн тэжээл бэлтгэж аймаг, сумын аюулгүйн нөөцийг 100 хувь бэлтгэсэн. Аймгийн хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын 32 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023	100%	

										нутгийн төсөв 196.7	оны 15/02 дугаар тогтоолоор батлуулан аймгийн аюулгүйн нөөцөд өвс 200 тн, тэжээл 86.1 тн бүрдүүлж аймаг, сумдын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг 100 хувь бүрдүүлсэн. Аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг бэлдэхэд орон нутгийн төсвөөс 75.0 сая төгрөг, Баян-Өндөр, Жаргалант сумдын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бэлдэхэд орон нутгийн төсвөөс тус бүр 50.0 сая төгрөг зарцуулсан. 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын хүрээнд аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бэлдэхэд орон нутгийн төсвөөс 75.0 сая төгрөг, Баян-Өндөр сум 50 сая төгрөг, Жаргалант сум 71.7 сая төгрөг нийт 196.7 сая төгрөгийг зарцуулж, аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 60 тн өвс, 25.0 тн тэжээл, Жаргалант сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 50 тн өвс, 30 тн тэжээл, Баян-Өндөр суманд өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 50 тн өвс, 20 тн тэжээл, нийт 160 тн өвс, 75.0 тн тэжээлийг 100 хувь бэлтгэсэн.		
212		Эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх ажлыг өргөжүүлэн, фермерүүдийг дэмжих	2022-2024	ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	1.800.0	Үхрийн фермер 15, гахай фермер 1, тахианы аж ахуй 5, зөгийн 14 аж ахуйн нэгж	Төсөл хөтөлбөрт хамруулан дэмжсэн байна.	600.0	2021-2023 онд Орон нутгийн төсөв 8.0 Төсөл хөтөлбөр 7.0 Хоршоо хөгжүүлэх сан 138.0 ХААҮДС 3800.0 2024 онд орон нутгийн төсөв 8.5 Хоршоо хөгжүүлэх сан 100.0 ЖДҮХС 797.5	2021-2022 онд эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 5 иргэн, аж ахуйн нэгжид 332.2 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. 2023 оны байдлаар аймгийн хэмжээнд 168 иргэн эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаа нь өмнөх оноос 27.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2023 онд "Хоршоо хөгжүүлэх сан"-аас мах, сүүний чиглэлийн үхэр сүргийн чанарыг сайжруулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд 6 иргэнд 138.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч фермерүүдийг дэмжих ажлын хүрээнд "Эрдэнэт хот орчмын сүүний үхрийн фермерүүдийн холбоо"-нд ногоон тэжээл боох төхөөрөмж худалдан авахад орон нутгийн төсвөөс 8.0 сая, Прогресс төслөөс 7.0 сая, нийт 15.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр 3 аж ахуйн нэгж, 1 иргэнд нийт 3.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. 2024 онд хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээг бууруулах, сав, баглаа боодлын дотоодын үйлдвэрлэлийг	100%

											<p>дэмжиж улсын төсвийн 8.5 сая төгрөгийн хөрөнгөөр "Чиглэл" ХХК-д үйлдвэрлэгдсэн хүнсний зориулалтын савыг орон нутгийн сүү боловсруулах 2 үйлдвэр, сүүний чиглэлийн эрчимжсэн мал аж ахуй эрхэлдэг 16 малчин, фермерүүдэд олгож дэмжлэг үзүүлж, аймгийн хүн амыг эрүүл аюулгүй хүнсээр хангах боломж бүрдсэн.</p> <p>Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сангаас мал аж ахуйн чиглэлээр "Арга билиг арвин сүрэг" хоршоонд 100 сая төгрөгийн зээл олгосон.</p> <p>Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас махны чиглэлийн үхэр өсгөн үржүүлэхээр Төмөрт Агро ХХК 200.0 сая төгрөг, Тэнүүн буянт ХХК 197.5 сая төгрөг, Сүүний үхэр өсгөн үржүүлэхээр Роял Алтай Констракшн ХХК 300.0 сая төгрөг нийт 4 аж ахуйн нэгж 797.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан.</p>	
213	7.3.4.Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн усан хангамжийн хүрэлцээг тогтвортой байлгана.	Худаг уст цэгийг шинээр гаргах болон сэргээн засварлаж малчдад эзэмшүүлэх	2022-2024	ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	270.0	Бэлчээрт 71 худаг ашиглагд аж, малчин өрхийн 80% усаар хангагдсан.	2 худаг шинээр, 2 худаг сэргээн засварлан а.	90.0	<p>2021-2023 онд Улсын төсөв 60.0 Орон нутгийн төсөв 206.7</p> <p>2024 онд Орон нутгийн төсөв 62.0</p> <p>Бэлчээрт байрших худаг, уст цэгийг малчдад гэрээгээр эзэмшүүлэн ажиллаж байна. 2021 онд Жаргалант сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Дулаан-Уул багийн Хөөвөр, Шувуут зэрэг газруудад шинээр худаг гаргаж, Дулаан-Уул багийн Жаргалантын хөл дэх худгийг засварласан. 2022 онд Жаргалант сумын Шувуут, Баруунбулаг зэрэг газарт бэлчээрийн 2 худаг, 2023 онд улсын төсвийн 60.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2, орон нутгийн төсвийн 230.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 5 худаг шинээр гаргаснаар 63 өрхийн 17.8 мянган толгой мал усаар хангагдсан. 2024 онд аймгийн хэмжээнд бэлчээрийн зориулалттай 87 худаг уст цэг байгаагаас инженерийн хийцтэй худаг 81, усан сан 6 ашиглагдаж байна.</p> <p>Бэлчээрийн усан хангамжийг сайжруулахаар 2024 оны орон нутгийн төсөвт 1 худгийн хөрөнгө шийдвэрлэгдэж, Малчин багийн Цохионы өвөрт 1 худаг шинээр гаргах ажлыг хийснээр 12 өрхийн 1500 толгой мал усаар хангагдаж, бэлчээрийн усан хангамж 87 хувьд хүрлээ.</p> <p>Худгийн ундарга муудсан 1 худгийг "Далайн эрхэс констракшн" ХХК засварлаж, 2 худгийг малчид өөрийн хөрөнгөөр сэргээн засварласан байна.</p>	100%

214		Бэлчээрт үлийн цагаан оготны тандалт судалгаа хийх	2022-2024	ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	6.0	Бэлчээрийн тандалт, судалгааг бэлчээрийн 30%-д хийсэн байна.	Бэлчээрийн тандалт, судалгааг бэлчээрийн 10%-д хийсэн байна.	2.0	-	Манай аймаг нийт 39.3 мянган га бэлчээрийн талбайтай ба үлийн цагаан оготны тандалт судалгааг 4000 га газарт хийж гүйцэтгэхэд үлийн цагаан оготны тархалт илрээгүй. 2024 онд нийт бэлчээрийн 10% буюу 4000 га талбайд үлийн цагаан оготны тандалт судалгааг 05, 10 дугаар саруудад Ус, цаг уур орчны шинжилгээний төвтэй хамтран Жаргалант сумын Дулаан-Уул багийн Баруун, Зүүн булаг, Зэрэглээ, Цагаан хуст, Тугалч, Панзын далиу зэрэг газруудын 4000 га талбайд хийхэд хөнөөлт хортон мэрэгч, үлийн цагаан оготно илрээгүй байна.	100%
215	7.3.5.Орон нутгийн онцлогт зохицсон ашиг шимийн чиглэлийн үүлдэр, омгийн цөм сүргийн малаар сайжруулна.	Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлэх	2022-2024	ХБТХ ОХ	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	150.0	496 толгой хуц, ухна тоологдсоноос 81% буюу 402 толгой хуц, ухныг 3 суурьт ялган төвлөрүүлсэн.	Бог малын хээлтүүлэгчийн 80-аас дээш хувийг ялган төвлөрүүлнэ.	50.0	-	Аймгийн хэмжээнд 2023 оны эхэнд 848 хуц, ухна тоологдсоноос бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлэх ажлын хүрээнд 724 толгой хуц, ухна буюу 85.4 хувийг 4 суурьт ялган суурилж, мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжийн хяналтад авч үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт, ялган тэмдэглэгээ хийж, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулан, малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн. Бог малын чанарыг сайжруулах зорилгоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан 72 хуц, 40 ухна нийт 112 өсвөр хээлтүүлэгчийг шинээр нөхөн тавьсан. 2023 онд махны чиглэлийн Суффолк үүлдрийн хуцны үрээр Монгол үүлдрийн 270 хонинд зохиомол хээлтүүлэг хийж ажилласан. 2024 оны эхэнд хуц 417, ухна 325 нийт 742 толгой хуц, ухна тоологдсоноос хаврын үзлэг ангилалтаар 603 толгой хуц, ухна буюу 81.2 хувийг 4 суурьт ялган суурилж, мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжийн хяналтад авч үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт, ялган тэмдэглэгээ хийж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн. Монгол үүлдрийн 40 /хуц/ өсвөр хээлтүүлэгчийг шинээр нөхөн тавьж мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулсан. 2023, 2024 онуудад Баян-Өндөр, Жаргалант сумдын 64 малчин өрхөд 140 толгой бог малын хээлтүүлэгч ашиглуулах түрээсийн гэрээ байгуулан ажилласан. Үүний үр дүнд Барга үүлдрээр сайжруулсан F1 төл 3400 толгой байна.	100%



												Бог малын чанарыг сайжруулснаар махны үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж богино хугацаанд эдийн засгийн эргэлтэд оруулах боломж бүрдсэн.	
216		Мал сүрэгт үзлэг ангилалт, ялган тэмдэглэгээ хийх, бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлэх, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулах	2021-2024	ХХАА Г ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	24.0	35.8 мянган толгой малд үзлэг ангилалт, хянан баталгаа жуулалт хийсэн.	Нийт богийн хээлтүүлэгчийг 100, богийн хээлтэгчийн 60 хүртэлх хувийг хамруулна.	6.0	2021-2023 онд Орон нутгийн төсөв 9.5  2024 онд орон нутгийн төсөв 1.7	Орон нутагт үржүүлж байгаа үүлдэр, омог, хэвшлийн малын ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор адуун сүргийг хурдны чиглэлээр, үхэр сүргийг Сэлэнгэ, Алатау, Семменталь, Хар тарлан үүлдэрээр, хонин сүргийг Монгол, Баяд, Барга хуцаар, ямаан сүрэгт Өлгийн улаан, Эрчмийн хар ухна зэргийг үндсэн сайжруулагчаар ашиглаж байна. 2022 онд аймгийн хэмжээнд 37000 толгой малд үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт хийсэн бөгөөд 668 толгой хээлтүүлэгч, 36332 толгой хээлтэгчийг хамруулсан. Нийт 5.6 мянган толгой малыг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн. 2023 онд аймгийн хэмжээнд 37.5 мянган толгой малд үзлэг ангилалт, 2.0 мянган толгой үхэрт ялган тэмдэглэгээ хийсэн. Нийт богийн 848 толгой хээлтүүлэгчид буюу хээлтүүлэгчийг 100 хувь, нийт богийн 58.9 мянган толгой хээлтэгчийн 36.8 мянган толгой буюу 62.4 хувийг хамруулан малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн. Орон нутагт үржүүлж байгаа үүлдэр, омог, хэвшлийн малын ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор адуун сүргийг хурдны чиглэлээр, үхэр сүргийг Сэлэнгэ, Алатау, Семменталь, Хар тарлан үүлдэрээр, хонин сүргийг Монгол, Баяд, Барга хуцаар, ямаан сүрэгт Өлгийн улаан, Эрчмийн хар ухна зэргийг үндсэн сайжруулагчаар ашиглаж байна. 2022 онд аймгийн хэмжээнд 37000 толгой малд үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт хийсэн бөгөөд 668 толгой хээлтүүлэгч, 36332 толгой хээлтэгчийг хамруулсан. Нийт 5.6 мянган толгой малыг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн. 2023 онд аймгийн хэмжээнд 37.5 мянган толгой малд үзлэг ангилалт, 2.0 мянган толгой үхэрт ялган тэмдэглэгээ хийсэн. Нийт богийн 848 толгой хээлтүүлэгчид буюу хээлтүүлэгчийг 100 хувь, нийт богийн 58.9 мянган толгой хээлтэгчийн 36.8 мянган толгой буюу 62.4 хувийг хамруулан малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.	100%

											<p>2024 онд аймгийн хэмжээнд 40.0 мянган толгой малыг үзлэг ангилалтад хамруулан ажилласан. Хавар, намрын үзлэг ангилалтад бог малын 742 толгой хээлтүүлэгч 39.2 мянган толгой хээлтэгчийг 100 хувь хамруулан анги, чанарыг тодорхойлон ажиллахад 7858 толгой буюу 20.0 хувь нь цөм сүрэг, 28652 толгой буюу 71.6 хувь нь үржлийн сүрэг, 3490 толгой буюу 8.7 хувь нь хэрэгцээний сүрэгт бүртгэгдсэн. Мөн 1870 толгой үхрийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.</p> <p>Сэлэнгэ үүлдрийн үхэрт малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлоход аймгийн хэмжээнд 2700 үхэр Сэлэнгэ үүлдрийн үндсэн хэв шинжийг хадгалж, анги чанарыг тодорхойлоход 282 толгой үхэр цөм сүрэгт бүртгэгдсэн.</p> <p>Программд бүртгэснээр e-mongolia системээс малчин, мал бүхий этгээдийн тодорхойлолт авах, дэмжлэгт хамрагдах боломж бүрдсэн.</p>		
217	7.4.Татвар төлөгчдөд чиглэсэн сургалт, зөвлөгөөг тогтмол явуулж, эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулан, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарсан сургалт, үйлчилгээг үзүүлнэ.	Иргэд, татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлэх цахим сургалтын төвийг тохижуулах	2021-2024	Татварын хэлтэс	СТСХ	Орон нутгийн төсөв	12.0	Иргэд, татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлэх цахим сургалт хийх боломж бүрдсэн байна.	Иргэд, татвар төлөгчдөд цахим сургалтын төвөөр дамжуулан 20 удаа сургалт зохион байгуулна	0.5	<p>2021-2023 онд Орон нутгийн төсөв 10.0</p> <p>2024 онд орон нутгийн төсөв 45.0</p>	<p>Татварын газарт 1 өрөөг засварлан, шаардлагатай тусгай техник хэрэгслээр тохижуулан Live, Zoom хэлбэрээр цахим сургалт хийх орчныг бүрдүүлж 2021-2023 онд татварын хууль, тогтоомж, журам, зааврын талаар танхимаар 162, ажлын байраар 128, цахимаар 70 удаа, нийт 160 удаагийн сургалтыг зохион байгуулж, эдгээр сургалтад давхардсан тоогоор дунд сегмент 163, жижиг сегмент 1979, бичил сегмент 7247, хувь хүн 29020, нийт 38409 татвар төлөгчийг хамруулсан. 2024 онд танхимаар 54, ажлын байранд 79, цахимаар 45 удаа, нийт 178 удаагийн сургалт зохион байгуулж, тус сургалтуудад давхардсан тоогоор дунд сегментийн 235, жижиг сегментийн 3289, бичил сегментийн 4268, хувь хүн 22772, нийт 30564 татвар төлөгчийг хамруулав.</p> <p>Төрийн болон ТББ-тай хамтран 21 удаагийн сургалт зохион байгуулж 513 татвар төлөгчийг хамруулсан.</p> <p>Татварын хууль тогтоомж, журам, заавруудыг олон нийтэд хүргэх, сурталчлах зорилгоор орон нутгийн "ETV", "Тусгал ТВ", "Лха тэнгэр", "Номин" телевизтэй хамтран 114 удаагийн тодруулга ярилцлага, цаг үеийн мэдээ, 10 удаагийн ярилцах цаг нэвтрүүлэгт оролцсон. "Гэрэгтв", "Erdenetnews.mn", "update.mn",</p>	100%

											<p>"Баян-Өндөр сум", "Улсын тэргүүний Жаргалант сум", "Орхон аймгийн Татварын газар" пэйж хуудсуудаар 746 төрлийн мэдээ, мэдээллийг 1818 удаагийн давтамжтай сошиал орчинд түгээж, давхардсан тоогоор 493400 орчим иргэнд хүрсэн байна.</p> <p>"Орхон аймгийн Татварын газар" пэйж хуудсыг дагагч 11000, зочилсон хүний тоо 75000-д хүрч өмнөх оны мөн үеэс 27.2 хувиар өссөн бол 2024 онд татварын хууль тогтоомжийн агуулга бүхий 64 видео, 42 бичвэр, нийт 746 постоор мэдээ, мэдээллийг түгээсэн нь 223.1 мянган хүнд хүрч 84%-аар өссөн дүнтэй байна.</p> <p>5-р сард А.Амарын талбайд татвар төлөгч нарт зориулсан "Хариуцлагатай татвар төлөгч", 9-р сард "Нээлттэй хаалга"-ны өдөрлөгийг 3 өдөр зохион байгуулж, давхардсан тоогоор 410 гаруй иргэнд татварын хууль тогтоомжийн зөвлөгөө, мэдээллийг хүргэсэн.</p> <p>Орон нутгийн хэвлэл мэдээллийн 3 байгууллагатай байгуулсан гэрээний гүйцэтгэл, тараах материалын зардалд 19.0 сая, сургалт мэдээллийн хэвлэлийн зардалд 26.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан.</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

НАЙМ.НАЙДВАРТАЙ ЗАСАГЛАЛ

"ЦАХИМ ЭРДЭНЭТ" ТӨРИЙН ШУУРХАЙ ҮЙЛЧИЛГЭЭ

8.1.Төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.

218	8.1.1."Цахим төрийн үйлчилгээ" хөтөлбөр хэрэгжүүлж төрийн байгууллагад байгаа мэдээллийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас шаарддаг байдлыг зогсоож, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг болгох ажлыг үе шаттайгаар	Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн хүрээнд "Цахим төрийн үйлчилгээ" хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэх	2020-2024	ТЗУХ	Холбогдох байгууллагууд	Улсын болон орон нутгийн төсөв	200.0	16%	100%	50.0	2021-2023 онд орон нутгийн төсөв 1370.0 2024 онд орон нутгийн төсөв 305.0	Аймгийн ИТХ-ын 2021 оны 20 дугаар тогтоолоор "Цахим Эрдэнэт-1" хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн Засаг даргын 2022 оны А/202 дугаар захирамжаар Мастер төлөвлөгөөг батлуулан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд 17 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж байгаагаас одоогийн байдлаар 11 арга хэмжээ буюу 64.7 хувь нь бүрэн хэрэгжиж дууссан байна. Үүнд: Смарт Эрдэнэт платформ, аймаг болон сумдын веб сайт, газарзүйн мэдээллийн систем, эмнэлгийн түргэний үйлчилгээнд ухаалаг таблет, багийн төвүүдэд ухаалаг төхөөрөмж, шилэн кабелийн хайгуул, Цахим Эрдэнэт сервер, хөдөлгөөнт холбоо, гадаад гарц, мэдээллийн аудит, дугаар илрүүлэгчтэй камер байна. Санхүүжилтэд 1.37 тэрбум төгрөг зарцуулсан ба үүний 62.5 хувь нь программ хангамж, 25.5 хувь нь тоног төхөөрөмж, 12 хувь нь ажил үйлчилгээний төлбөр байна. Төслийн нэгж, мэдээлэл	90%
-----	---	--	-----------	------	-------------------------	--------------------------------	-------	-----	------	------	---	---	-----

	зохион байгуулна.											сурталчилгаа, Ухаалаг байгууллага аян өрнүүлэх гэсэн 3 арга хэмжээ үргэлжлэн бизнес хөгжүүлэлт хийгдэж байгаа ба 2023 онд тус арга хэмжээг хэрэгжүүлэхэд 227.0 сая төгрөг зарцууллаа. 2024 онд төлөвлөгөөний дагуу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 240.0 сая төгрөгөөр нийтийн тээврийн хяналт, төлбөрийн цахим системийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн, Смарт Эрдэнэт аппликейшн болон бусад техникийн туршилт, холболтын ажлуудыг хийж байна. Төслийн нэгжийн үйл ажиллагаа, мэдээлэл сурталчилгааны зардал 65.0 сая төгрөг зарцуулаад байна.	
219	Иргэд, байгууллагууд төрийн үйлчилгээг цахимаар авдаг болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	2020-2024	ТЗУХ	-	Улсын төсөв	-	16%	100%	-	2024 онд Улсын төсөв 84.0  Орон нутгийн төсөв 82.5	Төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, хоёр суманд E-Mongolia төвийг байгуулан үйлчилгээний ажилтнуудыг сургаж, бэлтгэн ашиглагдах тоног төхөөрөмж, интернэтийн эх үүсвэрээр ханган иргэдэд үйлчилгээ үзүүлж хэвшээд байна. Мөн. Уг төвөөр төрийн үйлчилгээг Төрийн үйлчилгээний цахим (ТҮЦ) машинаар иргэн хуулийн этгээдийн 16 төрлийн 37 үйлчилгээ, E-Mongolia Цахим үйлчилгээний нэгдсэн ХУР-ДАН системээс иргэн, хуулийн этгээдийн 73 төрлийн үйлчилгээг, Улсын бүртгэлийн хэлтсийн киоск машинаар 9 төрлийн 72 үйлчилгээг тус тус үзүүлж байна. ХААН банкны АТМ болон киоск машин, Төрийн банкны АТМ, төлбөр тооцооны киоск машинаар төрийн үйлчилгээ, үүрэн холбоо, авто тээвэр гэх мэт 5 төрлийн 33 үйлчилгээг цахимаар хүргэн иргэдэд үйлчилж байна. Цахим төвөөр нийт 8200 гаруй иргэн үйлчлүүлж, цахим үйлчилгээ авсан байна.  И-Монгол лавлагааны 3 ширхэг киоск машиныг шинээр авч Жаргалант, Баян-Өндөр сумын ЗДТГ-т, Гэр хорооллын нэгдсэн байрны Хур-Дан төвийн үйлчилгээний хэсэгт тус тус байршуулан лавлагаа мэдээллээр үйлчилгээ үзүүлж байна.	100%	
220	Төрийн байгууллагуудын И-Оффис системийн хөгжүүлэлтийг сайжруулах	2021-2023	ТЗУХ	-	орон нутгийн төсөв	30.0	20.0%	100%	-	2021-2023 онд орон нутгийн төсөв 119.4	Төрийн байгууллагуудын албан хэргийн үйл ажиллагаанд И-Оффис систем ашиглагдаж байна. Улсын хэмжээнд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, яам, агентлагууд, төрийн байгууллагуудтай албан бичиг солилцох дундын <a href="https://docx.gov.mn/">https://docx.gov.mn/</a> системд интеграци хийж албан бичиг солилцох хөгжүүлэлт бүрэн хийгдэж ашиглалтад орсноор тус системд	100%	

										2024 онд орон нутгийн төсөв 138.4	<p>холбогдсон 1374 байгууллагатай албан бичиг солилцох нөхцөл боломж бүрдээд байна. Системийг 154 байгууллагын 1792 хэрэглэгч албан хэргийн үйл ажиллагаандаа ашиглаж байна. И-оффис системийн ашиглалтыг өмнөх онтой харьцуулахад байгууллага 3.0 хувь, хэрэглэгч 7.5 хувиар тус тус өссөн байна.</p> <p>2024 онд Бичиг төлөвлөлт хяналтын системийн шинэчлэлт, Бодлогын баримт бичгүүдийн Төлөвлөлт, хэрэгжилтийн системүүдийн шинэчлэлт, Чатын шинэчлэлт, Irgen.erdenet.mn системийн шинэчлэлтүүд хийгдэж үйл ажиллагаанд ашиглагдаж байна. Мөн Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу тоон гарын үсгийн хэрэглээг эрчимжүүлэх ажлын хүрээнд И-Оффис системийг хөгжүүлж тоон гарын үсгийн хэрэглээг нэвтрүүлэхээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт (86.4 сая төгрөг)-аар Erdenet Eoffice eSign system программ хангамжийн хөгжүүлэлтийн ажлыг 2024 оны 12 дугаар сард ашиглалтад оруулж хэрэглээнд нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.</p>	
221	8.1.2.Иргэдийн өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэж, бодлого шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахимаар хянадаг тогтолцоог улам сайжруулна.	Иргэд, төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг цахимаар хянах боломжийг бүрдүүлэх	2021-2023	ТЗУХ	-	Орон нутгийн төсөв	50.0	20.0%	100.0%	-	<p>Аймгийн хэмжээнд И-оффис системийг ашиглан иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна. 2021-2023 онд аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон хэлтэс, албад, төрийн чиг үүрэг бүхий байгууллага, ажилтанд нийт 21666 өргөдөл, гомдол ирснээс 29963 буюу 94.1 хувь нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн байна.</p> <p>2024 онд "Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах"- төвд нийт 2734 өргөдөл, гомдол ирснээс 2624 нь буюу 96.0 хувь нь хуулинд заасан хугацаанд шийдвэрлэгдсэн, 110 нь буюу 4.0 хувь нь шийдвэрлэх хугацаа болоогүй байна. Тус төвд ирж буй өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар 7 хоног тутамд аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнд танилцуулан холбогдох албан тушаалтанд үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.</p> <p>Мөн аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон хэлтэс, албадууд, төрийн чиг үүрэг бүхий байгууллага, ажилтанд нийт 7379 өргөдөл, гомдол ирсний 169 буюу 2.3 хувь нь шийдвэрлэх хугацаа болоогүй, 26 буюу 0.4 хувь нь шийдвэрлэх боломжгүй, 7184 буюу 97.3 хувь нь хуулинд заагдсан хугацаанд</p>	97.3%

											шийдвэрлэгдлээ. Ирсэн өргөдөл, гомдлын 194 нь гомдол, 167 нь талархал, 19 нь санал, 3 нь мэдэгдэл, 6996 нь хүсэлт байна. Ирсэн нийт өргөдөл, гомдлыг агуулгын хувьд авч үзэхэд газрын харилцааны асуудлаар 18.2 хувь, халаалт цэвэр бохир ус шугам хоолойн асуудлаар 16.4 хувь, авто зам засварлах асуудлаар 7.7 хувь, барилгын асуудлаар 6.4 хувь, нийтийн тээврийн үйлчилгээтэй холбогдолтой асуудлаар 5.5 хувь, нийгмийн халамжийн төрөл бүрийн үйлчилгээ авахыг хүссэн асуудлаар 4.8 хувь, худалдаа үйлчилгээний талаар 4.3 хувь, хог хаягдлын асуудлаар 3.6 хувь, цахилгаан шугам сүлжээ, гэрэлтүүлгийн асуудлаар 3.5 хувь, нийтийн аж ахуйн үйлчилгээтэй холбогдолтой асуудлаар 2.6 хувь, эрүүл мэндийн үйлчилгээтэй холбогдолтой асуудлаар 2.5 хувьтай байгаа нь нийт өргөдлийн 75.5 хувийг эзэлж байна. Орхон аймгийн иргэд <i>irgen.erdenet.mn</i> вэб системийг ашиглаж цахимаар төрийн байгууллагуудад илгээж шийдвэрлэлтийг иргэд хянах боломжтой болсон.		
222	8.1.3.Багийн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бөгөөд хүн амын тоо, байршлыг харгалзан Баян-Өндөр сумын зарим багуудыг хувааж шинээр баг нэмж байгуулах асуудлыг шийдвэрлэнэ.	“Багийн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2020-2024	ТЗУХ	-	Улсын болон орон нутгийн төсөв	260.0	-	100%	65.0	2021-2024 онд улсын төсөв 8700.0 2021-2024 онд Орон нутгийн төсөв 460.0 сая	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2021-2024 онд багуудын ажлын байрыг үе шаттайгаар шийдвэрлэн ажиллаж байгаа ба улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Говил, Баянцагаан, Яргуйт, Зэст багуудын цогцолбор төвийг ашиглалтад хүлээн авсан. 2021-2024 онд орон нутгийн төсвийн 96.6 сая төгрөгөөр багийн байруудад урсгал засвар, 320.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 29 багийг суурин болон зөөврийн компьютер, өнгөт принтер, лед дэлгэц гэх мэт техник тоног төхөөрөмж, шаардлагатай эд хогшлуудаар хангасан. Багийн 130 гаруй хэсгийн ахлагчдын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх ажлыг сайжруулах чиглэлээр орон нутгийн төсвөөс харилцаа холбоо, бичиг хэргийн зардалд нийт 128.6 сая /өссөн дүнгээр/ төгрөг зарцуулсан. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор баг бүр нутаг дэвсгэрээ хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байгаа бөгөөд тус хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд орон нутгийн	100%

											<p>төсвөөс нийт 232.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Багийн үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлж, багт ажиллагсдын мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ажлын байран дахь сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулж, багийн ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, мөнгөн тусламж олгох, мэдлэг мэргэшлээ дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, орон гэр, хашааны газар олгох зэрэг ажлуудыг зохион байгуулж ажиллалаа.</p> <p>Иргэдийн өргөдөл гомдлыг цахимаар хүлээн авах irgen.erdenet.mn вэб системд иргэд баг дээрээсээ цахимаар орж төрийн байгууллага, албан тушаалтанд санал, өргөдөл гомдлоо илэрхийлэх боломж олгох зорилгоор орон нутгийн төсвийн 58.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 29 багт "Иргэний цахим булан"-г байгуулан үйл ажиллагааг тогтворжууллаа.</p> <p>Багийн үйл ажиллагаанд иргэд, байгууллагуудын оролцоог хангах, тэдний эрх ашгийг хамгаалах, иргэдээс гаргасан санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэн ажиллаж байгаа бөгөөд баг, Цагдаагийн хэсэг, Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг сайжруулах, эрчимжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж хүн амыг эрүүлжүүлэх эмчилгээ үйлчилгээ, оношлогоо шинжилгээ, сургалт сурталчилгаанд хамруулах, нутаг дэвсгэртээ олон нийтийн эргүүл хамгаалалтын ажлыг тогтмол зохион байгуулж мэдээллийг иргэдэд хүргэж ажиллаж байна.</p> <p>Аймгийн ИТХ-ын 2022 оны Ээлжит 8-р хуралдаанаар Баян-Өндөр сумын Эрдэнэ, Яргуйт, Цагаанчулуут багийг хувааж Чингэл, Баян-Овоот, Найрамдал, Чандмань багуудыг шинээр зохион байгуулж, 2023 оны 1 дүгээр сараас үйл ажиллагааг эхлүүлсэн</p>	
223	Хүн амын тоо, байршлыг харгалзан Баян-Өндөр сумын зарим багийг хувааж, баг нэмж байгуулах	2021-2023	ТЗУХ	-	Улсын болон орон нутгийн төсөв	2.500.0	-	100%	-	-	<p>Аймгийн ИТХ-ын 2022 оны Ээлжит 8-р хуралдаанаар хүн амын тоо, байршлыг харгалзан төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор Баян-Өндөр сумын Эрдэнэ, Яргуйт, Цагаанчулуут багийг хувааж Чингэл, Баян-Овоот, Найрамдал, Чандмань</p>	100%

		асуудлыг шийдвэрлэх										багуудыг шинээр зохион байгуулж, 2023 оноос үйл ажиллагаагаа явуулж байна.	
224	8.1.4.Иргэдийн санал, хүсэлт, санаачилгыг дэмжин бүртгэх, хүлээн авах, бодлого шийдвэрт тусгах нэгдсэн цахим платформ бий болгоно.	Нэгдсэн платформтой болох	2022-2024	ХЗА ТЗУХ	-	Улсын болон орон нутгийн төсөв	80.0	-	100%	-	-	"Цахим Эрдэнэт-1" хөтөлбөрийн хүрээнд иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авах, шийдвэрлэлтийн явц болон шийдвэрлэлт нь иргэдэд нээлттэй, ил тод харагддаг байдлаар төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн И-Оффис системтэй уялдаж ажилладаг байхаар нэгдсэн вэб системийг 2022 оны 10 дугаар сараас ашиглаж эхэлсэн. Уг системд Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд хувийн нууцад хамаарах асуудлаар гаргасан өргөдөл гомдол, санал хүсэлтийг зөвхөн өргөдөл гомдол гаргагч иргэнд өөрт нь харагдахаар, нийтэд хамаарал бүхий асуудлаар гаргасан өргөдөл, гомдлыг нийтэд харагдаж байхаар зохион байгуулагдсан. "Цахим Эрдэнэт-1" хөтөлбөрийн хүрээнд Орхон аймгийн иргэдэд зориулсан Смарт Эрдэнэт платформ байгуулах ажлыг "Монгол контент" ХХК гүйцэтгэж дуусган хэрэглээний туршилтын шатанд төстлөгдөн ажиллаж эхлээд байна. Платформ хэрэглээнд нэвтэрснээр мэдээллийн веб сайт, статистик судалгааны бааз, иргэдийн орон нутгийн төрийн үйлчилгээ авах, харилцах, ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлэх, бизнесийн харилцааг дэмжих боломж бүрдэж хэрэглээний шинэчлэлт, өөрчлөлтүүдийг тухай бүр хийж ажиллаж байна.	100%
<b>ХАРИУЦЛАГАТАЙ ТӨРИЙН АЛБА</b>													
8.2 Аймгийн хэмжээнд төрийн албаны хүний нөөцийн чадавхийг улам сайжруулж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгоно.													
225	8.2.1Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангаж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэх системийг үлгэр жишээ хэрэгжүүлнэ. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын	Аймгийн хэмжээнд гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөх, дүгнэх системийг бий болгож И-Оффис системд холбох	2021-2022	ТЗУХ	-	Орон нутгийн төсөв	65.0	-	-	-	-	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206, 216, 217, 218 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор Стратеги төлөвлөгөө, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, Зохион байгуулалтын нэгжийн болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг программ хангамж ашиглан түргэн шуурхай, хялбар байдлаар төлөвлөх, тайлан гаргах, хяналт үнэлгээ хийж, үйл явцыг автоматжуулах программ хангамжийг И-Оффис цахим системд холбосон бөгөөд программ хангамжийн сургалтыг 2 удаа зохион байгуулсан. Төрийн захиргааны байгууллагууд Стратеги төлөвлөгөө, Байгууллагын	100%



	гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.											гүйцэтгэлийн төлөвлөгөө, Зохион байгуулалтын нэгжийн болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг үйл ажиллагаандаа ашиглаж хэвшээд байна.	
226	хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгах зохион байгуулалтын арга хэмжээ авах	2020-2024	ТЗУХ	Нийт төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, аж ахуйн нэгжүүд	-	-	30%	100%	-	-	Аймгийн Засаг даргын дэргэдэх нутгийн захиргааны байгууллага, төрийн албан хаагчдад иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгах, шагнаж урамшуулахдаа хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах зарчмыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа байдалд мэргэжил арга зүйн зөвлөмжөөр тогтмол ханган ажиллаж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан 65 төрийн байгууллагад “Ёс зүйн дэд хороо”-г шинэчлэн байгуулж, дэд хороодод 267 албан хаагчид томилогдон ажиллаж байна. Төрийн албаны зөвлөлөөс Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын хэрэгжилтэд анхаарах асуудлын талаар зохион байгуулсан сургалтад 66 байгууллагын ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн болох 100 төрийн албан хаагч, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн талаарх сургалтад нийт 1353 төрийн албан хаагч тус тус хамрагдсан. Аймгийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах ажлыг жил бүр зохион байгуулж, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хуралдаанаас гарсан дүгнэлт, зөвлөмжийг байгууллага тус бүрээр бэлтгэн төрийн байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.	100%

												Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэхдээ Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам" - ыг мөрдөн төрийн албан хаагчдын ажлыг хагас, бүтэн жилээр нэгжийн удирдлага үнэлгээг хийж, "Үнэлгээний баг" томилон үнэлгээг хянан баталгаажуулан ажиллаж байна. Үнэлгээ хийхдээ төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, хандлага, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгон дүгнэж байна. Тайлант хугацаанд төрийн байгууллагуудад ёс зүйн 6 гомдол, мэдээлэл ирснийг шалган хэлэлцэж 5 төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан нь нотлогдсоны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллалаа.	
227	8.2.2.Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна.	Хүний нөөцийн программыг цалингийн нэгдсэн системтэй холбох ажлыг хийх	2020-2021	ТЗУХ СТСХ	-	Орон нутгийн төсөв	167.0	20%	-	-	-	Төрийн албаны цалингийн нэгдсэн системийг нэвтрүүлэх сургагч багшаар бэлтгэгдсэн 5 багш баталсан төлөвлөгөөний дагуу аймгийн төвийн болон Баян-Өндөр, Жаргалант сумдын нийт 96 байгууллагын хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн санг хянан явцын засвар өөрчлөлтийг байгууллага, албан хаагч бүрээр хийж өгч, ажилтан, алба хаагчдын үндсэн болон нэмэгдэл цалин хөлсний шинэчлэлтийг бүрэн хийлгэж гүйцэтгэсэн. Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын цалингийн нэгдсэн систем нь нууцын зэрэглэлд байдаг тул тус системд хамрагдаагүй болно. Сургалтыг төлөвлөгөөний дагуу байгууллагын цалингийн загвар үүсгэх, цалингийн загварт багануудын үзүүлэлтийг зөөвөрлөн байршуулж хадгалах, ур чадварын нэмэгдлийг тооцож оруулах, амралтын цалин бодох, цалингийн түүх оруулах, цалингийн суутгал тохируулж хийх, кодын блок үүсгэх, Хүний нөөцийн нэгдсэн сангийн системд цалингийн сүлжээний зэрэглэл, шатлал өөрчлөх, алба хаагчийн цалингийн мэдээллийн өөрчлөлтийг татах, цалингийн загварт шинээр нэмэгдэл болон суутгал нэмж оруулах, ээлжийн амралт хэрхэн тооцох, загвар файл хэрхэн үүсгэх, зэрэг зааврыг өгч ажиллаж байна. Төрийн албаны цалингийн нэгдсэн систем болон Хүний нөөцийн удирдлагын системийг Орхон аймгийн	100%

											төсвийн байгууллагын хэмжээнд 100 хувь хамруулж ажилласан.		
228	8.2.3.Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, сургалт, нийгмийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн дэмжиж ажиллана.	Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг тухайн байгууллагуудын жил бүрийн төлөвлөгөөнд тусган шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах	2020-2024	ТЗУХ	Төрийн байгууллагууд	Улсын болон орон нутгийн төсөв	-	20%	100%	-	2021-2023 онд Улсын болон орон нутгийн төсөв 2358.9 2024 онд Орон нутгийн төсөв 206.8	Төрийн байгууллага бүр албан хаагчдыг дэмжих нийгмийн хамгааллын болон сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хөтөлбөрийн дагуу судалгааг хагас, бүтэн жилээр нарийвчлан гаргаж, хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар тогтмол ханган ажиллаж байна. 2021-2022 онд аймгийн хэмжээнд нийт төрийн байгууллагуудын албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд давхардсан тоогоор 4484 төрийн албан хаагчид 1.9 тэрбум төгрөг, 2023 онд хууль тогтоомжид заасан бусад нөхөх төлбөрт 271 төрийн албан хаагчид 45.4 сая төгрөг, орон байраар хангагдахад 2 төрийн албан хаагчид 15.0 сая төгрөг, ажиллах хугацаандаа мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамрагдсан 16 төрийн албан хаагчид 44.5 сая төгрөгийг тус тус олгосон. 2023 онд аймгийн хэмжээнд "Төрийн албан хаагчийн хөгжлийн хөтөлбөр"-ийг шинээр батлуулан, хэрэгжилтийг ханган ажилласнаар тухайн байгууллагад тогтвор суурьшил, үр бүтээлтэй, 10-аас доошгүй жил ажилласан, орон нутгийг хөгжүүлэх эрдэм шинжилгээний бүтээл туурвисан, тухайн бүтээл нь орон нутагт бодит үр дүнд хүрч олон нийтэд эерэг өөрчлөлт, сайн үр дүнд хүрсэн, донорын үүрэг гүйцэтгэж буй болон эрхтэн шилжүүлэн суулгах хагалгаанд орж буй, өрхийн орлого буурч хүн амын амьжиргааны баталгаажих доод түвшинд хүрэхгүй байгаа, амины орон сууц барих, худалдан авах болон нөхцөл сайжруулах нийт 46 төрийн албан хаагчид 281.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, төрийн албан хаагчдын сургалтын зардалд 18.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Мөн тус хөтөлбөрийн хүрээнд тогтвор суурьшилтай, ажлын амжилт гаргасан 8 байгууллагын 13 төрийн албан хаагчийг гадаад улсад туршлага судлуулах дэмжлэгт хамруулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2024 онд 16 арга хэмжээг төлөвлөн ажилласан бөгөөд тухайн байгууллагад тогтвор	90%

											суурьшил, үр бүтээлтэй, 33-21 жил ажилласан 11 байгууллагын 16 төрийн албан хаагчдад 111.9 сая төгрөг, Удирдлагын академитай хамтран анх төрийн албанд орсон албан хаагчдад чиглүүлэх богино хугацааны сургалтад 3 байгууллагын 50 албан хаагч, "Хөгжлийн бодлого, хэрэгжилт- үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл" сэдэвт сургалтад 5.0 сая төгрөгийн санхүүжилтээр 34 байгууллагын 68 албан хаагчийг хамруулсан. Мөн тогтвор суурьшилтай, ажлын амжилт гаргасан 13 байгууллагын 14 төрийн албан хаагчдыг гадаад улсад туршлага судлуулах дэмжлэгт хамруулж 89.9 сая төгрөгийг зарцуулаад байна. Төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, шаардлагатай тоног төхөөрөмж, тавилгаар хангах, төрийн албан хаагчдын эрүүл мэндийн үзлэгт оруулах, дархлааг дэмжин амин дэм олгох зэрэг ажлыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна.		
229		Төрийн албан хаагчдыг богино, зорилтот, дунд хугацааны болон мэргэшүүлэх сургалтуудад үе шаттайгаар төрөл бүрийн хэлбэрээр хамруулах	2020-2024	ТЗУХ	Төрийн албаны салбар зөвлөл	Улсын болон орон нутгийн төсөв	145.0	10.0	100%	45.0	2024 онд Орон нутгийн төсөв 19.0	2021-2022 онд Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургуультай хамтран нийт 132 төрийн албан хаагчийг сургалтад хамруулан суралцах явцад хяналт тавин ажилласан. 2023 онд Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургуультай хамтран "Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь" богино хугацааны сургалтын сургагч багш бэлтгэх сургалтад 2 байгууллагын 3, нутгийн захиргааны байгууллагад ажиллаж байгаа, анх томилогдсон төрийн албан хаагчийг чиглүүлэх зайн сургалтад 7 байгууллагын 11, дунд хугацааны мэргэшүүлэх зайн сургалтад 15 байгууллагын 15 төрийн албан хаагч, цаашид ажиллах ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц зайн сургалтад 9 байгууллагын 12 төрийн албан хаагч, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц зайн сургалтад 1 төрийн албан хаагчийг тус тус хамруулсан. Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ "Алсын хараа 2050" сэдэвт богино хугацааны танхимын ажлын байран дахь сургалтыг Ерөнхий сайдын зөвлөх, ЗГХЭГ, Удирдлагын академийн багш нартай хамтран зохион байгуулж тус сургалтад 40 байгууллагын 212 төрийн албан хаагчдыг танхимаар хамрууллаа. Мөн Алсын хараа 2050, Шинэ	100%

												сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх цахим сургалтыг 2 удаа зохион байгуулан 82 төрийн байгууллагын 2178 төрийн албан хаагч хамрагдан гэрчилгээгээ авсан. Төрийн албаны зөвлөл, "Мерит" төслөөс хамтран "Хувь хүний хөгжил"-ийн чиглэлээр 7 хоног бүрийн Пүрэв гариг бүр 32 удаа цахимаар зохион байгуулагдан давхардсан тоогоор нийт 1580 гаруй төрийн албан хаагчид хамрагдсан. 2024 онд Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургуультай хамтран "Баг/хорооны засаг дарга нарыг чадавхжуулах нь", "Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл" богино хугацааны сургалтад сургагч багш бэлтгэх сургалтад 3 байгууллагын 7, нутгийн захиргааны байгууллагад ажиллаж байгаа анх томилогдсон төрийн албан хаагчийг чиглүүлэх зайн сургалтад 12 байгууллагын 12, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 4 байгууллагын 4, дунд хугацааны мэргэшүүлэх зайн сургалтад 20 байгууллагын 20 төрийн албан хаагч, цаашид ажиллах ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц зайн сургалтад 9 байгууллагын 9 төрийн албан хаагч, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 байгууллагын 1 албан хаагч, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг мэргэшүүлэх орон нутгийн захиалгат сургалтад 3 байгууллагын 50 албан хаагч, нийт 52 байгууллагын 103 албан хаагчийг хамруулж, суралцах явцад хяналт тавин ажиллаж байна. Мөн баг, хорооны Засаг дарга нарыг чадавхжуулах богино хугацааны зорилтот танхимын сургалтад 29 багийн Засаг дарга нар, "Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл" сургалтад 34 төрийн байгууллагын 68 төрийн албан хаагчдыг хамруулсан.	
230	8.2.4.Нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн хүрээнд шийдвэр гаргах бүх шатанд төр, иргэний нийгмийн	Аймгийн хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээрийг байгуулан ажиллах	2021-2024	ХШҮХ НБХ АОЭХ ОАҮЭ Х	ХХҮГ МХГ	Үйл ажиллаг ааны чиглэлэр	-	2019-2020 оны хамтын хэлэлцээр ийн хэрэгжилт 92.6%-тай байна.	Хэлэлцээрийн хэрэгжилт 90%-тай байна.	-	-	Аймгийн Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2023-2025 оны хамтын хэлэлцээрт 7 бүлгийн 81 арга хэмжээг тусган батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2023 оны байдлаар Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хамтын хэлэлцээрийн биелэлт 88.9 хувьтай хэрэгжсэн.	98.8%

231	байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил зөвлөлдөх, санал авах, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавихад оролцоог нэмэгдүүлнэ.	Төрийн зарим чиг үүргийг Төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулан хамтран ажиллах	2021-2024	ХБТХ ОХ	Аймгийн ЗДТГ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	2020 онд 28 ТББ 87.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан	16 чиг үүрэгт хамаарах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	Батлагдсан төсвийн хүрээнд	2021-2023 онд орон нутгийн төсөв 199.1 2024 онд орон нутгийн төсөв 80.0	2021-2023 онд 47 төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж нийт 199.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж ажилласан. 2024 онд аймгийн Засаг даргын Тамгын газраас төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулахад 80.0 сая төгрөг зарцуулахаар батлагдсаны дагуу 13 төрийн бус байгууллагатай хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, хоршоо хөгжүүлэх, байгаль экологи, хүнсний аюулгүй байдал, сургалт мэдээлэл, нийгмийн оролцоо, хөгжил, хууль эрх зүйн мэдлэг олгох, үнийн асуудал зэрэг 12 чиг үүргийн хүрээнд гэрээ байгуулан хамтран ажиллаж 80.0 сая төгрөгийг зарцуулаад байна.	100%
<b>АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ ХОТ</b>													
<b>8.3.Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.</b>													
232	8.3.1.Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын системийг нэвтрүүлж, Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагааг сайжруулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагааг сайжруулж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах	2021-2024	ХЭЗХ	МШУТ	Орон нутгийн төсөв	361.5	-	Шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	110.0	2021-2023 онд орон нутгийн төсөв 575.7 2024 онд Орон нутгийн төсөв 415.0	2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 90.0 сая төгрөгийн үнэ бүхий камерын засвар үйлчилгээ хийхэд шаардлагатай тусгай зориулалтын автовишктай автомашиныг худалдан авч, давхардсан тоогоор нийт 100 орчим камерын шон дээр 250 гаруй камерыг, дагалдах хэрэгслийн хамт бүрэн шинэчилж засварласан. Мөн гэр хороололд агаарын баганаар татагдсан кабелийн гэмтлийг засварлан 3км шилэн кабель татаж, унжсан аюултай байдал бий болсон 7 цэгт шилэн кабелийг дээш нь татах, сойх ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн. Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн камерын сүлжээний нийт багтаамж нь 1ГБ/с учраас хяналтын камер нэмэгдэхийн хэрээр сүлжээний ачаалал нэмэгдэж гацаж байсан. Уг асуудлыг шийдвэрлэх зорилгоор төвийн хяналтын камерын системийн үндсэн сүлжээний дамжуулалтыг нэмэгдүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад зориулж 2024 онд орон нутгийн төсвөөс 50.0 сая төгрөгийг зарцуулж, тус ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "МонТех дистрибьюшн" ХХК тоног төхөөрөмжийг нийлүүлэн суурилуулалтыг хийснээр сүлжээний үндсэн урсгалын багтаамж 10ГБ/с болоод байна. 2024 онд 335.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Орхон аймгийн хэмжээнд 15 байршилд 15ш дугаар таньдаг камер, 15 ширхэг царай таньдаг тусгай зориулалтын камер суурилуулж ашиглалтад оруулаад байна.	100%

												Ингэснээр Баян-Өндөр сумын хэмжээнд 25 байршил, Жаргалант сумын хэмжээнд 1 байршилд дугаар таньдаг камер ажиллаж байна.	
233		Хотын гудамж, зам талбайн камержуулалтыг үе шаттайгаар нэмэгдүүлэх	2021-2024	ХЭЗХ	МШУТ ЦГ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Ажиллаж буй камерын тоо 183	Камерын тоог нэмэгдүүлсэн байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	2021-2023 онд орон нутгийн төсөв 1100.0 2024 онд Орон нутгийн төсөв 3882.8	<p>Баян-өндөр сумын багуудын Засаг дарга, ажлын алба, хэсгийн байцаагч, иргэдийн төлөөлөл нартай уулзалт зохион байгуулж гэмт хэрэг ихээр гардаг хар цэгийн судалгаанд үндэслэн камер суурилуулах байршил, цэгийг 26 багаар нарийвчлан гаргасан. Судалгааны дагуу:</p> <ul style="list-style-type: none"> <li>· 2021 онд 104 ш камер</li> <li>· 2022 онд 412 ш камер</li> <li>· 2023 онд 150 ш камер</li> <li>· 2024 онд 621 ш камер тус тус орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэмэлтээр суурилуулсан.</li> </ul> <p>Дэвшилтэт технологид боловсруулсан өгөгдлийг ашиглан хяналтын камеруудыг үр ашигтай, эдийн засгийн үр өгөөжтэй ашиглаж хиймэл оюун ухаанд суурилсан системийг нэвтрүүлэх туршилтыг амжилттай хийсэн. Уг систем нь энгийн камераар авто машины дугаар илрүүлэх, хүний биометрик мэдээлэл, царай төрхөөр олж илрүүлэх боломжтой. 2024 онд "Ногоон Эрдэнэт" төслийн хүрээнд 210 цэгт 721 хяналтын камер байршуулах судалгаа, нэгдсэн систем, техникийн даалгавар, тодорхойлолтыг гаргаж, теле хяналтын камерт 3.9 тэрбум, төгрөг орон нутгийн төсөвт тусгагдсан. Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас камержуулалтын 26 ажлын тендер сонгон шалгаруулалтыг зарлаж, 23 ажлын гүйцэтгэгч компанийн ажил бүрэн дуусаж хүлээлгэн өгсөн, 3 ажил нь гүйцэтгэлийн шатандаа явж байна. Энэ ажлын хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 621ш камер дагалдах хэрэгслийн хамт иж бүрэн суурилуулан ашиглалтад оруулсан. 24 баг болон Эрдэнэт хотын ЕБС, СӨБ-ын гадна орчны камеруудыг МШУТөвийн камерын нэгдсэн системд холбосон. Ингэснээр аймгийн хэмжээнд 26 багт нийт 1287 ширхэг камер бүртгэлтэй ажиллаж байна. Үүнээс: Нэг чиглэлийн 1077 ширхэг, PTZ хөдөлгөөнт 168 ширхэг, хэт ягаан туяаны 2 ширхэг, ANPR дугаар таних зориулалттай 25 ширхэг, царай таних 15 ширхэг камер тус тус ажиллаж байна.</p>	100%

												2024 онд хяналтын камерын тусламжтайгаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 4800 санал хүсэлт хүлээн авч, иргэд, байгууллагад учирсан 729.0 сая төгрөгийн хохирлоос 59.8 сая төгрөгийн хохирлыг барагдуулж ажилласан.	
234	8.3.2.Эмэгтэйчүүд хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах түр хамгаалах байр байгуулж, хуульд заасны дагуу мэдээллээр хангана.	Түр хамгаалах байрыг байгуулах	2021	ХЭЗХ ХБТХ ОХ	ГБХЗ ХГ ЦГ ЭМГ	Улсын болон орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	-	-	2021-2023 онд улсын төсөв 1261.0	2021-2023 онд түр хамгаалах байранд нийт 171 хүнийг хүлээн авч түр байрлуулах, эмнэлгийн анхан шатны үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн болон хууль зүйн туслалцаа зөвлөгөө мэдээлэл өгөх зэргээр 10 төрлийн үйлчилгээг үзүүлсэн. 2024 онд Түр хамгаалах байр ажиллуулах, хохирогчид хуульд заасан үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах зардал 45.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусган хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр байрлуулах, иргэдэд эмнэлгийн анхан шатны үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн болон хууль зүйн туслалцаа зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээг үзүүлж, тайлант хугацаанд нийт 24 гэр бүлийн 78 иргэн үйлчлүүлснээс 15 нь насанд хүрэгчид, 63 нь хүүхэд байна. Үйлчилгээ авсан хүүхдүүдэд сэтгэл зүй, сэтгэл заслын оношилгоо, эмчилгээ хийх чиглэлээр мэргэжлийн "Сэтгэл зүйн цогц боловсролын төв" НҮТББ-тай хамтран ажиллаж сэтгэл зүйн үйлчилгээнд 31 хүүхэд /давхардсан тоогоор 161 хүүхэд/ хамруулсан. Мөн боловсролын үйлчилгээнд 5 хүүхэд холбон зуучилж, эрүүл мэндийн үйлчилгээнд 6, нийгмийн халамжийн үйлчилгээнд 1 хүүхдийг тус тус хамруулсан. Шинээр стандартад нийцсэн хамгаалах байрны төсөл боловсруулан газрын асуудлыг шийдвэрлэж, зураг төсвийг боловсруулан улсын төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар барилгын ажлын гүйцэтгэл 75.0 хувьтайгаар барилгын ажил удаашралтай явагдаж байна.	70%
235	8.3.3.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих ажлыг эрчимжүүлэх	2021-2024	ХЭЗХ ЦГ	-	Орон нутгийн төсөв	30.0	-	Урьдчилан сэргийлэх ажлын хамралтын хувь нэмэгдсэн байна.	8.0	2021-2023 онд орон нутгийн төсвөөс 34.0 2024 онд Орон нутгийн төсөв 38.0	Аймгийн хэмжээнд мансууруулах эм худалдах зөвшөөрөлтэй 5, сэтгэцэд нөлөөт эм худалдах зөвшөөрөлтэй 9 эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллагын эмийн хяналт, хадгалалт, хамгаалалтад 2 удаа хяналт шалгалтыг зохион байгуулж зөвлөмж хүргүүлсэн. 2023 онд нууц далд аргаар үйлдэгдсэн 13 холбогдогчтой 7 гэмт хэрэг, 16 холбогдогчтой 4 зөрчлийг илрүүлэн шалгаж холбогдох арга хэмжээг авч ажиллалаа.	90%



											<p>"Тархцын хяналт-2023" нэгдсэн арга хэмжээний хүрээнд 2017 оноос хойш Мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг гэмт хэрэг, мансуурсан гэх зөрчилд холбогдсон этгээдүүдийн судалгааг гаргаж, эмзэг цэгийг тогтоох чиглэлээр хяналт тавьж ажиллалаа.</p> <p>2024 онд орон нутгийн төсвөөс 18.0 сая төгрөг, аймгийн ГХУСАЗСЗ-ийн зардлаас 20.0 сая төгрөг, нийт 38.0 сая төгрөгийн санхүүжилтийг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил болон "Устгал-2024" нэгдсэн арга хэмжээнд зарцуулахаар шийдвэрлүүлсэн.</p> <p>Аймгийн хэмжээнд "Анзаар" хэсэгчилсэн арга хэмжээг аймгийн ерөнхий боловсролын 25 сургуулийн ахлах ангийн сурагч, багш, нийгмийн ажилтан, сургалт хүмүүжлийн ажилтан, ар гэр, асран хамгаалагч нарт чиглэсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нөлөөллийн аян зохион байгуулсан. Цагдаагийн газрын 84, гэрээт цагдаагийн хэлтсийн 103, Дотоод цэргийн 78 нийт 265 албан хаагчдад "Мансуурсан этгээдэд илрэх шинж тэмдэг, биедээ авч явж болзошгүй хэрэглүүр" сэдэвт 4 цагийн сургалтыг зохион байгуулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийт 200 ширхэг тараах хуудас тарааж ажилласан.</p> <p>2024 онд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг 7 бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 хэргээр нэмэгдсэн.</p>		
236		Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх зорилгоор зориулалтын шаардлага хангасан тестийг үйл ажиллагаандаа ашиглах	2022-2024	ХЭЭХ ЦГ	-	Орон нутгийн төсөв	9.0	-	Гэмт хэргийн илрүүлэлт ийг ахиулсан байна.	3.0	2021-2023 онд 3.0	<p>Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх зорилгоор зориулалтын шаардлага хангасан 150 ширхэг тестийг Цагдаагийн газарт олгосон. 2023 онд гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 150 хүнд "Multi drug screen cup" тест ашиглан мөрдөн шалгах ажиллагаа явуулахад 14 хувь нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн болох нь тогтоогдож илрүүлэлт 22.2 хувиар өссөн.</p> <p>2024 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 437 дугаар нээлттэй хорих ангийн хяналтад байдаг</p>	90%

											зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэгдсэн 2 этгээдэд аймгийн Прокурорын газрын ахлах Прокурорын хамт сургалт, мэдээлэл хийж дахин хэрэглэж байгаа эсэхийг шалгах аар "Multi drug screen cup" тестээр биологийн дээж авах ажлыг зохион байгуулсан. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэрэг бүртгэлтийн 8 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 5 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татаж Мөрдөн байцаалтын 5 хэрэгт ажиллагаа явуулж, 5 хэргийг шүүхэд шилжүүлж шийдвэрлэсэн бөгөөд 3 хэрэг ажиллагаанд шалгагдаж байна. Энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судалж, дахин гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мөрдөгчийн 4 мэдэгдэл бичиж, холбогдох газарт хүргүүлж, хариуг нь тооцсон. Тайлант хугацаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах 7 гэмт хэргийг илрүүлж, өмнөх оны мөн үеэс 16.7 хувиар өссөн байна.	
237	Мансууруулах төрлийн ургамлыг устгах ажлыг зохион байгуулах	2021-2024	ХЭЗХ ЦГ	-	Орон нутгийн төсөв	31.0	-	Ургамлын тархцын хэмжээ багассан байна.	8.0	2021-2023 онд орон нутгийн төсвөөс 34.0 2024 онд Орон нутгийн төсөв 38.0	Аймгийн нутаг дэвсгэрт ургасан зэрлэг олсны ургамлын тархцыг Аймгийн прокурорын газар, Цагдаагийн газар хамтран судлан тогтоож, "Устгал-2023" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, Баян-Өндөр суманд 15 га, Жаргалант суманд 90 га талбайд ургасан олс /каннабис/-ны ургамлыг устгахад орон нутгийн төсвөөс 18.0 сая төгрөгийг зарцууллаа. Жаргалант сумын нутаг дэвсгэрт газар, тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллагын удирдлагуудад ногооны талбайн ойр орчимд ургасан сэтгэцэд нөлөөт бодисын агууламжтай каннабисын ургамлын тархцын талаар тайлбарлан ойлгуулж, устгах талаар мэдэгдэл өгч ажилласнаар газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 9 аж ахуйн нэгж 65 га талбайд зэрлэг олсны ургамлыг устгах ажлыг хийсэн байна. 2024 онд орон нутгийн төсвөөс 18.0 сая, аймгийн ГХУСАЗСЗ-ийн зардлаас 20.0 сая төгрөг, нийт 38.0 сая төгрөгийн санхүүжилтийг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил болон "Устгал-2024" нэгдсэн арга хэмжээнд	100%

											зарцуулахаар шийдвэрлүүлж, 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 08 дугаар сарын 30-ны өдрийн хооронд 2 үе шаттайгаар устгал хийж Жаргалант сумын нутаг дэвсгэрт 75 га талбайд ургамлын хор цацаж, 5 га талбайд гараар түүж шатааж, 15 га талбайд газар хагалж, Баян-Өндөр сумын нутаг дэвсгэр буюу хотын төв, гэр хорооллын хэсэгт 13 га талбайд ургасан зэрлэг олсны ургамлыг гар аргаар хор цацаж устгах ажлыг зохион байгуулж нийт 108 га талбайд зэрлэг байдлаар ургасан олсны /каннабис/ ургамлыг устгах ажлыг зохион байгуулсан.		
238	8.3.4.Ял эдэлж буй иргэдийг хөдөлмөрлөх нөхцөлөөр хангах замаар гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах нөхцөл боломжийг хангана.	ШШГГ-ын үйлдвэрлэлийн хэсэгт шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах, үйлдвэрлэлийг өргөжүүлэх замаар хөдөлмөрт хамрагдах боломжийг нэмэгдүүлэх	2021, 2024	ХЭЗХ ШШГГ	-	Орон нутгийн төсөв	75.0	-	Оёдлын цехэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	40.0	2021-2023 онд: Орон нутгийн төсөв 155.0 2024 онд: орон нутгийн төсөв 112.0	Хоригдлыг ажлын байраар хангах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах, үйлдвэрлэлийн төрөл чиглэлийг өргөжүүлэн хоригдлын мужаан цехэд сийлбэртэй шатар, эмээлийн тавиур, морин хуур, сийлбэртэй цаг бусад бэлэг дурсгалын зүйлс, гар урлал, суран эдлэл, хазаар ногт, чөдөр, ажлын баяжмалын шуудай зэргийг үйлдвэрлэж байна. Төлбөртэй хоригдлыг ажлын байраар хангах чиглэлээр оёдлын цехэд шаардлагатай оёдлын тоног төхөөрөмжийг шийдвэрлүүлж хоригдлын нийгэмд учруулсан хохирлыг барагдуулахаар ажиллаж байна. Хоригдлыг ажлын байраар хангах чиглэлээр оёдлын цехэд шаардлагатай оёдлын тоног төхөөрөмжийг худалдан авахад зориулж орон нутгийн төсвөөс 60.0 сая төгрөгийг шийдвэрлэн 20 ширхэг оёдлын машин авч, 20 хоригдлыг оёдол, эсгүүрийн мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулсан. 2023 онд нийт давхардсан тоогоор 118 хоригдлыг цалинтай ажлын байраар хангаж 99.2 сая төгрөгийн цалин бодогдож, 54 хоригдлын нэрийн дансанд 11.9 сая төгрөгийг шилжүүлсэн. 2024 онд хорих ангийн үйлдвэрлэл болон хоригдлын орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор хоригдлын гал тогооны тоног төхөөрөмж, телекамерын хяналтын тоног төхөөрөмж, мужааны цехэд модны лазер машин зэрэг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авахад орон нутгийн төсөвт 112.0 сая төгрөгийг тусган батлуулж, 150квт-ын лазер машин, гал тогооны	100%

											<p>хэрэгсэл, тоног төхөөрөмж, камержуулалтын тоног төхөөрөмжийг нийлүүлэхээр Чандмань биндер ХХК шалгарч 31 нэр төрлийн тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн. Хоригдлыг ажлын байраар хангах чиглэлээр оёдлын цехэд төлбөртэй 18 хоригдлыг ажилд хамруулан баяжмалын 9000 ширхэг уутыг оёж нийлүүлэн төлбөртэй хоригдлын төлбөрийг хэсэгчлэн болон бүрэн төлж барагдуулж байна. Орхон аймаг дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран мэргэжлийн чиг баримжаа, хөдөлмөрийн дадал олгож, хоригдлыг ажлын байраар хангах зорилгоор автомашин засварчин мэргэжил олгох сургалтад 8 хоригдлыг, гагнуурчин мэргэжил олгох сургалтад 7 хоригдлыг хамруулан ажиллаж мэргэжлийн үнэмлэхийг гардуулсан.</p> <p>2023 оны жилийн эцсээр нийт 105 хоригдлын 1621.1 сая төгрөгийн төлбөртэй байсан. Үүнээс: 2024 онд:</p> <p>Ар гэрээс төлбөрийг бүрэн барагдуулсан 17 хоригдлын 71.8 сая төгрөг Цалин хөлснөөс бүрэн барагдуулсан 6 хоригдлын 1.3 сая төгрөг Цалин хөлснөөс хэсэгчилж барагдуулсан 31 хоригдлын 17.7 сая төгрөг Өөр хорих анги руу шилжсэн 8 хоригдлын 105.5 сая төгрөг Цагдаагийн байгууллагад дуудлагаар явсан 4 хоригдлын 9.1 сая төгрөг Ялын хугацаа дуусаж суллагдсан 15 хоригдлын 242.5 сая төгрөг төлж тус тус шилжүүлсэн.</p>	
239	8.3.5.Үндэсний санах ой болох архивын баримтын хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулж, иргэдэд архивын баримтын лавлагаа мэдээллээр шуурхай үйлчлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	Төрийн архивын баримтын хадгалалт хамгаалалт, ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах, техник тоног төхөөрөмжийг шинэчлэх	2022-2024	ХЭЗХ	Архивын тасаг	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	<p>2021-2023 онд: Орон нутгийн төсөв 49.0 2024 онд Орон нутгийн төсөв 124.1</p> <p>Орон нутгийн төсвийн 26.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар архивын баримтын бүртгэлийн ухаалаг тоологчийн төхөөрөмж болон 14900 ширхэг соронзон чип, 5.0 сая төгрөгөөр баримтыг сэргээн засахад шаардлагатай тоног төхөөрөмж, худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж байна. Төрийн архивын хадгаламжийн сангийн өрөөний багтаамжийг нэмэгдүүлэх зорилгоор Засаг даргын Тамгын газрын шинээр баригдсан өргөтгөлийн барилгад 69 м.кв хадгаламжийн сангийн 1 өрөөг шинээр тохижуулан 220.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2500х900х560 хэмжээ бүхий 13 ширхэг ухаалаг нягтруулсан шүүгээ, галын дохиолол гал унтраах техник</p>	100%

												хэрэгслээр хангаж сан хөмрөгийн өрөөний багтаамжийг нэмэгдүүлсэн. Мөн 6 ширхэг иж бүрэн компьютероор хангаж, баримтыг цахимжуулах болон лавлагаа мэдээллээр үйлчлэх ажлыг шуурхай явуулах нөхцөлийг бүрдүүлсэн. 2024 онд төрийн архивын ажилтнуудын өрөө болон сан хөмрөгийн өрөөнүүдэд иж бүрэн засварын ажлыг хийж гүйцэтгэхэд орон нутгийн төсвөөс 91.4 сая төгрөгийг зарцуулж, засварын ажлыг бүрэн хийж баримтын хадгалалт хамгаалалтын нөхцөл сайжирсан.	
240	Архивын баримтыг цахимжуулах ажлыг эрчимжүүлэх	2021-2024	ХЭЗХ	Архивын тасаг	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Цахимжуулалтын хувь 20%	Цахимжуулалтын хувь 45%	Батлагдсан төсвийн хүрээнд	2021-2023 онд: Орон нутгийн төсөв 68.0 2024 онд Орон нутгийн төсөв 34.2	"Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн төсөвт 34.2 сая төгрөгийг тусган батлуулснаар нийт 4 гэрээт ажилтан архивын баримтыг цахимжуулах ажлыг гүйцэтгэж байна. 2021-2023 онд 62 хөмрөгийн 89 дансны 1646 хадгаламжийн нэгжийн 196364 хуудас баримтыг нягтлан шалгаж, скайнарадаж, цахим хувь үүсгэсэн. 2024 онд 4 хөмрөгийн 4 дансны 259 хадгаламжийн нэгжийн 38098 хуудас баримтыг нягтлан шалгаж, сканердаж, цахим хувь үүсгэн цахим системд холбосноос 22246 хүний нэр, 1638 байгууллагын нэр, 1907 газар зүйн нэр, 5773 заалтыг E-Document.gov.mn программд холбож, мэдээллийн сан үүсгэн лавлагаанд ашигласнаар иргэдэд чирэгдэлгүй түргэн шуурхай үйлчилж байна. Төрийн Архивын цахимжуулалтын ажлын гүйцэтгэл 42%-тай явагдаж байна.	93.3%	
241	Архивд хадгалагдаж буй баримтыг сэргээн засварлах лаборатори байгуулах	2022	ХЭЗХ	Архивын тасаг	Орон нутгийн төсөв	5.0	-	-	-	2021-2023 онд орон нутгийн төсөв 18.0 2024 онд Орон нутгийн төсөв 5.0	Архивын баримтыг сэргээн засварлах лаборатори байгуулахад шаардагдах тоног төхөөрөмжөөр хангахад зориулж 5.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгаж батлуулсны дагуу зориулалтын ширээ, багаж хэрэгслээр хангагдсан. 2021-2024 онд нийт 3757 хуудас баримтыг сэлбэн зассан.	100%	
242	Архивын байр барих асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх	2021-2024	ХЭЗХ	Архивын тасаг	Улсын төсөв	Батлагдсан төсвийн	-	Байрыг барих хөрөнгийг шийдвэрл	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Төрийн архив болон аймгийн ЗДТГ-ын архивын хадгаламжийн сангийн өрөөний багтаамжийг нэмэгдүүлэх зорилгоор Засаг даргын Тамгын газрын шинээр баригдсан өргөтгөлийн барилгад 138 м.кв хадгаламжийн сангийн 2	100%	

							хүрээнд		үүлсэн байна.			<p>өрөөг шинээр тохижуулан 441.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2500x900x560 хэмжээ бүхий 26 ширхэг ухаалаг нягтруулсан шүүгээ, галын дохиолол гал унтраах техник хэрэгслээр хангаж сан хөмрөгийн ерөөний багтаамжийг нэмэгдүүлсэн.</p> <p>Аймгийн хэмжээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хөрөнгө оруулалтаар үйлдвэрийн төрөлжсөн архивын зориулалтын байрыг барьж ашиглалтад оруулаад байна.</p>	
243		Архивын баримтын бүртгэлийн UF TAG систем, соронзон кодын бүртгэл, баримтын цахим ухаалаг тоолох систем нэвтрүүлэх	2022	ХЭЗХ	Архивын тасаг	Орон нутгийн төсөв	30.0	-	-	-	2021-2023 онд: Орон нутгийн төсөв 26.0	<p>Архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа байнга хадгалах баримтыг тоолох ажиллагаанд автоматжуулалт нэвтрүүлэх, баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор орон нутгийн төсвийн 26.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар зайнаас унших андройд үйлдлийн системтэй тооллогын төхөөрөмж болон тоологчийн соронзон чип худалдан авч үйл ажиллагаандаа ашигласнаар нийт 14900 хадгаламжийн нэгжийг кодлон программд холбосон.</p>	100%
244	8.3.6.Зам тээврийн осол, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, зам тээврийн осол түүнээс үүдэх хор уршгийг бууруулах ажлыг хэрэгжүүлнэ.	“Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх	2021-2024	ХЭЗХ ЦГ	БШУГ ГБХЗ ХГ	Орон нутгийн төсөв	1.003.0	-	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь 100%	Батлагдсан төсвийн хүрээнд	2021-2023 онд: Орон нутгийн төсөв 20.5 2024 онд Орон нутгийн төсөв 10.0	<p>2021 онд аймгийн ИТХ-ын өдрийн 13 дугаар тогтоолоор “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх хөтөлбөр”-ийг батлуулан 2020-2024 онд хэрэгжүүлж, хөтөлбөрийн үр дүн, гүйцэтгэлийг аймгийн ИТХ-ын Хуралдаанаар хэлэлцүүлж, хэрэгжилтийг 94.8%-ийн үнэлгээтэй дүгнүүллээ.</p> <p>Аймгийн хэмжээнд "Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх 2024-2027 хөтөлбөр"-ийг боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023оны 14/02 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Уг хөтөлбөрийн хүрээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, замын тэмдэг, тэмдэглэгээ, камерийн хяналтыг сайжруулах зорилтыг дэвшүүлэн, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх чиглэлээр 1 бүлэг 10 заалт бүхий арга хэмжээг тусган, хэрэгжүүлж байна.</p> <p>Цагдаагийн ерөнхий газраас зохион явуулсан "Мэдэгдэл", "Зам, замын байгууламж", "Тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал", "Мотоцикль ба хамгаалах малгай",</p>	100%

											<p>"Жолооны ард утсаа, хамгаалах бүс", "Шугаман эргүүл хар бүс" зэрэг нэгдсэн арга хэмжээнүүдийн хүрээнд хариуцсан нутаг дэвсгэртээ зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Замын цагдаагийн тасгийн алба хаагчдын хяналт шалгалтыг эрчимжүүлэн ажилласан. Хотын захирагчийн албатай хамтран "Цагаан шонхорын жигүүр" НҮТББ-аар аймгийн нутаг дэвсгэрийн замын онцлог, уулзвар гарцууд дээр гэрэлт тэмдэглэгээ хийлгэх, гэрэл дохио шинээр байрлуулах, уулзвар гарц шинээр хийлгэх зэрэг ажлын судалгааг хийлгэж зөвлөх үйлчилгээг авч ажилласан.</p> <p>Мөн Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн төвийн хэсэгт дугуйн зам хийхэд 1.0 тэрбум, авто замын цэвэрлэгээний тусгай зориулалтын 3 ширхэг техник хэрэгсэл худалдан авахад 405.0 сая төгрөгийг тус тус орон нутгийн төсөвт тусган, дээрх ажлуудын гүйцэтгэгчийг шалгаруулан тоног төхөөрөмжийг хүлээн авч Хот тохижуулах газар авто зам засвар, арчилгаанд ашиглаж байна.</p> <p>Монгол Улсын Их хурлаас 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн баталсан "Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай", "Зөрчлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулиудад орсон өөрчлөлт, зохицуулалтыг иргэд олон нийтэд сурталчилж ажилласан. Иргэдээс цахим хэлбэрээр авто замын зорчих болон зогсох хэсэг зөрчсөн фото зураг ирүүлсэн зөрчлийн дагуу 154 жолоочид Зөрчлийн тухай хуулийн холбогдох зүйл заалтаар арга хэмжээ тооцож ажилласан.</p>		
245	8.3.7.Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ үйлчилгээг сайжруулна.	Архидан согтуурахтай тэмцэх, хяналт тавих, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх	2021-2024	ХЭЭХ ЦГ	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	27.0	Гэмт хэргийн тоо 197	Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн бууралтын хувь 5%	8.0	2021-2023 онд: Орон нутгийн төсөв 9.0 2024 онд Орон нутгийн төсөв 6.0	Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр өдөр бүр гудамж талбай, олон нийтийн газруудад хөдөлгөөнт болон явган эргүүлийн тогтмол ажиллуулж, хяналт тавин ажиллаж байна. "Цахим-Архи худалдаа" тусгай арга хэмжээний хүрээнд хэсгийн байцаагч нар багийн ажлын албатай хамтран иргэд, олон нийтэд Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг сурталчлан, иргэд олноор цуглардаг аж ахуй нэгж, зах худалдааны төвүүдэд 100 ширхэг	50%

											<p>зурагт хуудас байршуулан ажилласан. Аймгийн Татварын хэлтсийн 11 байцаагчийн хамт 23 хэсгийн байцаагч архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг 526 аж ахуй нэгжид үзлэг шалгалт хийж, 174 аж ахуй нэгжээс татварын хуурамч ацтай 8257 шил архийг хураан авч, Эрүүгийн Цагдаагийн тасаг шалгаж байна. Архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг аж ахуй нэгжид хямд үнэтэй, чанарын шаардлага хангахгүй архи, согтууруулах ундаа худалдан борлуулахгүй байх чиглэлээр яриа таниулга хийж, зөвлөмж тараан ажилласан. Дүн шинжилгээ, судалгааны багаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчил ихээр бүртгэгддэг багуудыг Цагдаагийн газрын тасгуудад хуваарилан өгч, нэгдсэн эргүүл шалгалтаар ажиллаж, гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэн ажиллаж байна. Байнгын архи согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэдэг 85 гэр бүлийн судалгааг гаргаж архины албадан эмчилгээнд хамруулах ажлыг төлөвлөн, архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр 5 удаагийн сургалт зохион байгуулж 175 иргэнийг хамруулсан. Орхон аймгийн Цагдаагийн газар пэйж хуудсанд хуурамч, гарал үүсэл нь тодорхойгүй архи согтууруулах ундаа хилээр орж ирж байгаа, цахим орчинд архи согтууруулах ундаа худалдах, худалдан авахгүй байх чиглэлээр 3 шторкийг байршуулж, 194 лайк, 63 коммент, 4200 шэйр хийн иргэд, олон нийтэд түгээн ажилласан.</p> <p>Тайлант хугацаанд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 47.3 хувиар өссөн. Энэ нь 2024 оноос Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт орж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийг гэмт хэрэгт тооцдог болсонтой холбоотой байна.</p> <p>Тайлант хугацаанд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 277 бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 47.3 хувиар өссөн.</p>	
246	Архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ үйлчилгээг сайжруулах, албадан эмчилгээнд	2021-2024	ХЭЗХ ЦГ	ЭМГ Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	15.0	Хамрагдсан хүний тоо 20	Шаардлагатай иргэдийг эмчилгээнд хамруулах	5.0	2021-2023 онд Орон нутгийн төсөв 43.0 2024 онд	Орон нутгийн төсвөөс нийгэмшүүлэх арга хэмжээний зардалд 20.0 сая төгрөгийг шийдвэрлэн, орон гэргүй тэнэмэл байдлаар амьдардаг, гудамж талбай, ахуй хүрээнд байнга архидан согтуурч зөрчил үйлддэг 44 иргэний судалгааг хэсгийн байцаагч нараар гаргуулан авч Баян-Өндөр сумын ЗДТГ, Хөдөлмөр,	100%



		хамруулах ажлыг зохион байгуулах								Орон нутгийн төсөв 20.0	<p>халамжийн үйлчилгээний газар, Цагдаагийн газар хамтарч "Хамтдаа тэмүүлэх, гэрэлт ирээдүй" НҮТББ-ын нийгэмшүүлэх байранд хүйтний улиралд буюу 2023 оны 11 дүгээр сараас 2024 оны 2 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл орон гэргүй тэнэмэл 30 иргэнийг байршуулж, нийгэмшүүлэх үйлчилгээнд хамруулан гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй иргэдэд Цагдаагийн газраас хяналт тавьж, гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж өгч, яриа таниулга хийн архи дан согтуурахтай тэмцэх чиглэлээр 3 удаагийн сургалт зохион байгуулсан.</p> <p>Үйлчилгээнд хамрагдсан иргэдээс 5 иргэнийг хөдөлмөрт зуучилж, мод үржүүлгийн ажил эрхэлж байна.</p> <p>Мөн архинд донтох эмгэгтэй, архины архаг хэрэглээтэй иргэдийг албадан эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулахад 6.0 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсөвт тусган батлуулж, архи, согтууруулах ундаа байнга хэрэглэдэг 2 иргэнийг Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Сэтгэц наркологиин төвтэй хамтран архины сайн дурын эмчилгээнд хамруулан, байнгын архи согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэдэг 82 гэр бүлийн судалгааг гаргаж 2024 оны 12 дугаар сард архины албадан эмчилгээнд хамруулахаар төлөвлөөд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийгэмшүүлэх үйлчилгээнд хамрагдсан архины архаг хэрэглээтэй иргэд 2 иргэнээр буюу 7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p>	
247	8.3.8.Хууль сахиулах байгууллагуудын хүний нөөц, техник тоног төхөөрөмжийг сайжруулах замаар иргэдэд чирэгдэлгүй шуурхай үйлчлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	Хуулийн байгууллагуудын хүний нөөц, техник тоног төхөөрөмжийг сайжруулах ажлыг дэс дараатай хэрэгжүүлэх	2021-2024	ХЭЗХ	ЦГ ШШГГ ШША УБХ МШУТ	Орон нутгийн төсөв	1.864.0	-	Шаардлаг атай техник тоног төхөөрөм жөөр хангагдса н байна.	2021-2023 онд Орон нутгийн төсөв 2969.7 2024 онд орон нутгийн төсөв 1582.9	<p>2021-2023 онд хуулийн байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж нийт 2969.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар техник, тоног төхөөрөмжийг олгосон.</p> <p>2024 онд хуулийн байгууллагуудын хүний нөөцийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр орон нутгийн төсвөөс нийт 541.8 сая төгрөгийн санхүүжилтээр Цагдаагийн газарт 40 олон нийтийн цагдаа, Улсын бүртгэлийн хэлтэст 4, Архивын тасагт 2 гэрээт ажилтан тус тус ажиллуулж байна.</p> <p>Техник, тоног төхөөрөмжийг сайжруулах чиглэлээр Мэдээлэл шуурхай удирдлагын төвд 50.0 сая, Тагнуулын газарт ухаалаг самбар,</p>	100%

												тоног төхөөрөмж худалдан авахад 200.0 сая, Шүүхийн Тамгын газарт компьютер, тоног төхөөрөмж худалдан авахад 100.0 сая, Цагдаагийн газарт хөдөлгөөнт эргүүлийн авто машин худалдан авахад 440.0 сая, ШШГГ-т камер, тоног төхөөрөмж авахад 112,0 сая, Архивын тасагт сан хөмрөгийн өрөөнүүдэд засвар хийхэд 94.1 сая, техник тоног төхөөрөмжөөр хангахад 10.0 сая, байнга хадгалах баримтыг сэргээн засварлахад 5,0 сая төгрөгийг тусган нийт 1552.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэн. Ингэснээр хууль сахиулах байгууллагуудын хүний нөөц, техник тоног төхөөрөмж сайжирч иргэдэд чирэгдэлгүй шуурхай үйлчлэх нөхцөл бүрдсэн.	
БАТЛАН ХАМГААЛАХ, ГАМШГААС ХАМГААЛАХ													
248	8.4.Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэх, Батлан хамгаалах чадварыг дээшлүүлнэ.	Орон нутгийн хамгаалалтын сургалтын тогтолцоог, бэхжүүлж, томилгоот нэгжийн бэлтгэлжилтийг хангах, нөөцийг үе шаттайгаар бүрдүүлэх	2021-2024	Цэргийн штаб	Сумдын ЗДТГ Хүчний байгууллагууд	Орон нутгийн төсөв	16.2	Томилгоот бүрэлдэхү үний 0%	Томилгоот бүрэлдэхү үний 25%	5.5	2021-2023 онд Орон нутгийн төсөв 16.2 2024 онд Орон нутгийн төсөв 82.0	Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүний онолын сургалтыг жил бүр зохион байгуулж байна. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн сургалтыг цугларалт хэлбэрээр 3 удаа, хээрийн дадлага хэлбэрээр 1 удаа зохион байгуулсан. Батлан хамгаалахын сайдын 2024 оны А/110 дугаар тушаал, Батлан хамгаалах зарим чиг үүргийг Орхон аймагт төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээний 4.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2024 оны А/341 дүгээр захирамжийн дагуу орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн "Хээрийн дадлага" сургалтыг аймагт анх удаа 3 үе шаттайгаар 4 томилгоот нэгжийн сургалтыг зохион байгуулж, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн удирдлага болон бие бүрэлдэхүүн томилгоот албан тушаалын үүрэгт нь сурган дадлагуулах, үүрэг гүйцэтгэх бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлийг хангах, онц болон дайны байдлын үед үүргээ алдаагүй биелүүлэх ур чадвар олгох, бататгах бүрэлдэхүүний дадлага, чадварыг дээшлүүлэхэд чиглэн ажилласан. Мөн томилгоот нэгжийн нөөцийг үе шаттайгаар зохион байгуулж байна. Орон нутгийн хамгаалалтын сургалтыг тайлант жилүүдэд 100 хувь биелүүлсэн.	100%
249		Эх оронч үзэл хүмүүжлийн үндэс байх, бодлогыг хэрэгжүүлж иргэн	2021-2024	Цэргийн штаб БШУГ	БШУГ аймагдахь МЦНХ	Орон нутгийн төсөв	186.0	Үндэсний хөтөлбөрийн	Үндэсний хөтөлбөрийн	40.0	2021-2023 онд Орон нутгийн	Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газраас баталсан "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр",	100%

		цэргийн харилцааг бэхжүүлж иргэдэд цэргийн боловсрол олгох			-ны салбар			хэрэгжилт 5%	хэрэгжилт 25%		төсөв 186.0 2024 онд Орон нутгийн төсөв 40.0	Их эзэн Чингис хаан мэндэлсний 860 жилийн ойн хүрээнд хүүхэд, залуучуудад тусгаар тогтнол, үндэсний эрх, эрх чөлөөний үнэ цэнийг ойлгуулах, эх орноороо болон Монгол хүн болж төрснөөрөө бахархах, эх байгаль, түүх соёлоо хайрлан хамгаалах ухамсартай, эх оронч иргэнийг төлөвшүүлэх зорилго бүхий “Бидний бахархал” хөтөлбөрийн хүрээнд олон талт арга хэмжээг зохион явуулж байна. Үүнд: 2021-2024 онд Монгол цэргийн өдөр, Олон улсын энхийг сахиулагчдын өдөр, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол Улсын төрийн далбааны өдөр, Олон улсын ахмадын баярын өдөр, Монгол бахархлын өдөр, Бүгд найрамдах улс тунхагласны өдөр, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр, нээлтэй хаалганы өдөр гэх мэт тэмдэглэлт өдрүүдэд аймаг, орон нутагт Батлан хамгаалах хууль тогтоомж сурталчлах, иргэн цэргийн харилцаа, бэхжүүлэх, хүүхэд залуучуудад цэрэг эх орон үзэл төлөвшүүлэх зэрэг 32 удаагийн арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 63140 мянган иргэнд мэдээлэл хүргэн, нийт хүн амын 60 хувьд сурталчилсан. “Бидний бахархал” үндэсний хөтөлбөр 96 хувийн хэрэгжилттэй амжилттай хэрэгжсэн.	
250	8.5.Дайчилгааны төлөвлөгөөг боловсронгуй болгон, дайчилгааны бэлтгэл нөөцийн бие бүрэлдэхүүний тоо чанарыг нэмэгдүүлнэ.	Дайчилгааны төлөвлөгөөг өнөөгийн нийгэмд эдийн засгийн нөхцөлд тулгуурлан шинэчлэн дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний тоо сургалтын тогтолцоог боловсронгуй болгох, бие бүрэлдэхүүний тоо, чанар материаллаг баазыг сайжруулах	2021-2024	ЗХЖ Ш, Цэргийн штаб	Аймгийн ЗДТГ Цэргийн штаб Зэвсэгт хүчний 186 дугаар анги	Улсын болон орон нутгийн төсөв	86.6	Дайчилгааны бэлтгэл нөөц 20%	Дайчилгааны бэлтгэл нөөц 20%	25.8	2021-2023 онд Орон нутгийн төсөв 86.6 2024 онд Орон нутгийн төсөв 25.8	Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын стратегийн удирдамж, Зэвсэгт хүчний Жанжин штабаас ирүүлсэн мн/270, мн/418 тоот дайчилгааны даалгавар, Цэргийн дайчилгааны заавар, “Зэвсэгт хүчний анги, самбарыг дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө”, “Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө”-ний дагуу жил бүрийн II, IV улиралд тодотголыг Зэвсэгт хүчний 110, 186 дугаар ангиудтай хийж, акт нотломжийг Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлэн үр дүнг тооцон ажиллаж байна. Дайчилгааны бэлтгэл нөөцийн I, II дугаар зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтуудыг Зэвсэгт хүчний 110, 186 дугаар ангиудын сургалтын материаллаг баазыг түшиглэн Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалын дагуу тогтмол зохион байгуулснаар бэлтгэл нөөц 20 хувиар өссөн байна. Улсын дайчилгааны төлөвлөгөө батлагдахтай холбогдуулан аймгийн	100%

											дайчилгааны төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдон ажиллаж Дайчилгааны төлөвлөгөөг батлуулсан.		
251	8.6.Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг чадавхжуулах, орчин нөхцөлийг бүрдүүлнэ.	Орон нутгийн хэмжээнд тохиолдож болох гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг чадавхжуулах зорилгоор үе шаттайгаар сургалтуудыг зохион явуулах, шаардлагатай хүн хүч техникийн нөөц бүрдүүлэх	2021-2024	ОБГ	Аймгийн Онцгой комиссын бүрэлдэхүүн	Орон нутгийн төсөв	100.0	Гамшиг осолд ажиллах хүн хүч техник хэрэгслийн бэлтгэл бэлэн байдал хангах	Аймгийн гамшгаас хамгаалах алба мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний иж бүрэн шалгалт зохион байгуулах	35.0	2021-2023 онд Орон нутгийн төсөв 103.0	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1, 13.2.4, 13.2.5, 13.2.6 дахь заалт, Монгол Улсын Шадар сайд, Орхон аймгийн Засаг даргатай хамтран ажиллах 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн ШС-22/012 дугаар гэрээний 3 дугаар заалтын 3.3, 3.6 дахь зүйлийн хэрэгжилт, Орхон аймгийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний гамшгийн үед үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангах, чадавхыг нэмэгдүүлэх, сургаж дадлагажуулах зорилгоор Орхон аймгийн засаг даргын 2022 оны А/610 дугаар захирамжаар 68.0 сая төгрөгийн зардлыг батлуулан Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг 2022 онд 6 үе шаттайгаар зохион байгуулж "Дүүрэн хангалттай" гэсэн үнэлгээ авч ажилласан. 2023 онд Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний газар хөдлөлтийн гамшгийн үед удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, хохирол багатай даван туулах, гамшгийн үеийн хариу арга хэмжээг зохион байгуулах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны онолын мэдлэгийг олгож, дадлагажуулах команд штабын сургуулийг зохион байгуулж нийт 34 ажилтан, алба хаагч хамрагдсан. Стратегийн команд штабын сургуулийг Газар хөдлөлтийн гамшиг тохиолдож "онц байдал" тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа сэдвээр зохион байгуулж, гамшгаас хамгаалах 12 алба, 22 мэргэжлийн ангийн 680 албан хаагчийн аранз, хувийн бэлтгэлийг 1 удаа яаралтай цуглах дохиогоор ажиллуулан шалгаж, 132 удирдах албан тушаалтныг гамшгийн үеийн цагийн байдалд ажиллуулсан. Аймгийн хэмжээнд гамшгийн зарлан мэдээлэх дуут дохиогоор 32700 хүн оролцож ажилласан. 2024 онд аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор сум, баг, хорооны гамшгаас хамгаалах орон тооны бус штабтай хамтран гэр хорооллын 12340 айл өрхүүдэд аюул осол, гал түймрийн аюулаас урьдчилан	100%

											сэргийлэх нэгдсэн арга хэмжээг давхардсан тоогоор 29 удаа зохион байгуулж 53630 иргэнд аюулт үзэгдэл, осол, гал түймэр, газар хөдлөлт, үер усны ослоос урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгаа хийж ажилласан. Гал түймэр, газар хөдлөлт, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, шторкийг орон нутгийн телевизээр болон лед дэлгэцээр 780 удаа гаргаж 28 удаа ярилцлага өгч, ОБЕГ-ын вэб сайт болон цахимаар 356, цаг агаар, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан фэйсбүүк бүлгэмүүд, и-оффис системээр урьдчилан сэргийлэх мэдээ шторкуудыг байршуулан ажиллалаа. Гамшгаас хамгаалах ерөнхий зориулалтын мэргэжлийн анги буюу Жаргалант сумын бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдлыг шалгах үйл ажиллагааг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.	
	<b>Нийт дүн</b>										<b>94.2%</b>	

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗАР  
--oOo--